

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН  
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ  
КАНАД УЛСЫН ТОРОНТОГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**GOBI-STEPPE  
NEOLITHIC PROJECT**



**ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА ТӨСӨЛ: СҮХБААТАР  
АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ЗАРАА УУЛ, ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ  
СУМЫН ТАМСАГБУЛАГТ 2022 ОНД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улсын бүртгэлийн  
дугаар.....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүтэн  
ангилалын код

Төсөл хэрэгжүүлэх гэрээний  
дугаар:

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН  
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ СУРГУУЛЬ  
КАНАД УЛСЫН ТОРОНТОГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА ТӨСӨЛ: СҮХБААТАР  
АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ СУМЫН ЗАРАА УУЛ, ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ  
СУМЫН ТАМСАГБУЛАГТ 2022 ОНД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН МАЛТЛАГА  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Төслийн гүйцэтгэгч: Д.Одсүрэн (доктор Ph.D)  
Л.Яанз (доктор Ph.D)  
М.Адъяасүрэн (магистр)  
М.Сугар-Эрдэнэ (магистрант)  
Б.Дашзэвэг (магистрант)

Санхүүжүүлэгч байгууллага: Канад улсын Торонтогийн Их Сургууль

Тайлан өмчлөгч: МУБИС-ийн НХУС. Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, VIII хороо,  
Бага тойруу – 14, Монгол Улс – 210648.  
Утас: 77773443

**Улаанбаатар  
2022**

## ГАРЧИГ

УДИРТГАЛ	5
1. МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН, ЗҮҮН ӨМНӨД НУТАГТ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛ СУДАЛСАН ТОЙМ	8
2. АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА	16
2.1. Археологийн судалгааны арга зүй	16
2.2. Оцон цохионы палеолитын сууринд хийсэн малтлага судалгаа	19
2.3. Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринд хийсэн малтлага судалгаа	34
3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН	56
4. НОМ ЗҮЙ	4
6. ХАВСРАЛТ	
Хавсралт 1. Археологийн судалгаа хийх зөвшөөрлын хуулбар	65
Хавсралт 2. Албан томилолтын хуулбар	66
Хавсралт 3. Судалгааны ажлын удирдамжийн хуулбар	67

## Зургийн тайлбар

Зураг 1. Оцон цохионы дурсгалт газрын өндөршлийн зураглал	19
Зураг 2. Оцон цохионы палеолитын суурингийн малтлага	20
Зураг 3. Оцон цохионы сууринд 2018 онд хийсэн малтлагын дэвсгэр ба хөндлөн зүсэлтийн зураглал	20
Зураг 4. 2018, 2021 оны малтлага	21
Зураг 5. Малтлагын 1-р давхаргаас яс, чулуун зэвсэг илэрсэн байдал	23
Зураг 6. А4, А3 өргийн заагаас гарсан адууны эрүү, эрүүний хооронд тавьсан ялтас	23
Зураг 7. 1 – бэлдэц, 2 – таргил үлдэц	24
Зураг 8. 1 – зэрэгцээ цуулалтад үлдэц; 2 – бичил цуулалтат үлдэц	26
Зураг 9. 1, 2 – хусуур, 3, 4 – ялтас	27
Зураг 10. 1, 2 – леваллуагийн залтас	28
Зураг 11. 1 – 3 бүтэн ялтас, 4, 5 – ялтасны дээд хэсгийн хугархай	30
Зураг 12. Малтлагын доод хэсгээс илрүүлсэн чулуун зэвсэг, амьтны яс	32
Зураг 13. Малтлагын доод талаас гарсан цайвар шаварлаг хөрс	33
Зураг 14. Тамсагбулагийн дурсгалт газарт хийж буй малтлага судалгаа	34
Зураг 15. 2022 оны малтлагын эхлэл. С0 өрөг	35
Зураг 16. С0 өргийн 2b үе. Галын ором, цайвар шаргал өнгөтэй шавран судал илэрсэн байдал	38
Зураг 17. 1 – ялтасны хугархай, 2 – нэлээд өргөн ясан зүүний дээд хэсэг, 3 – цоолтуур, 4 – ялтсан зэв, 5 – хоёр талт зэв	40

Зураг 18.	1 – ясан сүлбээрийн үзүүр, 2 – зурчсан оромтой яс	41
Зураг 19.	C0 өргөөс илрүүлсэн нохойн яс	43
Зураг 20.	Малтлагыг зүүн тийш тэлсэн байдал	44
Зураг 21.	C. – 1, D. – 1 өргөөс илрүүлсэн шатаасан шавар эвлэл	46
Зураг 22.	Малтлагын талбайн зүүн хэсэг сунгасан – 1 өргийн малтлага.	47
Зураг 23.	Ясан зүү	49
Зураг 24.	Малтлагын талбайн зүүн хэсэгт хар хөрсний зааг ялгарч мэдэгдэж буй нь	51
Зураг 25.	Тамсагбулаг 13 дурсгалын дэвсгэр зураг	52
Зураг 26.	ТВ13 малтлага ба илэрсэн олдвор	53

### Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1.	Оцон цохионы малтлагаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйлийн ангилал	22
Хүснэгт 2.	Оцон цохионы малтлагаас илрүүлсэн үлдцийн төрөл зүйлийн ангилал	27
Хүснэгт 3.	Оцон цохионы малтлагаас илрүүлсэн багаж зэвсгийн төрөл зүйлийн ангилал	29
Хүснэгт 3.1	Оцон цохионы малтлагаас илрүүлсэн цуулдасны үйлдвэрлэлийн төрөл зүйлийн ангилал	31
Хүснэгт 4.	C0 өргийн 1-р давхаргаас илрүүлсэн олдворын жагсаалт	36
Хүснэгт 5.	C0 өргийн 2-р үеэс илрүүлсэн олдворын жагсаалт	36
Хүснэгт 6.	C0 өргийн 2b үеэс илрүүлсэн олдворын жагсаалт	37
Хүснэгт 7.	C0 өргийн 2c үеэс илрүүлсэн олдворын жагсаалт	38
Хүснэгт 8.	C0 өргийн 2c floor үеэс илрүүлсэн олдворын жагсаалт	42
Хүснэгт 9.	C. – 1 өргийн 1, 2-р давхаргын дээд үеийн олдворын жагсаалт	43
Хүснэгт 10.	C. – 1 өргийн 2b үеийн олдворын жагсаалт	45
Хүснэгт 11.	D. – 1 өргийн 2b үеийн олдворын жагсаалт	45
Хүснэгт 12.	B. – 1 өргийн 1-р давхаргын олдворын жагсаалт	47
Хүснэгт 13.	B. – 1 өргийн 2-р давхаргын олдворын жагсаалт	48
Хүснэгт 14.	A. – 1 өргийн 1-р давхаргын олдворын жагсаалт	48
Хүснэгт 15.	A. – 1 өргийн 2-р үеийн олдворын жагсаалт	50
Хүснэгт 16.	A. – 1 өргийн 2b-р үеийн олдворын жагсаалт	50
Хүснэгт 17.	A0 өргийн хөрсөн дээрх олдворын жагсаалт	51
Хүснэгт 18.	A0 өргийн хөрсөн 1-р үеийн дээрх олдворын жагсаалт	52
Хүснэгт 19.	A0 өргийн хөрсөн 2-р үеийн дээрх олдворын жагсаалт	54

## УДИРТГАЛ

Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн судалгаа” төслийн баг сүүлийн хэдэн жилийн хугацаанд Монгол орны зүүн өмнөд, зүүн бүс нутагт археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг гүйцэтгэж байгаа юм.

2022 оны хээрийн судалгааны улиралд өмнөх жилүүдийн судалгааг үргэлжлүүлэн Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын Оцон цохионы палеолитын дурсгалт газар, Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн дурсгалт газарт малтлага судалгааг хийж гүйцэтгэв.

Монгол орны зүүн өмнөд талын говь, хээрийн бүсэд өмнө нь палеолитын дурсгалын судалгаа харьцангуй цөөн хийгдсэн юм. Тиймээс тухайн бүс нутгийн палеолитын дурсгалын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагаа, он цаг, соёлын хамаарлын асуудалд анхаарал хандуулж, палеолитын үеийн дурсгалт газар илрүүлэх, соёлт давхаргатай дурсгал байгаа, эсэхийг тогтоох, энэ үеийн түүхийг шинэ баримт хэрэглэгдэхүүнээр баяжуулах нь манай судалгааны нэг зорилго юм.

Энэ хүрээнд төслийн багийн судлаачид 2017 оноос хойш хэд хэдэн шинэ дурсгалыг илрүүлсэн бөгөөд суурин судалгаа хийж буй Зараа уулын Оцон цохио, Зүүн шовхын палеолитын сууринд бага хэмжээтэй сорилын малтлагыг 2017-2018 онд гүйцэтгэсэн юм.

Зараа уулын Оцон цохионы сууринд 2018 онд 4 м<sup>2</sup> талбайд малтлага хийхэд чулуун зэвсгийн олдворын хамт олон тооны амьтны яс, гоёл чимэглэлийн зүйл хадгалагдсан соёлт давхаргатай дурсгал болохыг тогтоосон. Малтлагаас илрүүлсэн археозоологийн хэрэглэгдэхүүнийг нарийвчлан судлах явцад улаан буга, цөөвөр чоно, савагт хирс зэрэг тухайн бүс нутагт эрт үед амьдарч байгаад устаж мөхсөн, урьд өмнө нь илэрч байгаагүй амьтны төрөл зүйл болох нь тогтоогдсон юм. Түүнчлэн, адуу, зээр, үхэр зэрэг амьтны яс ч олон гарсан. Чулуун зэвсгийн олдворын үйлдвэрлэлд ялтсан цуулалтын арга ажиллагаа давамгайлах боловч малтлагаас болон газрын хөрсөн дээр ил тархсан олдворын дотор леваллуагийн арга барилт эдлэлүүд нэлээд олон гарсан нь сонирхол татаж байв.

Тиймээс бид Зараа уулын Оцон цохионы суурингийн өмнөх малтлагыг тэлж, шинэ эх хэрэглэгдэхүүн бий болгох зорилготой судалгааг хийж гүйцэтгэсний зэрэгцээ тухайн дурсгалт газрын байршлын зураглалыг хийв.

Хамтарсан төслийн судалгааны нэг чухал талбар бол Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн суурин юм. Төв Азийн өргөн уудам орон зайг эзлэн орших Монгол орны нутаг дэвсгэрт мал аж ахуйг хэзээнээс эрхлэх болсон, тариалангийн үйл ямар нэг хэмжээгээр байсан эсэх зэрэг өнөөг хүртэл бүрхэг буй асуултуудад хариулт хайсан судалгааг бид Тамсагбулагийн дурсгалт газарт хийж байгаа юм.

Тамсагбулагийн сууринг анх XX зууны эхэн үеийн Монголын томоохон сэхээтний нэг Дэмчигийн Буддарь илрүүлж сургуулийн сурагчдын хамт ирж олдвор түүвэрлэдэг байсан гэх ба түүний шавь нар 1940-өөд оны үед энэ нутгаар чулуун зэвсгийн хайгуул судалгааг зохион байгуулсан Зөвлөлтийн нэрт археологич, академич А.П.Окладниковт зааж өгсөн байна. Тэрээр хожим 1967 онд Монгол судлаач Д.Доржийн хамт 3 сууц малтан судалж орос, монгол хэл дээр өгүүлэл хэвлүүлсэн байдаг.

Үүнээс хойш 1998 онд Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Гүнчинсүрэн, Францын археологич М.Сефрайдес нар бага хэмжээний судалгаа хийж, хөрсний давхаргаас дээж авч он цагийг нь тогтоожээ. 2011, 2012 онуудад Японы археологич Х.Обата Монголын судлаачидтай хамтран судалгааны ажил эхлүүлсэн боловч бүрэн дуусгалгүй зогсжээ.

Монгол-Оросын хамтарсан судалгааны ангиас хойш 2 ч удаа хээрийн судалгааг зохион байгуулсан боловч бидний дээр дурдсан олон асуутын хариу бүрхэг байна. Харин лабораторийн түвшинд тухайн дурсгалын он цагийн хамраалыг зөв тодорхойлсон нь ололт байсан юм.

Хамтарсан төслийн хүрээнд 2018 оноос Тамсагбулагт судалгааны ажил эхлүүлж, тухайн жилд 9 газарт малталга судалгааг гүйцэтгэсэн бөгөөд Тамсагбулаг 1-9 хэмээн тэмдэглэсэн. Эдгээрийн ТВ 01, 02, 09 том хэмжээтэй малтлага байсан бол Тамсагбулаг 3-8 нь 1 x 1, 1 x 2 м хэмжээтэй сорилын малтлага болно.

2021 онд хамтарсан төслийн баг Тамсагбулагийн суурингийн 4 хэсэгт малтлага судалгааны ажил гүйцэтгэсэн бөгөөд судалгааны баримтжуулалтад ТВ 12, 13

хэмээн тэмдэглэгдсэн дурсгал тухайн газрын мөстлөгийн дараах үеийн хүмүүсийн гал голомтын ор бүхий оромж сууцны үлдэгдэл болох нь тодорхой болсон юм. Тухайн жилд ТВ 13 дурсгалаас шонгийн нүхний ором, дагтаршуулж хатууруулсан шалны хэсэг илрүүлсэн нь хагас газар сууц болохыг илтгэж байв. Харин цаг хугацааны боломжоос шалтгаалан бүрэн хэмжээгээр малтаж амжаагүй юм.

Тиймээс 2022 оны хээрийн судалгааны улиралд ТВ 13 дурсгалын малтлагыг дуусгаж, сууцны бүтцийг тодорхойлох, хүн амьдарч байсан хэсгээс хөрсний дэж авч дараагийн лабораторийн олон талт шинжилгээний эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэхийг зорьсон болно.

Судалгааны ангийн бүрэлдэхүүнд МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D) Д.Одсүрэн, Канад улсын Торонтогийн Их сургуулийн судлаач, доктор (Ph.D), профессор Л.Яанз, Канадын МкМастерийн Их Сургуулийн докторант М.Адъяасүрэн, МУИС-ийн Археологийн төвийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батдалай, Их Британийн Дурхэмийн Их Сургуулийн докторант Зе Ма, МУБИС-ийн Түүхийн салбарын оюутан М.Сугар-Эрдэнэ, Э.Донойдугар, Г.Оргилболд, О.Дөлгөөнмөрөн, МУИС-ийн Археологийн тэнхимийн магистрант Б.Дашзэвэг, 0501 УБӨ Ландкрузер маркийн автомашины жолооч Б.Чинбат, 2210 ӨМҮ Мицүбиши Делика маркийн автомашины жолооч Д.Одхүү, тогооч Ц.Цэцэгбаяр нарын нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2022 оны 7-р сарын 14-нөөс 8-р сарын 13-ныг хүртэл ажилласан.

Энэхүү тайлан 2 хэсгээс бүрдэх бөгөөд I хэсэгт 2022 онд хийсэн археологийн судалгааны мэдээлэл, үр дүнг багтаасан болно.

Тайлангийн II хэсэг буюу Монгол тэмээний өв соёл, уламжлалын талаарх судалгааг бидэнтэй хамтран ажилладаг ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М.Алтаншагай 2023 оны 1, 2 сард хийсэн. Угсаатны зүйн судалгаагаар зэрлэг болон гэрийн мал үржил селекцид орох үйл явц, монголчуудын тэмээний соёлын асуудлыг хөндөхийг зорив. Археологийн малтлага судалгаагаар олдсон эртний үхрийн яснаас илрүүлсэн эх талаас гэрийн, эцэг талаас зэрлэг амьтны генетикийн баримтыг угсаатны зүйн үүднээс тайлбарлахыг зорьж буй бөгөөд энэ үйл явцтай хамгийн төстэй орчин үеийн баримт тэмээ, хавтгайн хоорондын үржил селекци байх магадлалтай хэмээн үзсэн юм.

## **.1. МОНГОЛ ОРНЫ ЗҮҮН, ЗҮҮН ӨМНӨД НУТАГТ ЧУЛУУН ЗЭВСГИЙН ДУРСГАЛ СУДАЛСАН ТОЙМ**

Монгол орны зүүн бүс нутагт Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн зүүн хэсгийн нутаг дэвсгэр хамаарна.

Тухайн бүс нутгийн чулуун зэвсгийн судалгаа ХХ зууны эхэн хагаст эхэлсэн бөгөөд 1933-1934 онуудад ШУХ-ийн урилгаар ажилласан Оросын судлаач Д.Д.Букиничийн тайланд Өмнөговьос Даш, Дорнодоос Буддарь нарын хүмүүс чулуун зэвсгийн олдвор цуглуулан илгээж байсан тухай тэмдэглэсэн байдаг.

1933-1934 онд Д.Д.Букинич Халхын голын сав газраар хайгуул хийж, неолитийн үеийн сонирхолтой олдворуудаас гадна палеолитийн үеийн зэвсэг багажийн зүйл цөөнгүй цуглуулжээ [Букинич, 1934].

1949 онд С.В.Киселевын удирдсан Монгол-Зөвлөлтийн түүх-этнографийн хамтарсан экспедицийн бүрэлдэхүүнд А.П.Окладниковын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги ажиллаж, Хиагтаас Улаанбаатараар дайран баруун зүг Хархорин хүртэл, зүүн тийш Хэрлэн, Халх голын сав газраар, өмнө зүгт улсын хил хүртэл хайгуул судалгаа хийсэн байна [Окладников., 1951].

Х.Пэрлээ 1951-1955 оны хооронд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Улаан-Зээг, Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутаг Хэрлэнгийн Баянцогт овоо, Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрэм, Рашаан хад зэрэг газруудаас хуучин чулуун зэвсгийн зүйлс, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутаг Гүрэмийн нуур, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг Дулааны говьд шинэ чулуун зэвсгийн дурсгал байгааг тус тус илрүүлжээ. 1954 онд газарзүйч О.Намнандорж Сүхбаатар аймгийн Урт сумын нутгийн зүүн зах Их айлын манхан болон Долир манхнаас шинэ чулуун зэвсгийн зүйлс, 1955 онд эрдэм шинжилгээний ажилтан А.Лувсандэндэв Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Дарига овоо хэмээх газраас шинэ чулуун зэвсгийн үеийн тарианы нухуур зэрэг олдвор, мөн тус сумын нутгаас эрдэм шинжилгээний ажилтан Ж.Дүгэрсүрэн шинэ чулуун зэвсгийн зүйлсийг илрүүлжээ [Доржсүрэн, 1957].

1950-1956 онуудад Монголын археологичид Ховд, Өвөрхангай, Архангай, Говь, Булган, Дорноговь аймгийн нутгуудаас илрүүлсэн хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгалт газруудын чулуун зэвсгүүд Байгал нуур, Хиагт орчмоос илрүүлсэн



палеолитийн дурсгалуудын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга барилтай ижил шинжтэй байгаад тулгуурлан Монгол оронд амьдарч байсан эртний хүмүүс хөрш зэргэлдээ Сибирийн эртний хүмүүстэй тодорхой харилцаа холбоотой байсан гэсэн дүгнэлтийг хийж байжээ [Доржсүрэн, 1957а: 4, 6]. Монголын археологичид энэ үеэс эхлэн мезолитын дурсгалуудыг ангилах оролдлогыг хийж эхэлсэн байна. Энэ үед холбогдуулан үзэж болох олдворуудыг Дундговь, Сүхбаатар аймгуудын нутгаас илрүүлэн олсон [Доржсүрэн, 1957а] бөгөөд тэдгээр нь дундаж хэмжээтэй хутган ялтас, шулуун суурьтай сумны зэв, шөвөг зэрэг зүйл байжээ.

1959 оны намар “Рашаан шинжилгээний анги” Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн хэрэм, Дархан сумын нутаг Цахарын рашаан, Чойбалсан аймгийн Цагаан-Овоо сумын нутаг Гурван рашааны дэргэдээс тус тус чулуун зэвсэг олсноос Цахарын рашааны дэргэдээс илрүүлсэн маажуур зэрэг 20 ширхэг чулуун зэвсэг тун сонирхолтой хэмээн тэмдэглэсэн байна [Намнандорж, 2003: 382-384].

1959 онд Дорноговь аймгийн Сулинхээр сумын Өлзийтөөс урагш 4.5 км-т жижиг нуураас холгүй орших толгойн хормойд геологич Г.Скворцов палеолит, неолитийн үеийн сонирхолтой зэвсгийн зүйлсийг 2 хэсэг газраас олж түүвэрлэснийг В.Е.Ларичев, В.В.Волков нар тодорхойлон нийтлүүлжээ [Ларичев и др., 1964].

1961 онд Х.Пэрлээ, Шуберт нарын удирдсан Монгол-Германы хамтарсан археологи-угсаатны зүйн шинжилгээний анги Хэнтий аймгийн нутагт судалгааны ажил хийж Онон, Балж голын эрэг хавиас палеолит, неолитийн үеийн зэвсгийн зүйлс илрүүлэн олсныг тус шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд ажилласан Германы археологич Дитрих Маниа урд өмнө цуглуулсан зарим олдворын хамт нийтэлжээ [Mania, 1963].

1967-1987 он хүртэл манай оронд Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици академич Ш.Нацагдорж, Д.Дорж, А.П.Окладников, А.П.Деревянко нарын удирдлагын дор хэд хэдэн ангийн бүрэлдэхүүнтэй ажиллажээ. Тус экспедицийн бүрэлдэхүүнд А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан чулуун зэвсгийн дурсгал судлах анги 1967-1969 онуудад Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгийн нутагт палеолитийн үеийн дурсгалаас гадна мезолит, неолитийн үеийн хэдэн арван шинэ бууц, суурин илрүүлэн Чойбалсан хотын ойролцоох Овоот, Тамсагбулаг, Хэрлэнгийн урд эрэгт неолитийн үеийн булш, сууц хэд хэдийг анх удаа малтан

шинжилжээ. Чойбалсан хотын ойролцоо Баруун Өлзийт хэмээх уулын зүүн хормойгоос “Хэрлэнгийн хүн” хэмээн нэрлэгдсэн нүүрийг нь баруун зүг харуулан зүүн хажуугаар нь хэвтүүлж, толгойг бөхийлгөн хоёр гарыг нь өвдөгний нь хооронд хавчуулан оршуулсан оршуулга илрүүлсэн бөгөөд оршуулгын зан үйл, байрлал зэрэгт тулгуурлан неолитийн үед хамааруулан үзсэн байна. Мөн Тамсагбулагт неолитийн үеийн нүхэн сууц болон 2 булшийг малтан судалсан байна [Дорж, 1969].

Тус шинжилгээний ангийн судлаачид 1969 онд Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Ярх уулын дэргэдээс гилбэр зэвсгийн соёлын дурсгал бүхий дархны газар нээсэн бөгөөд доод палеолитийн үед холбогдуулан үзжээ.

1970 онд Сүхбаатар аймгийн Хонгор сумын дэргэдэх Их-Оргио уулын хормойгоос палеолитийн үеийн цөөн тооны эдлэл түүвэрлэсний дотор леваллуа маягийн цохилтын хоёр талбайт үлдэц байжээ [Дорж., 1971].

Д.Дорж “Дорнод Монголын неолит” бүтээлдээ Дорнод аймгаас илэрсэн шинэ чулуун зэвсгийн түүхэнд холбогдох 15 сууринг авч үзэн судалгааны эргэлтэнд оруулж он цаг харилцан хамаарлын асуудлыг тогтоосноос Ямаат нуурын суурин, Баруун Өлзийт, Овоот болон Тамсагбулагийн сууц бүхий неолитийн дурсгалт дурсгалт газрууд томоохонд тооцогдоно. Тэрээр Сүхбаатар аймгийн нутгаас Онгон болон Баруун элс, Овон элс, Гүнбулаг, Эхэн усны баруун эрэг, Устай бургастай зэрэг дурсгалт газруудыг, Дорноговь аймгийн Сулинхээр сумын Сүлт хар овоо, Эрдэнэ сумын Дулааны говийн археологийн хэрэглэгдэхүүнийг уг нэгэн сэдэвт бүтээлдээ авч үзсэн байдаг. Түүний бүтээл нь Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн нутгаас олдсон неолитийн дурсгалуудыг нэлээд сайн судлагдсан хөрш зэргэлдээ орны мөн үеийн дурсгалтай харьцуулан судалж Монголын неолитийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга, түүний хөгжлийг үечлэн, улмаар тэр үеийн хүмүүсийн эрхлэх аж ахуй, нийгэм, оюун санааны хөгжлийг нэгтгэн дүгнэсэн байна. Энэ нь Монголын шинэ чулуун зэвсгийн судалгааны асуудлыг хөндсөн анхны нэгэн сэдэвт бүтээл бөгөөд чулуун зэвсгийн зангилаа асуудлуудыг тухайн үеийн олдвор хэрэглэгдэхүүний хэмжээнд бүхэлд нь авч үзэхийг зорьсон юм [Дорж, 1971].

Монгол нутгаас олдсон палеолитийн үеийн олон соёлт давхарга бүхий хоёр дахь дурсгалт газар болох Рашаан хадны сууринг Х.Пэрлээгийн удирдсан Гурван голын шинжилгээний анги 1973, 1974 онуудад малтаж эхэлсэн бөгөөд 1980 онд

А.П.Окладников, Д.Дорж, 1981 онд Р.С.Васильевский, Д.Цэвээндорж нарын удирдлагаар МЗТСХЭ-ийн палеолитийн дурсгал судлах анги үргэлжлүүлэн малтаж судалсан юм [Окладников и др., 1982].

1981 онд МЗТСХЭ-ийн чулуун зэвсэг судлалын анги Улаанбаатараас Өндөрхаан орох төв замын дагуу Хэнтийн Цэнхэрмандал сумын нутгаас дээд палеолитийн үед холбогдох үлдэц, ялтас, залтас түүвэрлэсэн байна. Үүнээс гадна Рашаан хадны баруун талд орших Ханангийн жалганаас үлдэц, хусуур зэрэг палеолитийн үед холбогдох нэлээд тооны эдлэл олжээ.

1981-1990 онд Дорнод Монголын бүс нутагт чулуун зэвсгийн судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй бөгөөд энэ нь МЗТСХЭ тус орны чулуун зэвсгийн үеийн судалгааг бүсчлэн, Алтайн нуруунаас эхлэн явуулах болсонтой холбоотой юм.

1990-1993 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” төслийн хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд оролцсон археологичид Хэнтийн нурууны салбар уулс, Хэрлэн, Онон голын сав газраас хэд хэдэн шинэ суурин газрыг илрүүлэн, олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсний нэлээд хувь нь палеолитийн үед холбогдох зэвсгийн зүйлс байжээ [Гурван гол., 1990, 1991, 1992, 1993]. Үүнд, 1990 онд Хэрлэн голын эхэн урсгалын баруун эрэг дагуу, Богдын голоос дээш Хөшийн гол, Баруун Бүрхийн голын дунд орших Намсрайн овоо (ухаа)-ны орчим, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Номгон уулын энгэрээс баргил залтас, хянгар маягийн зэвсэг, Хэрлэн голын баруун эрэг, Зүүн Байдлагийн гол, Тогос уул, Сангайн ам, Сүүжийн дэнж, Номгон толгой, Зорголын шар хад, Хустын булаг [Гурван гол., 1990] зэрэг газраас палеолитийн үед холбогдох баргил залтас, дугуй үлдэц, хусуур, үзүүр мэс, гилбэр маягийн эдлэл нэлээд хэмжээгээр олджээ.

1991 онд тус шинжилгээний ангийнхан Хэнтий аймгийн Батширээт, Биндэр сумын нутаг Онон, Хурхын голын сав газарт ажиллахдаа чулуун зэвсгийн зүйлс цуглуулснаас Батширээт сумын Ёлын байц, Биндэрийн Рашаан хад, Асгат уулын энгэр, Өглөгчийн үзүүр, Ганц модны жалга зэрэг газраас олдсон баргил хянгар, хусуур, залтсан хусуур, дугуй үлдэц зэрэг олон эдлэл нь палеолитийн үед холбогдоно [Гурвангол, 1991].

1992-1993 онд дээрх шинжилгээний анги Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Хэрлэнбаян-Улаан, Цэнхэрмандал сумдын нутгаар хайгуул судалгааны ажил гүйцэтгэх явцдаа Хэрлэн Баян-Улаан уулын салбар Бугахайрхан, Их Хайлант, Шар хад зэрэг газраас палеолитийн үеийн чулуун зэвсгийн зүйлс нэлээд хэмжээгээр цуглуулснаас [Гурван гол., 1992,1993] гадна Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэн голын зүүн биенд орших Ханангийн энгэрийн палеолитийн дурсгалт газрыг илрүүлсэн. Уг дурсгалт газраас илрүүлсэн үзүүр мэс, хусуур, хутга хэлбэрийн зэвсэг, ирлэсэн ялтас залтас, үлдэц зэргийг боловсруулан судалгааны эргэлтэнд оруулсан юм. Тэдгээрийн ерөнхий хэв шинж цуулалтын арга барилд үндэслэн дунд палеолитийн сүүл үеэс дээд палеолитийн дунд үед холбогдуулан үзсэн [Цогтбаатар, 1994] байна. Мөн тухайн бүс нутагт хамаарах Бугахайрхан уулын орчмоос түүвэрлэсэн 130 гаруй чулуун зэвсгийн олдворт боловсруулалт хийж мустье үеэс дээд палеолитийн дунд үед хамааруулан авч үзсэн байдаг [Цогтбаатар, 1998].

1993-1995 онд Монгол-Солонгосын хамтарсан “Дорнод Монгол” төслийн хээрийн шинжилгээний ангийн судлаачид Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Сүхбаатар аймгийн Дарьганга сумдын нутгаар хайгуул болон туршилтын малтлага хийж, олон тооны чулуун зэвсэг илрүүлжээ [Монгол-Солонгосын., 3, 4].

1998 онд Монгол-Солонгосын хамтарсан “Монсол” төслийн хээрийн шинжилгээний анги Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Өглөгчийн голын эрэгт чулуун зэвсгийн малтлага судалгаа явуулж мянга гаруй олдвор илрүүлсэн байна.

1998 онд Монгол-Францын хамтарсан экспедицийн судлаачид Тамсагбулагийн сууринд судалгааны ажил хийжээ. Малтлагыг 1967-1969 онд хийсэн малтлагын өмнөд ханыг үргэлжлүүлэн зүсэлт хийх маягаар үйлдсэн байна. Чулуун зэвсгийн олдвор бүхий хөрсний дээжийг Францын Радиоактивын лабораторид он цаг тогтоох судалгаа хийлгэсэн бөгөөд НТӨ 5.590□120 (Gif-10949) мянган жилийн өмнөх үед холбогдох он цагийн хамаарлыг заажээ. Тиймээс тухайн дурсгалыг НТӨ VI мянган жилийн өмнөх үед холбогдуулан үзэх боломжтойг судлаачид тэмдэглэсэн байдаг [Гүнчинсүрэн, 2000: 9-14]

2003 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнгийн Хөдөө аралд хайгуул судалгаа явуулсан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хээрийн шинжилгээний баг

Ханзат, Бугахайрхан, Ханан зэрэг газруудаас олон тооны чулуун зэвсэг түүвэрлэсэн байна [Цогтбаатар нар, 2003].

2003 оноос Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын төвийн баруунтай орших Чандмань Хар уул орчимд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн баг археологийн авран хамгаалах судалгааны ажил хийж эхэлсэн. 2003 онд ажилласан хайгуулын баг шугаман хайгуулын аргаар тандалт хийсний үр дүнд газрын гадаргуу дээр тархсан 233 ш чулуун зэвсгийн олдворыг түүвэрлэн цуглуулсан байна. Дараа жил буюу 2004 онд хайгуул хийснээр нилээд олон газраас чулуун зэвсэг илрүүлж чулуун зэвсгийн суурингийн тоог 15 болгож, нийтдээ 2000 орчим чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэсэн байна. Түүвэрлэсэн чулуун зэвсгийн зүйлсийн дотор неолитийн үед холбогдох олон тооны бичил хусуур, ялтас, цуулдас, үлдэц, цөөн тооны шөвөг, бифас маягийн зэвсгүүд, хоёр талаас нь холтчин зассан нарийн хицтэй сумны зэв 10 гаруйг илрүүлжээ [Амартүвшин нар, 2012: 15-18]

2004 онд Монгол-Японы хамтарсан “Шинэ зуун” төслийн хээрийн шинжилгээний ажлын явцад зарим судлаачид Хэрлэнгийн Хөдөө арал орчмын чулуун зэвсгийн дурсгалт газруудтай танилцаж 10 гаруй объектоос олон тооны чулуун зэвсгийн дээж цуглуулан анхан шатны боловсруулалт хийжээ. [Izuho et al., 2005].

Мөн Монгол–Японы хамтарсан “Палеолитийн судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг 2006 оны 09-р сард Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хэрлэнбаян-Улаан уулын Ханзат хэмээх газар хөрсөн дээрээ палеолитийн дээд үеийн чулуун зэвсгийн баялаг дурсгалыг агуулсан сууринд соёлт давхарга байгаа эсэхийг тогтоох малтлагыг дөрвөн газарт явуулж нэгээс нь харьцангуй нимгэн боловч олон арван чулуун зэвсэг, амьтны ясны үлдэгдэл бүхий давхарга илрүүлэн олдворын нарийвчилсан судалгаа хийсэн байна [Izuho et al., 2007a].

2006-2008 онд Монгол–Японы хамтарсан “Палеолитийн судалгаа” хээрийн шинжилгээний ангийн судалгааны хэсэг (Т.Цурумару, Б.Цогтбаатар, Я.Такаши, Г.Лхүндэв, Я.Шино, Ф.Мики) Хэнтий аймгийн Батширээт сумын нутагт орших Рашаан хад, Өглөгчийн голын эх орчимд хайгуул болон малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэсэн юм. Судлаачид хайгуул судалгаагаар илрүүлсэн олдворууд ерөнхийдөө неолитийн үеийн шинж төрхийг агуулж байгаа боловч түүвэр

олдворуудын дотор мезолитын үед холбогдох цөөн тооны эдлэл байгааг тэмдэглэсэн байна [Цогтбаатар нар, 2010: 32-51]

Дээрх судалгааны анги 2008 оны хайгуул судалгааны хүрээнд Батширээт сумын Улаан хадны хормойгоос чулуун зэвүүд болон түүнд холбогдох бэлдэц, цуулдас зэргийг илрүүлэн олжээ. Тэдгээрийг судалгааны эргэлтэнд оруулж холбогдох он цагийг шинэ чулуун зэвсгийн сүүл үе хүрэл зэвсгийн эхэн үед хамааруулан авч үзжээ. [Цогтбаатар нар, 2010: 52-60].

Монгол-Францын хамтарсан “Монголантропус” төслийн хүрээнд 2009 оноос эхлэн Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Салхитын ам, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг Хавцгайт болон түүний эргэн тойронд буй чулуун зэвсгийн олдвор бүхий газруудад хайгуул, малтлага судалгаа хийж байна.

Монгол-Японы хамтарсан “Эртний монголчуудын палеоантропологийн судалгаа” төслийн хүрээнд Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагт неолитийн үеийн нүхэн сууц байж болохуйц газруудад малтлага судалгаа хийж байна [Цогтбаатар нар, 2012]

ШУА-ийн Археологийн хүрээлэн, Сөүлийн Их Сургуулийн Археологи, эртний урлалын тэнхимтэй хамтарсан хээрийн шинжилгээний анги 2011-2013 онуудад Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хадны сууринд малтлага судалгаа хийжээ. Малтлагаас илэрсэн зэрлэг адууны яс  $35630 \pm 180$  (IAAA-110745; 41340~40353 calBP at 95.4%), болон үхрийн яс  $35070 \pm 180$  (IAAA-110746; 40905~39436 calBP at 95.4%)-нд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнд тухайн дурсгал дээд палеолитийн эхэн үед холбогдохыг харуулж байна [Гүнчинсүрэн нар, 2012].

Монгол орны хээрийн бүс нутгийн палеолитийн үеийн нэгэн сонирхолтой дурсгал бол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ачаат уулын суурин юм. Уг дурсгалыг МУИС-ийн окутны хээрийн дадлага ажлын үеэр анх илрүүлсэн бөгөөд 2012 онд ШУА-ын Археологийн хүрээлэнгийн судлаачид чулуун зэвсгийн олдворуудын тархалтын хүрээг урьдчилсан байдлаар тодорхойлж, олдворуудын түүвэр цуглуулга хийжээ. Судлаачид тухайн дурсгалын чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хэв маяг, олдворуудын төрөл зүйлд үндэслэн мустье сүүл үеэс

дээд палеолитийн эхэн үед холбогдуулан үзсэн байна [Цогтбаатар, Пүрэвжал, 2014: 15-24].

Ачаат уулын орчимд Устай Бургастайн Барга элсний неолитийн сууринд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” төслийн хүрээнд 2008, 2009, 2011 онуудад ажиллаж олон тооны чулуун зэвсгийн зүйлс цуглуулсан байдаг [Цыденова и др., 2012].

Монгол орны зүүн бүс нутагт хийсэн чулуун зэвсгийн судалгааны эхэн үе буюу 1930-1960-аад онуудад ихэвчлэн мэдээ шалгах, цөөн тооны олдвор түүвэрлэх маягаар цаашдын судалгааны үндэс суурийг боловсруулжээ. Харин 1960-аад оноос МЗТСХЭ-ийн Чулуун зэвсэг судлах анги Зүүн Монголын бүс нутагт өргөн цар хүрээтэй хайгуул судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд илрүүлсэн ихэнх дурсгалууд шинэ чулуун зэвсгийн үед холбогдож байв. Мөн шинэ чулуун зэвсгийн үеийн нүхэн сууц, оршуулгуудыг илрүүлэн судалсан байна. Сүүлийн жилүүдэд Солонгос, Япон, Америкийн судлаачидтай хамтарсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд палеолит болон неолитийн дурсгалуудын судалгаа, палеолитоос мезолит, неолитоос төмөрлөг зэвсэгт шилжсэн шилжилтийн үеийн түүхийн асуудлуудыг тодруулах зорилготой судалгааны ажлууд хийгдэж байна.

## 2. АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА

### 2.1. Археологийн судалгааны арга зүй

Монгол орны говь, хээрийн бүс нутгийн чулуун зэвсгийн дурсгалт газрууд ихэвчлэн хөрсөн дээр үеийн олдворуудыг агуулсан ил суурин хэлбэрээр оршдог билээ. Тиймээс юуны өмнө тухайн дурсгалын хөрсөн дээр тархсан олдворуудын нягтаршил, тархалтын хүрээ заагийг тодорхойлох нь чухал юм.

Чулуун зэвсгийн олдворын тархалтын хүрээ, зааг, нягтаршилыг тодорхойлохдоо өнгийн туг ашигласан бөгөөд олдворуудын нягтшил их, төрөл зүйл олон байсан тул зөвхөн зэвсгийн чанартай хоёрдогч боловсруулалт хийгдсэн эдлэлүүд, анхдагч цуулалтыг тодорхойлох олдворууд болон онцлох цуулдасуудын дэргэд туг хатгаж тэмдэглэсэн болно. Ингэснээр олдворууд хоорондоо тодорхой зайд буюу хэсэг хэсэг газарт байрласан олдворуудын бөөгнөрлийг харах боломжтой билээ. Мөн энд нэг анхаарах зүйл бол чулуун зэвсгийн олдвор тархсан гадаргуугийн байршил зүй, гадаргын хэв шинж, хөрсжилт билээ.

Чулуун зэвсгийн олдворууд хөрсөнд дарагдах, налуу даган гулсах болон усны үйл ажиллагааны нөлөөгөөр зөөгдсөн байдгийг тооцоолох хэрэгтэй юм. Олдворууд тархсан байршлуудыг туг хатгаж тодорхойлсны дараа гэрэл зурган баримтжуулалт хийнэ. Мөн тухайн дурсгалуудын байршил зүйн ерөнхий план зургийг гаргана. Үүний дараа тухайн дурсгалт газарт соёлт давхарга байгаа эсэхийг тодорхойлох анхан шатны оролдлого хийнэ. Энэ нь хүрзэн шалгалт болон гар өрмийн тусламжтайгаар хийгдэх ба олдворууд тархсан гадаргуугийн байршил зүйг харгалзан үзнэ. Гар өрмөн шалгалт хийх цэгүүд нь хоорондоо 2-4 м зайтай байх ба өрмөөс гарсан бүх шороог шигшүүрээр шигшүүрдэж илэрсэн олдворыг өрмийн цэгийн дугаар болон гүний хамт тэмдэглэнэ. Энэ нь сорилын малтлага, цаашлаад өргөн хэмжээтэй малтлага хийх газрыг тодорхойлоход дөхөм болно. Өрмөн шалгалтын үр дүнгээс хамааран 50 x 50 см хэмжээтэй талбайд хүрзэн шалгалт хийх эсэхийг шийднэ. Хүрзэн шалгалт нь өрмөн шалгалтын мэдээг баталгаажуулах нэг хэлбэр юм.

Өрмөн болон хүрзэн шалгалтын үр дүнд хөрсний хурдас хуримтлагдаж соёлт давхарга үүссэн байх боломжит газруудыг тодорхойлсны дараа судалгааны



дараагийн шат болох малтлага судалгааг хийнэ. Чулуун зэвсгийн дурсгалт газрын судалгаанд *сорилын* болон *өргөн хэмжээний малтлагын* арга зүйг ашигладаг.

Сорилын малтлагыг 2 м<sup>2</sup> – 4 м<sup>2</sup> талбайд гүйцэтгэх ба тухайн газрын налуу, ургамалжилт зэргээс шалтгаалан чиглэлийг тодорхойлно. Малтлагыг археологийн шинжлэх ухааны малтлагын үндсэн арга зүйн дагуу хийж, гэрэл болон гар зургийн баримтжуулалт, түвшингийн тэмдэглэгээ, малтлагын тодорхойлолт, дээж авах зэргийг шаардлагад нийцүүлэн хийнэ.

Сорилын малтлагын мэдээнд тулгуурлан дараагийн том хэмжээтэй малтлагыг эхлүүлэх бөгөөд бид Тамсагбулаг 12, Тамсагбулаг 13 малтлагыг өмнөх 2018 оны сорилын малтлагын үр дүнд тулгуурлан гүйцэтгэсэн билээ. Том хэмжээтэй малтлага хийхдээ хийхдээ сонгосон талбайгаа 200 х 200 см, 250 х 250 см хэмжээтэй өргүүдэд хувааж, өрөг тус бүрээс илэрсэн олдворуудын байршил, гүнийг тэмдэглэж баримтжуулсан. Ингэхдээ том хэмжээтэй ясны олдворууд, чулуун багаж зэвсэг, анхдагч цуулалтад хамаарах эдлэл болон 2 см-ээс том хэмжээтэй олдвор, ваар савны хагархайг баримтжуулж, маш олон тоогоор илрэх цуулдасны үйлдвэрлэлд хамаарах жижиг хэлтэрхий, хагархай зэргийг малтлага хийж буй давхарга, үе, өргийн дугаараар нь тэмдэглэн авч байв. Мөн малтлагын талбайг голоор нь тэгш хэмтэй хуваасан хамар үлдээсэн нь хөрсний давхаргын зураглал хийх, дээж авахад зориулагдсан болно.

Малтлагын явц болоод олдворын байршлыг дэвсгэр зураг болон хөндлөн огтлолын зураг, дроны зураг, фото зургаар баримтжуулав.

Малтлагаас гарсан шороог 1 х 1 мм, 1 х 2 мм хэмжээтэй тор бүхий шигшүүрээр шалгав.


Тамсагбулгийн сууринд судалгаа хийхдээ тухайн дурсгалын чулуун зэвсгийн олдвор агуулсан хэсгүүдийн хооронд олдворын ялгаа бий эсэхийг тодорхойлох зорилгоор гадаргыг хэд хэдэн хэсэгт хуваасан бөгөөд малтлагын талбайг өргүүдээр дугаарлах, тэнцүү хэмжээтэй том хэсгүүдэд хуваах зэргээр баримтжуулсан. Хэмжилтийн багажийн тусламжтайгаар олдворуудын байршил, гүнийг тодорхойлохын зэрэгцээ гарсан шороо бүрийг шигшүүрээр шүүрдэж шалгасан. Мөн тэр бүр хүний нүдэнд өртөхгүй үр тарианы үлдэгдэл, органик гаралтай эд зүйл байж

болзошгүй хэсгийн хөрсийг тусгайлан бэлтгэсэн цаасан уутанд авч хөвүүлэгч машины тусламжтайгаар шалгаж байв.

Малтлагаас гарсан олдворыг хээрийн нөхцөлд болон лабораторийн нөхцөлд чулуун зэвсгийн судалгааны төрөл зүйн ангиллын дагуу боловсруулж тодорхойлолт үйлдсэн болно.

## 2.2. Оцон цохионы палеолитын сууринд хийсэн малтлага судалгаа

Говийн бүс нутгийн зүүн тал, Хятадын умард хэсэгтэй зах нийлэх Монгол орны зүүн өмнөд талын нутаг дэвсгэрт өнгөрсөн хугацаанд хуучин чулуун зэвсгийн дурсгалыг бүртгэн баримтжуулах, шинжлэн судлах ажил цөөн хийгдсэн байдаг. Тиймээс хамтарсан судалгааны хэсэг тухайн бүс нутагт хайгуул судалгааг зохион явуулахдаа хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгалд анхаарал хандуулж эхэлсэн юм. Бид хайгуулын явцад палеолитын үеийн хэд хэдэн дурсгалыг шинээр илрүүлэн баримтжуулсны зэрэгцээ суурин судалгаа хийж буй Зараа уулын Оцон цохио, Зүүн шовх зэрэг газрын палеолитын дурсгалыг бага талбайгаар малтан шинжилж, он цагийн хамаарлыг тогтоосон [Janz at al., 2021].



Зураг 1. Оцон цохионы дурсгалт газрын өндөршлийн зураглал

Энэ онд бид Зараа уулын Оцон цохионы сууринд малтлага судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Оцон цохио нь Зараа уулын өмнөд хэсэгт орших бөгөөд цавчим өндөр хадан тогтоцтой. Цохионы өвөрт хоёр талаараа гүн жалгаар хязгаарлагдсан урагш


ялимгүй хазгай багавтар дэвсэг бий. Энд хүрлийн үеийн болон он цаг тодорхойгүй булш оршуулга, чулуун байгууламж олон байна (Зураг 1, 2).

Чулуун байгууламжит дурсгалын хооронд болон жалганы ирмэг дагуу газрын хөрсөн дээр чулуун зэвсгийн олдвор нэлээд нягтаршилтай тархсан байдаг.



Зураг 2. Оцон цохионы палеолитын суурингийн малтлага

Өмнөх малтлагаар олон тооны амьтны ясны үлдэгдэл илрүүлсний дотор цөөвөр чоно, савагт хирс, улаан буга зэрэг онцлох төрөл зүйл, адуу, үхэр, жижиг биетэй өвсөн тэжээлт амьтдын яс олон байв (Зураг 3).



Зураг 3. Оцон цохионы сууринд 2018 онд хийсэн малтлагын дэвсгэр ба хөндлөн зүсэлтийн зураглал

Оцон цохионы сууринд хийсэн өмнөх малтлагаар газрын хөрсөн дээрээс болон малтлагаас цөөн боловч леваллуагийн төрхийн үлдэц, леваллуа хэв шинжийн ялтсыг илрүүлсэн юм. Бид холбогдох он цагийн хамаарал хийгээд чулуун зэвсгийн төрөл зүйл, үйлдвэрлэлийн арга барилын хувьд Монгол орны умард бүс нутгийн дурсгалаас ялгаатай байх магадлалтай хэмээн таамагласан бөгөөд илүү өргөн дэлгэр мэдээлэл бий болгох үүднээс дахин малтан судалсан юм.



Зураг 4. 2018, 2022 оны малтлага

Энэ жил Оцон цохионы өврийн урагшаа ялимгүй хазгай дэвсгийг огтолсон зүүн хойноос баруун урагш чиглэсэн жалганы ирмэг дээр 2018 онд хийсэн малтлагыг өргөсгөн 6 м<sup>2</sup> талбайд судалгааг гүйцэтгэв (Зураг 4).

Малтлагын талбайн газрын өнгөн хөрсөн дээрээс 28 ш чулуун зэвсгийн олдворыг дэвсгэр зурагт тэмдэглэж, түүвэрлэв. Олдворын дотор ирлэсэн залтас 1 бий. Тэр нь жижиг хэмжээтэй бөгөөд хажуу ирмэгийн багахан хэсэгт жигд бус холточсон ир гаргасан байна. Ялтас 12 ш байгаа нь бүтэн 5 ш, цохилтын талбайн

үлдэгдлээ хадгалсан дээд хэсгийн хугархай 3, дунд хэсгийн хугархай 1, үзүүр хэсгийн хугархай 3 хэмээн ангилагдана. Бүтэн ялтас хэмжээгээр жижиг бөгөөд тэгш бус хэмтэй. Нэг ялтасны төгсгөл хэсэг чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Том ялтсуудыг бөмбөгөрдүү, арагшаа налуу цохилтын талбай бүхий үлдцээс цуулж авсан байна. Залтас 4 ш байгаагийн хоёр нь жижиг хэмжээтэй юм. Залтаснууд нь гадаргуудаа өмнөх цуулалтын ормыг хадгалсан хоёрдогч цуулдасны төрөлд хамаарна.

Чулуун зэвсэг цуулалт, хэлтлэлт, ирлэлтийн явцад гарсан жижиг хайрс 5, хагархай хэлтэрхий 5 ш байна.

Хүснэгт 1. Оцон цохионы малтлагаас илрүүлсэн чулуун зэвсгийн олдворын төрөл зүйлийн ангилал

	Оцон цохионы малтлага: Газрын гадарга				Оцон цохионы малтлага: 1-р давхарга				Оцон цохионы малтлага: 2-р давхарга			
	U	R	Σ	f	U	R	Σ	f	U	R	Σ	F
Түүхий эд	0	0	0	0.0	1	0	1	0.35	2	0	2	5.88
Бэлдэц	0	0	0	0.0	3	0	3	1.07	0	0	0	0.0
Үлдэц	0	0	0	0.0	13	0	13	4.67	0	0	0	0.0
Залтас	2	1	3	11.1	62	3	65	23.38	11	0	11	32.35
Түүхий эдийн гадартай залтас	0	0	0	0.0	7	1	8	2.87	3	0	3	8.82
Ялтас	10	0	10	37.0	77	9	86	30.93	8	1	9	26.47
Түүхий эдийн гадартай ялтас	2	0	2	7.4	6	0	6	2.15	0	0	0	0.0
Залтас 2<cm	2	0	2	7.4	14	0	14	5.03	0	0	0	0.0
Хайрс	5	0	5	18.51	17	0	17	6.11	1	0	1	2.94
Хагархай, хэлтэрхий	5	0	5	18.51	58	0	58	20.86	8	0	8	26.47
Техникийн цуулдас	0	0	0	0.0	7	0	7	2.51	0	0	0	0.0
<b>Нийт</b>	<b>26</b>	<b>1</b>	<b>27</b>	<b>100</b>	<b>265</b>	<b>13</b>	<b>278</b>	<b>100</b>	<b>33</b>	<b>1</b>	<b>34</b>	<b>100</b>

1-р давхаргын малтлага. Газрын өнгөн хөрсөн дээрх цөөн тооны олдвор, амьтны ясны хэлтэрхийг баримтжуулсны дараа малтлагыг цаашид 5 см гүнтэйгээр үелэн гүйцэтгэсэн. Хөрсний бүтцийн хувьд жижиг чулуутай, нарийн ширхэгтэй шаварлаг хурдаснаас тогтсон байна. Малтлагын талбайн зарим хэсэгт кальцийн карбонатын бөөгнөрөл илэрч байв.



*Зураг 5. Малтлагын 1-р давхаргаас яс, чулуун зэвсэг илэрсэн байдал*

Малтлагаас чулуун зэвсэг, тэр дунд дахин боловсруулаагүй залтас, ялтас олон олдов (Зураг 5). Малтлагын талбайн төв хэсэгт, А4, А3 өргийн заагаас бүрэн араатай, үүдэн шүдний зарим хэсэг нь хадгалагдан үлдсэн адууны эрүү зүүн хойд зүгт чиглэсэн байдалтай гарсан. Хоёр эрүүний хооронд хэл байх хэсэгт нь дээд палеолитын эхэн үеийн хэв шинжтэй ялтсыг тавьсан (Зураг 6) нь сонирхолтой.



*Зураг 6. А4, А3 өргийн заагаас гарсан адууны эрүү, эрүүний хооронд тавьсан ялтас*

Араа шүдтэйгээ маш сайн хадгалагдсан эрүүний дунд, хэл байх хэсэгт энэ ялтас байгаа нь ямар нэг байгалийн хүчин зүйл, хөрсний хөдөлгөөнтэй холбоогүй

бөгөөд хүн зориуд тавьсан гэлтэй. Энэ нь магадгүй эртний анчин, түүвэрлэгчдийн шүтлэг, зан үйлийн илэрхийлэл байж болох юм. Мөн эрүүний эргэн тойрон, углуурганы орчмоос чулуун зэвсгийн олдворууд нэлээд олон гарлаа. Эрүүний дэргэдээс маш бахим чөмөгний хугархай гарсан нь мөн л хадгалалт сайн юм. Бид үүнийг бие гүйцээгүй хирсний яс хэмээн үзэж буй бөгөөд 2018 оны малтлагаас том амьтны бүтэн шахам дал илрүүлсэн [Одсүрэн нар., 2018] нь хирснийх гэдэг нь тодорхой болсон юм. Мөн буга, адуу, үхэр, зээр, юуных нь тодорхойгүй ясны жижиг хэсэг олон гарсан байна.



Зураг 7. 1 – бэлдэц, 2 – таргил үлдэц

1-р давхаргын чулуун зэвсгийн тодорхойлолт. Өнгөн хөрсний олдворыг баримтжуулсны дараа 5 см гүнтэйгээр үелэн малтав.



Хөрсний бүтцийн хувьд жижиг чулуутай, нарийн ширхэгтэй шаварлаг хурдаснаас тогтсон байна. Малтлагын талбайн зарим хэсэгт кальцийн карбонатын бөөгнөрөл илэрч байв.

Энэ үеийн малтлагаас 278 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн. Тэдгээрийн дотор бэлдэц 3 ш байна. Эхний бэлдэц нэлээд том бөгөөд цахиурлаг чулуу ашиглан бэлтгэжээ. Түүхий эдийн эргэн тойрноос замбараагүй цуулалт хийж залтас, ялтас салган авсан оромтой (Зураг 7. 1). Дараагийнх нь шаравтар өнгөтэй чинчигноров ашиглан хийсэн. Түүхий эдийн нэг тэгш талыг цохилтын талбай болгон ашиглаж ялтас салган авчээ. Энэ төрөлд хамаарах сүүлийн эдлэлийг зэрэгцээ цуулалтаар жижиг ялтас салган авах үлдэц хийхээр зассан байна. Ар тал руугаа ялимгүй налуу том цохилтын талбайг гүйцэд бэлтгэлгүй орхижээ. Цохилтын талбайгаас шулуун цуулалт хийж хэд хэдэн ялтас салган авсан оромтой. Суурийг мөн нимгэлж, ар талыг нь дагуулан шулуун цуулалт хийсэн оромтой.

Үлдэц 13 байна. Тэдгээр нь цацарган цуулалтад таргил үлдэц 1, зэрэгцээ цуулалтад үлдэц 9, бичил цуулалтат үлдэц хэмээн ангилагдана.

Таргил үлдцийг гүйцэд боловсруулаагүй. Зах ирмэгээс нь төв рүү чиглүүлсэн цуулалтуудаар зассан бөгөөд нүүр болон ар тал нь нэлээд товгор юм. Нүүрэн талд нь ялтас салган авах оролдлого хийсэн хэд хэдэн ором байх бөгөөд амжилтгүй болжээ (Зураг 7. 2).

Зэрэгцээ цуулалтад үлдцүүд хэмжээгээр харилцан адилгүй. Зарим нь жижиг бөгөөд нимгэн ялтас авсан зэрэгцээ ормуудтай. Харин хэмжээгээр том үлдцүүд дээд палеолитын эхэн үеийн арга ажиллагааг илтгэж байна. А3 өргийн 1с давхаргаас буюу нэлээд доороос илрүүлсэн энэ төрлийн үлдцийг бахим зузаан цахиурлаг чулуу ашиглан бэлтгэсэн. Түүхий эдийн арагшаа ялимгүй налуу том хавтгай талыг цохилтын талбай болгосон бөгөөд нүүрэн талд нь хэд хэдэн өргөн ялтас цуулж авсан ором үлджээ. Ар тал нь товгор бөгөөд суурьнаас шулаан цуулалт хийсэн нь амжилтгүй болсон оромтой (Зураг 8. 1). АА3 өргийн 1с өргөөс илэрсэн 27 дугаартай үлдэц мөн том хэмжээтэй бөгөөд арагшаа ихэд налуу цохилтын талбайтай. Нэг хажуу ирмэгийг хөндлөн цуулалтууд хийж засжээ. Нүүрэн тал нь Ялимгүй гүдгэр бөгөөд суурь болон цохилтын талбайгаас шулуун цуулалт хийж нимгэн ялтас авсан зэрэгцээ ормуудтай. АА4 өргийн 1-р үеэс илэрсэн зэрэгцээ цуулалтад үлдцийг

хагархай ашиглан хийжээ. Нэг тэгш талыг цохилтын талбай болгон ашиглаж жижиг, нимгэн ялтас цуулж авчээ. Үлдсэн 6 үлдэц нь жижиг хэмжээтэй бөгөөд цохилтын нэг талбайтай. Зарим нь чулууны өнгөн бүрхүүлээ хадгалсан бөгөөд жижиг, нимгэн ялтас салган авсан зэрэгцээ ормуудтай юм.



Зураг 8. 1 – зэрэгцээ цуулалтад үлдэц; 2 – бичил цуулалтат үлдэц

Бичил цуулалтад үлдэц 3 байгаагийн нэг нь нэлээд урт юм. Арагшаа налуу цохилтын талбайн цуулалтын гадаргуутай уулзсан ирмэгийг холтчин засжээ.

Нүүрэн талын нэг хажуу чулууны өнгөн бүрхүүлээ хадгалах бол ихэнх хэсэгт нимгэн ялтас салган авсан зэрэгцээ ором үлджээ.

Хүснэгт 2. Оцон цохионы малтлагаас илрүүлсэн үлдцийн төрөл зүйлийн ангилал

Үлдцийн төрөл	Оцон цохионы малтлага: Газрын гадарга			Оцон цохионы малтлага: 1-р давхарга			Оцон цохионы малтлага: 2-р давхарга		
	n	Σ	f	n	Σ	f	n	Σ	f
Бэлдэц	0	0	0.0	3	3	18.75	0	0	0.0
Таргил үлдэц	0	0	0.0	1	1	6.25	0	0	0.0
Зэрэгцээ цуулалтад үлдэц	0	0	0.0	9	9	56.25	0	0	0.0
Бичил цуулалтад үлдэц	0	0	0.0	3	3	18.75	0	0	0.0
<b>Нийт</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>16</b>	<b>16</b>	<b>100</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

Дараагийнх нь мөн хэд хэдэн жижиг ялтас салган авсан зэрэгцээ оромтой. Цохилтын талбай болон ар талын ихэнх хэсэг чулууны өнгөн бүрхүүлээ хадгалжээ. Энэ төрөлд хамаарах сүүлийн үлдцийг хагархай ашиглан хийжээ. Өмнөхийн адил урьдчилан засаагүй тэгш талыг цохилтын талбай болгосон бөгөөд нэг талд нь ялтас цуулж авах оролдлого хийсэн хэд хэдэн оромтой.



Зураг 9. 1, 2 – хусуур, 3, 4 – ялтас

Энэ үеэс багаж зэвсгийн олдвор 12 илэрсэн. Тэдгээр нь хусуур 3, цоолтуур 1, леваллуагийн залтас 1, шүдлэг ирт зэвсэг 1, шүдлэг хүнхэр ирт зэвсэг 1, иртэй ялтас 3, иртэй ялтасны хугархай 2 юм.

Бүх хусуурыг ялтсаар бэлтгэжээ. Хоёр нь урт, нэг нь богиновтор хэмжээтэй. Ялтасны төгсгөл ирмэгийг дугуйруулан засаж босоо холтчин ирлэжээ (Зураг 9. 1, 2). Ийм хэв шинжийн хусуур Монгол орны дээд палеолитын эхэн үед холбогдох нь тодорхой болсон юм. Сэлэнгэ мөрний дунд урсгалын цутгал Их Төлбөрийн гол, Харганын гол, Эгийн голын сав нутгийн соёлт давхаргатай дурсгалын малтлагын доод давхаргуудаас илэрсэн бөгөөд он цагийн хамаарлыг лабораторийн судалгаагаар тогтоосон байдаг.



Зураг 10. 1, 2 – леваллуагийн залтас

*Цоолтуурыг* жижгэвтэр залтас ашиглан хийжээ. Түүний нэг буланд урт хошуу гаргаад түүнийгээ нямбай шовхлон үзүүрлэж зассан байна.

*Леваллуагийн залтас* жижгэвтэр хэмжээтэй. Цохилтын талбайн үлдэгдэл нь гол хэсгээрээ нэлээд гүдгэр бөгөөд хажуу ирмэг нь үзүүр рүүгээ нарийсаж нийлсэн гурвалжин хэлбэртэй. Торгон үзүүрийг нь тайрсны дараа холтчин ирлэсэн ором

ажиглагдана. Хажуу ирмэгт нүүр болон ар талаас нь цөөн холтчин ирлэсэн оромтой. Цохилтын товгор нь нэлээд том юм (Зураг 10. 1, 2).

*Шүдлэг ирт зэвсгийг* түүхий эдийн өнгөн бүрхүүлээ хадгалсан том хэмжээтэй хоёрдогч залтсаар хийжээ. Залтасны төгсгөл ирмэгийн ховил гарган хагалсны дараа хурц шовх жижиг үзүүр гаргасан байна.

Хүснэгт 3. Оцон цохионы малтлагаас илрүүлсэн багаж зэвсгийн төрөл зүйлийн ангилал

Багаж зэвсгийн төрөл зүйл	Оцон цохионы малтлага: Газрын гадарга		Оцон цохионы малтлага: 1-р давхарга		Оцон цохионы малтлага: 2-р давхарга	
	n	f	n	f	n	f
<b>Тогтсон хэв шинжит багаж зэвсэг</b>						
<i>Төгсгөл хусуур</i>	0	0.0	3	25	0	0.0
<i>Цоолтуур</i>	0	0.0	1	8.33	0	0.0
<i>Леваллуагийн залтас</i>	0	0.0	1	8.33	0	0.0
<i>Леваллуагийн ялтас</i>	0	0.0	0	0.0	1	50
<b>Өвөрмөц багаж зэвсэг</b>	0	0.0	0	0.0	0	0.0
<i>Шүдлэг ирт зэвсэг</i>	0	0.0	1	8.33	0	0.0
<i>Иртэй залтас</i>	1	100	0	0.0	0	0.0
<i>Шүдлэг, хүнхэр ирт зэвсэг</i>	0	0.0	1	8.33	0	0.0
<i>Иртэй ялтас</i>	0	0.0	3	25	1	50
<i>Иртэй ялтасны хугархай</i>	0	0.0	2	16.66	0	0.0
<b>Нийт</b>	<b>1</b>	<b>100</b>	<b>12</b>	<b>100</b>	<b>2</b>	<b>100</b>

*Шүдлэг хүнхэр ирт зэвсгийг* дээд палеолитын хэв шинжит ялтасны дунд хэсгийн хугархайгаар хийжээ. Нэг ирмэгт нь хоорондоо зайтай хэлтчин ирлэх явцад жижиг хурц үзүүр болон хүнхэр ир бий болжээ.

*Ирлэсэн ялтасны* нэг нь том, гадаргуудаа өнгөн бүрхүүлээ хадгалсан. Түүний зах ирмэгийг хоорондоо зайтай томоор холтчин ирлэсэн байна. Хоёр дахь ялтас нь хугархай бөгөөд зах ирмэгийг нь жижгээр жигд бус ирлэжээ. Сүүлийнх нь жижиг хэмжээтэй дээд палеолитын төгсгөл үед холбогдох магадлалтай бөгөөд нэг хажуу ирмэгийг босоо холтчин ирлэжээ. Үлдцийн хажууг дахин засахад гардаг техникийн цуулдасны төрөлд хамаарна. Мөн хоёр ялтасны хугархайг жигд бус ирлэн зассан нь мэдэгдэж байна.

Энэ жилийн малтлагаас леваллуагийн үлдэц илрээгүй боловч леваллуагийн залтас олдсон нь ихээхэн сонирхолтой. Хэмжээ болоод хэв шинжийн хувьд леваллуагийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн хожуу үед хамаарах бололтой. Энэ

эдлэл нь тухайн дурсгалын леваллуагийн үйлдвэрлэлийн арга ажиллагааг сэргээн тодруулах чухал хэрэглэгдэхүүний нэг юм.



Зураг 11. 1 – 3 бүтэн ялтас, 4, 5 – ялтасны дээд хэсгийн хугархай

Энэ давхаргаас олдсон чулуун зэвсгийн олдворын хамгийн олон буюу 169 нь үйлдвэрлэлийн явцад гарсан цуулдас, хагархай хэлтэрхий юм. Тэдгээрийн дотор буй тухайн бүс нутгийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга ажиллагааг нөхөн сэргээх хэрэглэгдэхүүн бол ялтас юм. Ялтас том, жижиг янз бүрийн хэмжээтэй агаад том хэмжээтэй нь бидний сонирхолыг ихэд татаж буй. Том хэмжээтэй ялтаснууд дээд палеолитын эхэн үед холбогдох бөгөөд бөмбөгөрдүү цохилтын талбайн үлдэгдлийг хадгалсан байна (Зураг 9. 3, 4; 11. 1 – 5). Харин залтаснууд жижиг болон жижгэвтэр хэмжээтэй. Тэдгээр нь чулуун зэвсэг цуулалтын үйл ажиллагааны явцад бий болсон бөгөөд зориудаар багаж зэвсэг хийх зорилгоор бий болгоогүй ажээ.

Техникийн цуулдсууд бүгд үлдцийн хажуу ирмэгийг дахин засах оролдлогын улмаас гарсан захын цуулдас юм.

2-р давхаргын малтлага. 1-р давхаргын малтлагын явцад чулуу ихтэй шаварлаг бордуу хөрсний доод талд кальцийн карбонат бүхий мараалаг цайвар шаварлаг хөрс буй нь тодорхой болсон юм. Малтлагын талбайн зарим хэсэгт энэ

хөрс нэлээд дээрээс гарсан. 1-р үеийн төгсгөл энэхүү цайвар шаварлаг үеийн завсрыг бид 2-р давхарга хэмээн тодорхойлсон.

*2-р давхаргын чулуун зэвсгийн тодорхойлолт.* Эндээс бүх талбайгаас 34 ш чулуун зэвсгийн олдворыг амьтны ясны хамт илрүүлэн баримтжуулсан юм.

Чулуун зэвсгийн олдворын дотор анхдагч цуулалтыг илэрхийлэх тодорхой баримт байхгүй. Харин том хэмжээтэй цуулалт бүхий түүхий эд 2 бий. Залтаснууд ихэнх дундаж болон жижиг хэмжээтэй юм. Багаж зэвсгийн зүйлд ирлэсэн ялтас хамаарна.

Хүснэгт 3.1. *Оцон цохионы малтлагаас илрүүлсэн цуулдасны үйлдвэрлэлийн төрөл зүйлийн ангилал*

Цуулдасны үйлдвэрлэлд хамаарах эдлэлийн төрөл зүйл	Оцон цохионы малтлага: Газрын гадарга			Оцон цохионы малтлага: 1-р давхарга			Оцон цохионы малтлага: 2-р давхарга		
	n	$\Sigma$	f	n	$\Sigma$	f	n	$\Sigma$	f
Ялтас	3	0	17.64	28	0	16.56	1	0	4.34
Өнгөн бүрхүүлтэй ялтас	1	0	5.88	5	0	2.95	1	0	4.34
<i>Ялтасны дээд хэсэг</i>	3	0	17.64	24	0	14.2	2	0	8.68
<i>Дунд хэсэг</i>	1	0	5.88	11	0	6.5	2	0	8.68
<i>Төгсгөл хэсэг</i>	4	0	23.52	15	0	8.75	3	0	13.04
Залтас	4	1	29.41	74	1	44.37	11	0	47.82
Өнгөн бүрхүүлтэй залтас	0	0	0.0	5	0	2.95	3	0	13.04
Техникийн цуулдас	0	0	0.0	6		3.55	0	0	0.0
<b>Total</b>	<b>16</b>	<b>1</b>	<b>100</b>	<b>168</b>	<b>1</b>	<b>100</b>	<b>23</b>	<b>0</b>	<b>100</b>

Малтлагаас янз бүрийн хэмжээтэй улаан зос олон олдсоныг дэвсгэр зурагт баримтжуулсан. Оцон цохионы палеолитын дурсгалын орчимд улаан зосны орд байдаг тул малтлагаас гарч буй зосны үлдэгдэл хүний үйл ажиллагаатай холбоотой гэхээс илүүтэй байгалийнх байх магадлалтай. Гэхдээ дээд палеолитын үед холбогдох бууц суурингийн малтлагаас илэрдэг зосны үлдэгдлийг анхаарч үзэх, түүхий эдийн эх нь хаана гэдгийг тогтоох, зөөвөрлөн авчирсан, эсэхийг нягтлах нь палеолитын судалгааны нэг асуудал юм. Тухайн үеийн хүмүүсийн хадны зураг зурах хэрэгсэл зосыг гоёл чимэглэл, шүтлэг, зан үйлийн үүднээс чухалчлан үзэж, зөөвөрлөн авчирдаг байх магадлалтай. Их Төлбөрийн голын хөндийд хийсэн дээд палеолитын бууц суурингийн малтлагаас зосны жижиг хэлтэрхий олон гарсны

зэрэгцээ зүүлт чимэглэлийг улаан зосоор будсан ор мэдэгдсэн нь эрхгүй анхаарал татаж байгаа юм.

Түүнчлэн малтлагын талбайн баруун хэсгээс хүнийхтэй ихэд төстэй хөлийн хурууны яс, холбогч яс хэд хэд гарсан. Антропологичийн үзэж буйгаар энэ нь хүнийх биш бөгөөд мазаалайнх байх магадлалтай ажээ. Цаашид үүнийг лавшруулан судлах бөгөөд уур амьсгалын хувьд орчин цагийн говийн бүс нутгаас эрс ялгаатай нөхцөлд ойт хээр болон ойн бүсэд амьдрах зохилдолгоотой олон төрөл зүйл амьтадтай мазаалай зэрэгцэн амьдарч, эртний анчин, түүвэрлэгчдийн ан гөрөөний нэг болж байв уу? гэдэг нь сонин байна.

Чулуун зэвсгийн хувьд дээд палеолитын эхэн үеэс төгсгөл хүртэлх үйлдвэрлэлийн арга барилыг илэрхийлсэн олдвор илрүүлсэн. Хэдийгээр леваллуагийн цуулалтад үлдэц олдоогүй боловч леваллуа маягийн ялтас чулуун зэвсгийн дотор нэлээд олон бий. Үлдцийн дотор дээд палеолитын эхэн үед холбогдох зэрэгцээ цуулалтад хэв шинж голлож байгаа бөгөөд он цагийн хувьд арай хожуу үед хамаарах ялтас цуулан авсан жижгэвтэр үлдэц ч байна. Багаж зэвсгийн дотор хянгар, ирлэсэн ялтас дийлэнх хувийг бүрдүүлнэ. Мөн дээд палеолитын хэв шинжит төгсгөл хусуур, цоолтуур, хүнхэр ирт зэвсэг эндэхийн анчин, түүвэрлэгчдийн гол багаж болж байжээ.



Зураг 12. Малтлагын доод хэсгээс илрүүлсэн чулуун зэвсэг, амьтны яс





*Зураг 13. Малтлагын доод талаас гарсан цайвар шаварлаг хөрс*

### 2.3. Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринд хийсэн малтлага судалгаа

Хамтарсан төслийн баг 2018 оноос Монгол төдийгүй Зүүн Азийн неолитын томоохон дурсгал болох Тамсагбулагийн сууринд малтлага судалгааны ажил эхлүүлсэн юм. 2018, 2021 оны хээрийн судалгааны улиралд хэд хэдэн газарт том хэмжээтэй малтлага хийсэн (Зураг 14). 2022 онд төслийн багийн судлаачид ТВ 13 хэмээн судалгааны ажлын баримтжуулалтад тэмдэглэсэн дурсгалын судалгааг үргэлжлүүлэв.



Зураг 14. Тамсагбулагийн дурсгалт газарт хийж буй малтлага судалгаа

Тамсагийн булагийн эхээс урагш орших жалганы адагт чулуун зэвсэг, шавар ваарны хагархай хөрсний элэгдлээр газрын хөрсөн дээр ил гарсан эртний амьдралын ул мөрийг илэрхийлэх дурсгал байсан тул бид 2021 онд ТВ 13 хэмээн дугаарлаж малтлагыг эхлүүлсэн юм. Малтлагын үр дүнд галын ором, шонгийн нүхний ором, дагтаршуулсан шалны хэсгийн илрүүлсэн юм. Мөн хар хөрсөнд амьтны яс, ясан эдлэлийн баялаг олдвор хадгалагдаж буйг баримтжуулсан бөгөөд цаг хугацааны боломжоос шалтгаалан малтлагыг бүрэн дуусгаж амжаагүй юм. Тиймээс энэ онд өмнөх жилд илрүүлсэн баялаг олдвор бүхий хар хөрсний хязгаарыг

олох, нүхэн сууц мөн эсэхийг эцэслэн тогтоох зорилготой судалгааг гүйцэтгэв. Ингэхдээ өмнөх жилийн малтлагыг зүүн тийш нь  $34.5 \text{ м}^2$ , баруун тийш нь  $6 \text{ м}^2$  сунган  $40.5 \text{ м}^2$  талбайд судалгаа хийсэн.

Энэ жилийн малтлагыг бид өмнөх жилийн B0 хэмээн дугаарласан өргийг урагш нь сунгаснаар эхэлсэн бөгөөд мөстлөгийн дараах үеийн ахуй амьдралын ул мөрийг хадгалсан хар хөрс энд нэлээд зузаан хуримтлагдсан байсан юм.



Зураг 15. 2022 оны малтлагын эхлэл. C0 өрөг

Тиймээс бид B0 өргийг урагш нь сунган өмнөх жилийн дугаарлалтыг үргэлжлүүлэн C0, D0 хэмээн тэмдэглэсэн юм. Газрын өнгөн хэсэгт 5-8 см зузаан

элсэрхэг хөрс тогтсон бөгөөд энэ үеийг 1-р давхарга хэмээн баримтжуулсан. Эндээс 165 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн (Хүснэгт 4). Чулуун зэвсгийн олдворын дотор залтсаар хийсэн жижиг хусуур, ирлэсэн ялтасны 2 хугархайгаас бусад нь цуулдасны үйлдвэрлэлд хамаарна.

Хүснэгт 4. С0 өргийн 1-р давхаргаас илрүүлсэн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Хусуур	1	TB13.L1.Screen
Иртэй ялтас	2	TB13.L1.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	19	TB13.L1.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	28	TB13.L1.Screen
Ялтасны үзүүр хэсгийн хугархай	5	TB13.L1.Screen
Залтас	4	TB13.L1.Screen
Хайрс	13	TB13.L1.Screen
Хагархай, хэлтэрхий	93	TB13.L1.Screen
Нийт	165	

Хар хөрсөн давхаргыг бид бүхэлд нь 2-р давхарга хэмээн баримтжуулсан. Гэхдээ хөрсний ялимгүй өөрчлөлт, малтлагын үе давхаргад тулгуурлан үсгэн дугаар өгч ангилсан юм.

Өнгөн хэсгийн элсийг авсны дараа доош 5 см гүнтйгээр 2 үе малтсан бөгөөд энэ үеийг бид 2-р үе хэмээн баримтжуулав. Хөрс ерөнхийдөө элсэрхэг бараандуу өнгөтэй бөгөөд талбайн зүүн өмнөд хэсгээс галын ором бололтой хатуу бараан хөрс илрэв. Чулуун зэвсгийн зүйл, шавар ваарны хагархай нэлээд олдов (Хүснэгт 5). Ялангуяа, галын ормын орчмоос шатсан шаврын үлдэгдэл нэлээд олон гарч байна.

Хүснэгт 5. С0 өргийн 2-р үеэс илрүүлсэн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Техникийн цуулдас	1	TB13.C0L2. Screen
Хусуур	1	TB13.C0L2. Screen
Ирлэсэн ялтас	2	TB13.C0L2. Screen
Ялтас	1	TB13.22.C0.L2.54
Ялтасны дээд хэсэг	17	TB13.C0L2. Screen
Ялтасны дунд хэсэг	35	TB13.C0L2. Screen
Ялтасны үзүүр	10	TB13.C0L2. Screen
Хайрс	30	TB13.C0L2. Screen
Залтас	22	TB13.C0L2. Screen
Хэлтэрхий	97	TB13.C0L2. Screen
Нийт	216	

Шавар эдлэл		
Ваарны хагархай	10	TB13.C0L2.53; TB13.C0L2.Screen
Шаврын хагархай	5	TB13.C0L2. Screen

Эндээс 216 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсний ихэнх үйлдвэрлэлийн явцад гарсан хагархай, хэлтэрхий юм. Техникийн цуулдас нь гадаргуугийн бүх талаас ялтас цуулж авсан оромтой үлдцийн цохилтын талбайг дахин тайрч засах явцад бий болжээ. Ирлэсэн ялтасны нэг нь дунд хэсгийн хугархай агаад нэг ирмэгийг нь налуу холтчин ирлэжээ. Нөгөөх нь үзүүр хэсгийн хугархай юм. Хажуу ирмэгийг нь үзүүр рүү нь нийлтэл нь жижгээр холтчин ирлэж үзүүрлэжээ. Хусуурыг ижиг дугуй злтсаар хийжээ. Нэлээд өндөр хамартай бөгөөд ялтаслан ирлэжээ.

2-р үеийн малтлагаас доош хөрс гүн хар өнгөтэй болсон бөгөөд ясан олдворын чанар илүү сайн болж байна. Бид өмнөхийн адил 5 см зузаанаар хусан малтсан ба 2b хэмээн тэмдэглэж баримтжуулав (Хүснэгт 6).

Техникийн цуулдасны нэг нь шаантган үлдцийн хажуу ирмэгийг засах явцад гарчээ. Нөгөөх нь үлдцийн цохилтын талбайг дахин тэгшлэр оролдлогын явцад бий болсон.

Ирлэсэн ялтаснууд бүгд тэгш хэмтэй. Ар талаас нь хоёр ирмэгийг нь холтчин ирлэсэн байна. Харин залтасны нэг буланд ир гаргасан.

Хүснэгт 6. C0 өргийн 2b үеэс илрүүлсэн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Үлдцийн хагархай	1	TB13.22.C0.L2b.39
Техникийн цуулдас	2	TB13.22.C0.L2b. Screen
Хусуур	8	TB13.22.C0.L2b.40,57; TB13.22.C0.L2b.Screen
Ирлэсэн ялтасны хугархай	4	TB13.22.C0.L2b.43; TB13.22.C0.L2b.Screen
Ирлэсэн залтас	1	TB13.22. C0.L2b. Screen
Ялтас	1	TB13.22.C0.L2b.42
Ялтасны дээд хэсгийн хугархай	13	TB13.22.C0.L2b.58; TB13.22.C0.L2b. Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	43	TB13.22.C0.L2b.59; TB13.22.C0.L2b.Screen
Ялтасны үзүүрийн хугархай	8	TB13.22. C0.L2b. Screen
Хайрс	23	TB13.22. C0.L2b. Screen
Залтас	35	TB13.22.C0.L2b.38, 41, 60, TB13.22.C0.L2b.Screen
Хэлтэрхий	75	TB13.22.C0.L2b.638 TB13.22.C0.L2b.Screen
Нийт	214	
Ваарны хагархай	13	TB13.22. C0.L2b. 37; Screen

Хээлж чимэглэсэн шавар эдлэлийн хагархай	1	TB13.22. C0.L2b: 44
Шаврын хагархай	50	TB13.22. C0.L2b. Screen

Хусуурын олонхийг жижиг залтсаар хийжээ. Залтасны ирмэгийг тойруулан босоо ир гаргасан байна. Гол төлөв тэгш хэмт ялтсыг ар талаас нь жижгээр жигд ирлэжээ.

Хээлж чимэглэсэн шавар эдлэлийн хугархай (TB13.22. C0.L2b: 44). Тус өргийн малтлагын 2b үеэс олдсон нимгэн шавар эдлэлийн гадрыг олон жижиг дугуй хонхор гарган хээлжээ.



Зураг 16. C0 өргийн 2b үе. Галын ором, цайвар шаргал өнгөтэй шавран судал илэрсэн байдал

Энэ жилийн малтлагын хамгийн баялаг олдвортой үе бол 2с үе юм. Нарийн шрхэгтэй элсэрхэг хөрс гүн хар өнгөтэй бөгөөд энэ үеэс амьтны ясны олдвор илүү хадгалалт сайн гарч ирж байна. Түүнчлэн чулуун зэвсгийн олдворын дотор хагархай, хэлтэрхийн эзлэх хувь нэлээд буурч байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. C0 өргийн 2с үеэс илрүүлсэн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
----------------	-----	--------

Чулуун зэвсэг		
Техникийн цуулдас	1	TB13.22.C0.L2c.47
Түүхий эд	1	TB13.22.C0.L2c.140
Цоолтуур	2	L2c. hearth. Screen, TB13.22. C0.L2c: Screen
Сийлүүр	1	TB13.22. C0.L2c: 46, 32; TB13.22. C0.L2c Screen
Хусуур	3	TB13.L2c. screen
Илэсэн ялтас	1	TB13.L2c. screen
Ялтас	3	TB13.22.C0.L2c.78, 106, 133
Ялтасны дээд хэсгийн хугархай	5	TB13.L2c. screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	9	TB13.22.C0.L2c.61, 63; TB13.L2c. screen
Ялтасны үзүүр	6	TB13.22.C0.L2c.139; TB13.L2c. screen
Залтас	10	TB13.22.C0.L2c.44, 45; TB13.L2c.Screen
Хагархай, хэлтэрхий	24	TB13.22.C0.L2c.135; 142; TB13.L2c. screen
Нийт	66	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	8	TB13.L2c: 34-36; TB13.L2c.L2c. hearth. Screen
Шаврын хагархай	6	TB13.L2c.L2c. hearth. Screen
Шавар бөмбөлөг	2	TB13.22. C0.L2c: 55, 75
Шавар эдлэлийн хэсэг	1	TB13.22. C0.L2c: 43
Хээтэй шавар эдлэлийн хагархай	1	TB13.22. C0.L2c: 59
Дугуйлж зассан шавар эдлэл	1	TB13.22. C0.L2c: 60
Ваарны амсрын хагархай	1	TB13.22. C0.L2c: 130
Ясан эдлэл		
Ясан эдлэлийн хугархай	1	TB13.22. C0.L2c: Screen)


Техникийн цуулдас нь үлдцийн хажууг дахин засахад гарчээ. Шинэ чулуун зэвсгийн бууц суурингаас ийм эдлэл нэлээд олддог.

Цоолтуурын төрөлд хамаарах эхний эдлэл буюу үзүүр галын ормын орчмоос олдсон бөгөөд ялтсаар хийжээ. Хажуу ирмэгүүдийг төгсгөл хэсэг рүү нь жижгээр холтчин ихэд шовхлон үзүүрлэсэн байна. Суурь нь хугарсан. Дараагийнх нь хар өнгөтэй цахиурлаг чулуунаас салгаж авсан гурван талтай нимгэн ялтасны төгсгөл хоёр ирмэгийг үзүүр нь нийлтэл жижгээр холчин нямбай ирлэж шовх хурц үзүүр бий болгожээ.

Сийлүүрийг тэгш хэмтэй ялтсаар хийсэн. Ялтсыг ташуу тайрч ирмэгүүдийг нь жижгээр холтчин ирлэсэн байна. Суурь хэсэг нь хугарчээ.

Хусуурыг залтсаар хийсэн бөгөөд төгсгөл ирмэгийг нь дугуйруулан холтчин ирлэсэн. Ялтасны дээд, доод талыг нь тайрсан дунд хэсгийн хугархай юм. Хоёр ирмэгийг жижгээр ирлэсэн байна.

*Шавар бөмбөлөг 2 ш.* (ТВ13.22. С0.Л2с: 55, 75) Нарийн ширхэгтэй шаврыг бөөрөнхийлж шатааж хатууруулжээ. Хээ чимэг гаргаагүй. Нэг нь ялимгүй зуувандуу бол нөгөөх нь өөгүй бөөрөнхий хэлбэртэй.



Зураг 17. 1 – ялтасны хугархай, 2 – нэлээд өргөн ясан зүүний дээд хэсэг, 3 – цоолтуур, 4 – ялтсан зэв, 5 – хоёр талт зэв

*Ясан эдлэлийн хугархай.* (ТВ13.22. С0.Л2с: Screen) Нэг үзүүрийг нь дугуйруулж мөлийлгөн зассан нарийн урт эдлэлийн хугархай юм. Мөлийлгөн зассан хэсэг нь дээд тал бололтой бөгөөд нэвт нүхэлжээ. Түүний нэг тал ялимгүй товгор бол нөгөө тал нь хавтгай, хажуу нь шулуун ирмэгтэй. Бүхэлд нь зүлгэн нимгэлж хийжээ. Том хэмжээтэй ясан зүү, сүлбээрийн дээд хэсэг бололтой.

*Шавар цагариг маягийн эдлэлийн хугархай.* ТВ13.22. С0.Л2с: 43. Нарийн ширхэгтэй шаврыг цагариг гархи маягийн хэлбэрт оруулан шатааж хатууруулсан эдлэлийн хугархай юм. Өөр эдлэлийн чимэглэл, эсвэл бариул байж болно.

*Хээтэй шавар эдлэлийн хагархай* (ТВ13.22. С0.Л2с: 59). Нарийн ширхэгтэй шавраас хийсэн, нэлээд зузаан. Шаврын найрлагад гялтгануур мэдэгдэх бөгөөд нэг талд нь нарийн болон өргөн хөндлөн, ташуу, тууш гарсан оромтой. Нарийн үзүүртэй зүүлээр зурсан гэхээс илүүтэй шатаахаас өмнө гадар талд нь наасан дэрс, хулсны



ор байж магадгүй юм. Ваар сав биш бөгөөд юунд зориулагдсаныг хэлэх боломжгүй байна.



Зураг 18. 1 – ясан сүлбээрийн үзүүр, 2 – зурчсан оромтой яс

*Дугуйлж зассан шавар эдлэл* (ТВ13.22. С0.L2с: 60). Органик эдлэлээс саятар ялгаж цэвэрлээгүй нарийн ширхэгтэй шаврыг нимгэлж зах ирмэгийг нь мөлийлгэн дугуйруулан засжээ. Нэг тал нь хагарч унасан. Нэхмэлийн утасны үзүүрт хийдэг хүндрүүлэгчтэй төстэй боловч утас оосорлох нүхгүй. Тоглоомын хасаатай төстэй.

*Ваарны амсрын хагархай.* (ТВ13.22. С0.L2с: 130). Босоо амсартай ваарны хагархай бөгөөд амсрын доохон талд зэрэгцүүлэн нэвт нүх гаргасан байжээ. Шатаалт муу бөгөөд шаврын найрлагыг жижиг чулууны үйрмэгээс салгаж цэвэрлэлгүй хийсэн байна.

2с үеийн доод тал цайвар шаргал хөрстэй зах нийлэх хэсгээс олдвор, эд өлгийн зүйл нэлээд гардаг бөгөөд өмнөх жилийн малтлагаар сууцны шалны хэсэг илэрч олдсон юм. Тиймээс бид энэ үеийн L2с floor хэмээн тэмдэглэж баримтжуулсан (Хүснэгт 8).

Хусуурын нэгийг ялтас, бусдыг залтсаар хийжээ. Төгсгөл ирмэгийг нь босоо холтчин ирлэж зассан нийтлэг байдалтай.

Ирлэсэн ялтас нь дунд хэсгийн хугархай юм. Бусад чулуун эдлэлүүд ялтас, ялтасны хугархай болон үйлдвэрлэлийн явцад бий болсон цуулдас юм.

Хээ чимэглэлгүй нимгэн ваарны хагархай шатаалт муутай. Гэхдээ гадар дээр хар өнгөтэй хөө ис тогтсон нь сонирхолтой бөгөөд цаашид лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийх эх хэрэглэгэдхүүн юм.

Хүснэгт 8. C0 өргийн 2c floor үеэс илрүүлсэн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Техникийн цуулдас	1	TB13.C0.L2c.floor.30
Хусуур	2	TB13.C0.L2c.floor.21;TB13.C0.L2c.floor.screen
Илэсэн ялтас	1	TB13.C0.L2c.floor. screen
Ялтас	1	TB13. C0.L2c floor.22
Ялтасны дээд хэсгийн хугархай	7	TB13.C0.L2c.floor. screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	8	TB13.C0.L2c.floor. screen
Ялтасны үзүүр	3	TB13.C0.L2c.floor. screen
Залтас	10	TB13. C0.L2c floor.27, 10; TB13.22.C0.L2c floor. Screen
Хагархай, хэлтэрхий	3	TB13.C0.L2c.floor. screen
Нийт	36	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	3	TB13.C0.L2c.floor.97, 101, screen
Хээтэй шаврын хагархай	1	
Шаврын хагархай	23	TB13.C0.L2c.floor. Screen
Нийт		
Ясан эдлэл		
Ясан сүлбээрийн үзүүрийн хугархай	1	TB13.22. C0.L2c floor: 1
Ясан зүүний хугархай	1	TB13.22. C0.L2c floor: Screen

Ясан сүлбээрийн үзүүрийн хугархай. (TB13.22. C0.L2c floor: 1). Хоёр тал нь хавтгайдуу, мөлгөр хажуутай, хурц шовх үзүүртэй сүлбээрийн хугархай юм. Дээд тал нь хугарч алга болжээ. Бүхэлд нь зүлгэх аргаар хийсэн байна.

Ясан зүүний хугархай. (TB13.22. C0.L2c floor: Screen). Гадрыг нь зүлгэж өнгөлсөн нарийн зүүний дунд хэсгийн хугархай юм.

C0 өргийн малтлагын зүүн урд булан буюу D0 өрөгтэй нийлэх хэсгээр хэд хэдэн галын ором илрүүлсэн. Түүнчлэн өмнө нь Тамсагбулагийн бусад газарт хийсэн малтлагад ч ажиглагдаж байсан галын ормын хажуугаас илэрдэг зурвас шаргал хөрс мөн мэдэгдэв. Ийнхүү гал түлсэн газрын ойр орчмоос хэдэн удаа илэрсэн тул гал голомттой холбоотой байгууламжийн үлдэгдэл болов уу гэсэн таамаглал үнэнд илүү нийцэж байна. C0 өргийн 2b, 2c давхаргын заагаас илэрсэн

нэг сонирхолтой олдвор бол анхны тавилтаараа буй нохойн бүтэн яс юм. Нохойг баруун хажуугаар нь тавихдаа хоншоороор нь зүүн тийш чиглүүлжээ (Зураг 4).



Зураг 19. C0 өргөөс илрүүлсэн нохойн яс

Нохойн ясны эргэн тойрноос хагачиж хугалсан амьтны яс, шавар ваар савны хагархай олон тоогоор олдсон. Чухам зориуд хийсэн оршуулга уу? эсвэл үхсэн амьтныг энд авчирч орхисон уу гэдэг одоогоор тодорхойгүй байна.

C0 өргийн малтлагыг гүйцэтгэх явцад ялзмаг бүхий хар хөрсний зааг ялгараагүй тул бид A0, B0, C0, D0 өргийг зүүн тал руу 250 см сунгасан бөгөөд 0 болон – 1 өргийн хооронд 50 см зузаан хамар үлдээж сунган малтав.

Өнгөн хэсгийн буюу 1-р давхаргын хөрсийг хар ялмаг бүхий бараан өнгөтэй давхаргын хамт хусаж авсан (Хүснэгт 9). Чулуун зэвсгийн олдворын дотор үлдэц 1 бий. Тэр нь нямбайлан гаргасан тэгш цохилтын талбайтай, эргэн тойрон бичил ялтас цуулж авсан ором бүхий цуулалтын гадаргуутай ажээ. Түүнийг дахин засах явцад хагарсан бололтой.

Хусууруудыг бүгдийг жижгэвтэр залтсаар бэлтгэсэн бөгөөд төгсгөл хусуурын ангилалд хамаарна.

Хүснэгт 9. C – 1 өргийн 1, 2-р давхаргын дээд үеийн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Үлдэц	1	TB13.C0.surface and L2. Screen
Хусуур	5	TB13.C0.surface and L2. Screen
Илэсэн ялтас	3	TB13.C0.surface and L2. Screen

Ялтас	2	TB13.C0.surface and L2. Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	9	TB13.C0.surface and L2. Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	20	TB13.C0.surface and L2. Screen
Ялтасны үзүүр	5	TB13.C0.surface and L2. Screen
Залтас	26	TB13.C0.surface and L2. Screen
Хайрс	7	TB13.C0.surface and L2. Screen
Хагархай, хэлтэрхий	46	TB13.C0.surface and L2. Screen
Нийт	124	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	7	TB13.C0.surface and L2. Screen
Шавар эдлэл	2	TB13.C0.surface and L2. Screen

Иртэй ялтаснууд дунд хэсгийн хугархай юм. Нэг болон хоёр ирмэгт нь нарийн ир гаргажээ.



Зураг 20. Малтлагыг зүүн тийш тэлсэн байдал

Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд 2b үеэс цөөн тооны олдвор илрүүлсэн бөгөөд дугуй хэлбэртэй нүхний толбо 2 ч илрэв. Энэ хэсэгт харьцангуй дээд талаас цайвар шаргал хөрс илэрлээ. Ингэснээр бид ялзмаг бүхий хар хөрсний хязгаарыг тогтоов.

2b үеийн малтлагаас илэрсэн чулуун зэвсгийн дотор ялтасны цохилтын талбайн үлдэгдэл бүхий дээд хэсгийг тайрч, үзүүрийг нь нүүрэн талаар хурцлан үзүүрлэж хийсэн цоолтуур, хоёр ирмэгийн араас жигд холтчин ирлэсэн ялтас зэрэг

хоёрдогч боловсруулалт хийсэн эдлэл илрүүлжээ. Бусад нь ялтас, залтас хагархай юм (Хүснэгт 10).

Энэ үеэс илрүүлсэн нэг сонирхолтой эдлэл бол галт уулын гаралтай нэлээд сийрэг бүтэцтэй чулуулгаар хийсэн үзүүл чулуу юм. Жижиг хэмжээтэй агаад төдийлэн хэрэглээгүй бололтой.

Хүснэгт 10. С. – 1 өргийн 2b үеийн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Цоолтуур	1	ТВ13. С. – 1.L2b.Screen
Илэсэн ялтас	1	ТВ13. С. – 1.L2b.Screen
Үрүүл чулуу	1	ТВ13. С. – 1.L2b. 45
Ялтас	1	ТВ13. С. – 1.L2b.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	2	ТВ13. С. – 1.L2b.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	2	ТВ13. С. – 1.L2b.Screen
Ялтасны үзүүр	5	ТВ13. С. – 1.L2b.Screen
Залтас	12	ТВ13. С. – 1.L2b.Screen
Хагархай, хэлтэрхий	15	ТВ13. С. – 1.L2b.Screen
Нийт		
Шавар эдлэл		
Хатуурсан шаврын хэлтэрхий	98	

Бид малтлагыг цааш үргэлжлүүлэхэд цайвар шаргал хөрс гарч ирсэн бөгөөд өмнөх үеэс гарсантай адил хатууруулж биежүүлсэн шаврын хагархайн гадрыг зурчиж чимэглэсэн баримт илрүүлэв.

Малтлагын талбайн D. – 1 өргийн өнгөн хэсгээс 308 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсний ихэнх хагархай, хэлтэрхий юм (Хүснэгт 11).

Олдворын дотор үлдэц 1 буй нь жижиг хэмжээтэй агаад шаантган цуулалтын арга барилаар ялтас цуулж авчээ.

Хусуур олон буйн нэг нь тамсаг хэлбэртэй, нимгэн. Бусад нь ялтас, залтсаар хийсэн хусуур юм.

Тэгш хэмтэй ялтасны хоёр ирмэгийг нүүрэн талаас нь жигд холтчин ирлэсэн эдлэл 2 бий.

Хүснэгт 11. D. – 1 өргийн 2b үеийн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Үлдэц	1	ТВ13. D. – 1.L1.Screen
Тамсаг хусуур	1	ТВ13. D. – 1.L1.Screen
Хусуур	3	ТВ13. D. – 1.L1.Screen

Ирлэсэн ялтас	2	TB13. D. – 1.L1.Screen
Ялтас	3	TB13. D. – 1.L1.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	14	TB13. D. – 1.L1.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	28	TB13. D. – 1.L1.Screen
Ялтасны үзүүр	8	TB13. D. – 1.L1.Screen
Залтас	11	TB13. D. – 1.L1.Screen
Хайрс	9	TB13. D. – 1.L1.Screen
Хагархай, хэлтэрхий	228	TB13. D. – 1.L1.Screen
Нийт	308	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	1	

D. – 1 өргийн 1-р давхаргын доороос нимгэн хар хөрс гарсан бөгөөд ялзмаг бүхий хар хөрсний зүүн урд зах энэ хүрч дуусаж буй нь тодорхой болсон юм.

Тиймээс бид бусад – 1 өргүүдэд малтлага судалгааг гүйцэтгэв. Энд С. – 1 өргийн хар хөрсний түвшинд В. – 1 өргөөс 570 ш чулуун зэвсгийн олдвор, ваарны хагархай 4, хясааны хэлтэрхийн хамт илрүүлэв (Хүснэгт 12).



Зураг 21. С. – 1, D. – 1 өргөөс илрүүлсэн шатаасан шавар эвлэл

Чулуун зэвсгийн олдворын бүрдэлд жижиг хэлтэрхий маш олон байна. Ирлэн засаж хоёрдогч боловсруулалт хийсэн цөөн эдлэл нь хусуур, хагархайгаар хийсэн

хянгар, иртэй ялтасны дунд хэсгийн хугархай юм. Ваарны хагархай шатаалт муутай, жижиг хэмжээтэй ажээ.

Хүснэгт 12. В. – 1 өргийн 1-р давхаргын олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Хусуур	5	ТВ13. В. – 1.L1.Screen
Хянгар	1	ТВ13. В. – 1.L1.Screen
Ирлэсэн ялтас	1	ТВ13. В. – 1.L1.Screen
Ялтас	2	ТВ13. В. – 1.L1.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	13	ТВ13. В. – 1.L1.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	47	ТВ13. В. – 1.L1.Screen
Ялтасны үзүүр	13	ТВ13. В. – 1.L1.Screen
Залтас	49	ТВ13. В. – 1.L1.Screen
Хайрс	21	ТВ13. В. – 1.L1.Screen
Хагархай, хэлтэрхий	418	ТВ13. В. – 1.L1.Screen
Нийт		
Шавар эдлэл		
Ваарны хагархай	4	ТВ13. В. – 1.L1.Screen
Ясан эдлэл		
Хясааны хагархай	1	ТВ13. В. – 1.L1.Screen



Зураг 22. Малтлагын талбайн зүүн хэсэг сунгасан – 1 өргийн малтлага.

Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд 2-р үеэс 100 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлэв (Хүснэгт 13). Зэрэгцээ цуулалтаар тэгш хэмтэй олон ялтас цуулж авсан үлдцээс бусад нь ялтас, залтас, хагархай хэлтэрхий юм.

Хүснэгт 13. В. – 1 өргийн 2-р давхаргын олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Үлдцийн хагархай	1	TB13. В. – 1.L2.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	4	TB13. В. – 1.L2.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	11	TB13. В. – 1.L2.Screen
Ялтасны үзүүр	6	TB13. В. – 1.L2.Screen
Залтас	17	TB13. В. – 1.L2.Screen
Хайрс	9	TB13. В. – 1.L2.Screen
Хагархай, хэлтэрхий	52	TB13. В. – 1.L2.Screen
Нийт	100	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	14	TB13. В. – 1.L2.Screen
Шаврын хагархай	7	TB13. В. – 1.L2.Screen

Малтлагын талбайн зүүн хойд хэсгийн А. – 1 өргийн малтлага мөн үүнтэй адил. Энэ өргийн малтлагын эхний үе буюу хар хөрсний дээд талын элсэн хөрснөөс 177 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлэв (Хүснэгт 14). Өнгөн хэсгийн олдворын дотор жижиг залтсаар хийсэн дугуй хусуур, нэлээд зузаан ялтасны дунд хэсгийг араас нь холтчин ирлэсэн зуулга маягийн эдлэлээс бусад нь цуулдасны үйлдвэрлэлийн төрөлд хамаарна.

Хүснэгт 14. А. – 1 өргийн 1-р давхаргын олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Хусуур	4	TB13. А. – 1.L1.Screen
Ирлэсэн ялтасны хугархай	2	TB13. А. – 1.L1.Screen
Ялтас	2	TB13. А. – 1.L1.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	6	TB13. А. – 1.L1.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	12	TB13. А. – 1.L1.Screen
Ялтасны үзүүр	7	TB13. А. – 1.L1.Screen
Залтас	19	TB13. А. – 1.L1.Screen
Хайрс	8	TB13. А. – 1.L1.Screen
Хагархай, хэлтэрхий	117	TB13. А. – 1.L1.Screen
Нийт	177	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	1	TB13. А. – 1.L1.Screen



Шаврын хагархай	2	ТВ13. А. – 1.Л1.Screen
Шавар бөмбөлөг	1	ТВ13. А. – 1.Л1.Screen
Ясан эдлэл		
Хясааны хэлтэрхий	1	

*Шавар бөмбөлөг.* Өмнө С0 өргөөс гарсантай адил нарийн ширхэгтэй шаврыг бөөрөнхийлөөд шатаан хатууруулсан, жижиг хэмжээтэй.

Малтлагыг үргэлжлүүлэхэд 2-р үеийн дээд талаас буюу ялзмаг бүхий хар хөрсний дээд хэсгээс 54 ш чулуун зэвсгийн олдвор, ваарны хагархайг амьтны ясны хамт илрүүлсэн (Хүснэгт 15).



Зураг 23. Ясан зүү

Зэв. Цайвар өнгөтэй цахиурлаг чулуугаар хийсэн, гурвалжин хэлбэртэй. Тэгш суурьтай бөгөөд хажуу ирмэгээс төв рүү чиглүүлэн нимгэн холтчин тэгш хурц ирмэг бий болгожээ. Суурийг мөн нимгэлэн зассан байна. Тамсагбулагийн дурсгалт газарт

өмнө нь хийсэн малтлагаас ялтсан зэв, ясан зэв илэрч олдож байсан бол энэ удаад неолитын дундаас хойших үеийн үйлдвэрлэлийн арга барилыг илтгэх хоёр талт сумны зэв олдсон нь сонирхолтой байна.

Хүснэгт 15. А. – 1 өргийн 2-р үеийн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Зэв		ТВ13. А. – 1.L2.1
Ирлэсэн ялтасны хугархай	1	ТВ13. А. – 1.L2.Screen
Ялтас	1	ТВ13. А. – 1.L2.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	5	ТВ13. А. – 1.L2.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	11	ТВ13. А. – 1.L2.Screen
Ялтасны үзүүр	2	ТВ13. А. – 1.L2.Screen
Залтас	15	ТВ13. А. – 1.L2.Screen
Хайрс	7	ТВ13. А. – 1.L2.Screen
Хагархай, хэлтэрхий	11	ТВ13. А. – 1.L2.Screen
Нийт	54	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	6	ТВ13. А. – 1.L2.Screen

Харин 2b үеийн малтлагаас 52 ш чулуун зэвсгийн олдвор, 22 ваарны хагархай, галд шатсан шаврын бутарсан хагархай 11 илрүүлсэн (Хүснэгт 16). Чулуун зэвсгийн бүрдэлд буй хусуур зэвсэг хэмжээгээр жижиг бөгөөд босоо иртэй, дугуй хэлбэртэй.

Ахуйн хэрэглээний шавар сав суулга шатаалт нэлээд муу юм. Гэвч зарим эдлэлийн гадар дээр таарны ор үлдэж хоцорсон байна.

Хүснэгт 16. А. – 1 өргийн 2b-р үеийн олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Хусуур	2	ТВ13. А. – 1.L2b.Screen
Ялтас	1	ТВ13. А. – 1.L2b.Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	7	ТВ13. А. – 1.L2b.Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	8	ТВ13. А. – 1.L2b.Screen
Ялтасны үзүүр	6	ТВ13. А. – 1.L2b.Screen
Залтас	7	ТВ13. А. – 1.L2b.Screen
Хагархай, хэлтэрхий	21	ТВ13. А. – 1.L2b.Screen
Нийт	52	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	22	ТВ13. А. – 1.L2b.Screen
Шатаасан шаврын хагархай	11	ТВ13. А. – 1.L2b.Screen
Яс		
Хясааны хэлтэрхий	1	

Хөр хөрсний хойд хязгаарыг бид А өргийн дунд хэсгээр хязгаарлагдаж байна хэмээн өнгөрсөн жил үзсэн юм. Гэвч үүнийг илүү тодорхой болгох, зүүн хойд хэсгийг гаргаж ирэхийн тулд А0 өргийг нэмж малтсан юм. Газрын өнгөн хэсгийн цэвэрлэх явцад 70 чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн (Хүснэгт 17). Хоёрдогч боловсруулалт хийж зэвсэг болгон хувтиргасан 2 эдлэл буй нь хусуур юм. Нэг нь төгсгөл хусуур бөгөөд ялтсаар хийжээ. Нөгөөх нь хажуугийн хусуур бололтой.




Зураг 24. Малтлагын талбайн зүүн хэсэгт хар хөрсний зааг ялгарч мэдэгдэж буй нь

Хүснэгт 17. А0 өргийн хөрсөн дээрх олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Хусуур	2	TB13. A0.Surface. Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	2	TB13. A0.Surface. Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	15	TB13. A0.Surface. Screen
Ялтасны үзүүр	1	TB13. A0.Surface. Screen
Залтас	14	TB13. A0.Surface. Screen
Хайрс	4	TB13. A0.Surface. Screen
Хагархай, хэлтэрхий	32	TB13. A0.Surface. Screen
Нийт		

Өнгөн хэсгийн олдворын авсны дараа 1-р үеийг малтлахад 97 ш чулуун зэвсгийн олдор илрүүлсэн (Хүснэгт 18). Ихэнх нь жижиг хэмжээтэй бөгөөд чулуун зэвсэг цуулалтын явцад гарсан байна. Хусуурын нэг нь залтсаар хийсэн бөгөөд цохилтын талбайн үлдэгдэл бүхий хэсгийг тайрсны дараа хоёр ирмэгийг нь босоо холтчин ирлэжээ. нөгөөх нь өргөн залтасны нэг булаг налуулан ирлэсэн булангийн хусуурын төрөлд хамаарна. Тэгш хэмт ялтасны нэг ирмэгийг жигд бус холтчин ирлэжээ.



Зураг 25. Тамсабулаг 13 дурсгалын дэвсгэр зураг

Хүснэгт 18. А0 өргийн хөрсөн 1-р үеийн дээрх олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
----------------	-----	--------

Чулуун зэвсэг		
Хусуур	2	TB13. A0.L1. Screen
Ирлэсэн ялтас	1	TB13. A0.L1. Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	4	TB13. A0.L1. Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	14	TB13. A0.L1. Screen
Ялтасны үзүүр	1	TB13. A0.L1. Screen
Залтас	17	TB13. A0.L1. Screen
Хайрс	8	TB13. A0.L1. Screen
Хагархай, хэлтэрхий	50	TB13. A0.L1. Screen
Нийт	97	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	1	TB13. A0.L1. Screen
Шатаасан шаврын хагархай	1	TB13. A0.L1. Screen

2-р үед малтлагыг үргэлжүүлэхэд 147 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн (Хүснэгт 19). Мөн л өмнөх үеийн адил олонх нь цуулдасны үйлдвэрлэлд хамаарах хагархай хэлтэрхий, залтас юм. Харин ялтасны хоёр ирмэгийг төгсгөл торгон үзүүр хүртэл нь жижгээр нямбай холтчин ирлэсэн нэг эдлэл бий. Ялтасны дээд хэсэг буюу цохилтын тоьгорыг тайрч авсан нь ишинд суулгахад дөхөм болгосны илэрхийлэл юм. Цоолтуурын үүргээр ашиглаж байсан бололтой.



Зураг 26. TB13 малтлага ба илэрсэн олдвор

Хүснэгт 19. А0 өргийн хөрсөн 2-р үеийн дээрх олдворын жагсаалт

Олдворын төрөл	Тоо	Дугаар
Чулуун зэвсэг		
Хусуур	2	TB13. A0.L2. Screen
Ирлэсэн ялтас	1	TB13. A0.L2. Screen
Ялтасны дээд хэсгийн хугархай	7	TB13. A0.L2. Screen
Ялтасны дунд хэсгийн хугархай	16	TB13. A0.L2. Screen
Ялтасны үзүүр	7	TB13. A0.L2. Screen
Залтас	27	TB13. A0.L2. Screen
Хагархай, хэлтэрхий	87	TB13. A0.L2. Screen
Нийт	147	
Шавар эдлэл		
Ваарны хагархай	10	TB13. A0.L2. Screen
Шатаасан шаврын хагархай	10	TB13. A0.L2. Screen

Малтлагын талбайн зүүн, зүүн хойд, хойд талын өргүүдийг малтсанаар хар хөрсний заагийг тогтоож чадсан юм. Харин урд тал нь С, D заагаар тодорхой мэдэглэж байсан бөгөөд өмнөх жил малтан судалсан ТВ 13 дурсгалтай адил галын ором нь өмнө, зүүн өмнө талдаа байрлаж буй нь анхаарал татаж байна.

Хар хөрсний баруун өмнөд зах төдийлэн тодорхойгүй байсан тул бид өмнө жил малтсан С1, D1 өргийг баруун тийш нь 2 м сунган С2, D2 хэмээн тэмдэглэж баримтжуулав. D2 өргөөс хар хөрс илрээгүй бөгөөд С2 өргийн дундуур зах нь байгааг тогтоосон юм.

С2 өргийн малтлагын газрын өнгөн хөрсөн дээрээс 11 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлсэн нь төрөл зүйлийн хувьд яотасны цохилтын талбайн үлдэгдлийг тайрч, үзүүрийг нь ташуу хугалан хурцлан засса сийлүүр, тэгш хэмт ялтасны дунд хэсгийн хугархай 2, үзүүрийн хугархай 1, залтас 4, хэлтэрхий 3 хэмээн ангилагдана.

Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд 2b үеэс 30 ш чулуун зэвсгийн олдвор илрүүлэв. Тэдгээр нь залтсаар хийсэн дугуй хусуур, ялтасны дунд хэсгийн хугархай 5, үзүүрийн хугархай 3, залтас 5, хагархай хэлтэрхий 16 юм. Мөн шавар ваарны шатаалт муу жижиг хагархай 2 гарсан байна.

2b үеийн доор плейстоцены үеийн цайвар шаргал хөрстэй хар хөрс нийлэх хэсгийг бид 2с floor хэмээн тэмдэглэсэн бөгөөд эндээс тэгш хэмт жижиг ялтасны дунд хэсгийн хугархайн нэг ирмэгийг жижгээр холтчин ирлэсэн эдлэл, тэгш бус хэмтэй бүтэн ялтас 3, дээд хэсгийн хугархай 3, дунд хэсгийн хугархай 3, үзүүрийн

хугархай 2, залтас 5, хагархай 3 гарсан байна. мөн шатааж хатууруулсан шаврын хагархай 15 ш, ваарны хэлтэрхий 5 ш илэрчээ.

Ваарны хагархай жижиг бөгөөд шатаалт муу. 2-р үеийн доороо шууд цайвар шаргал хөрс илэрсэн нь олдвор эд өлгийн зүйл гарсангүй.

Хамтарсан төслийн судлаачид Тамсагбулагийн дурсгалт газарт 2021 онд эхлүүлсэн малтлагаа үргэлжлүүлэн гүйцэтгэж амжилттай дуусгав. Бид ТВ13 дурсгалын мөстлөгийн дараах үеийн ахуй амьдралын ул мөрийг хадгалсан ялзмаг бүхий хар шороон хөрсийг хөөж малтсанаар тухайн газарт амьдарч асан хүмүүсийн оромж сууцны үлдэгдлийг илрүүлэн баримтжуулж, дараагийн лабораторийн судалгааны чухал хэрэглэгдэхүүнийг бий болгосон юм.

### 3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитын судалгаа” төслийн баг 2022 оны хээрийн судалгааны улиралд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уул, Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринд өмнөх жилүүдийн судалгааг үргэлжүүлэн амжилттай гүйцэтгэв.

Зараа уулын Оцон цохионы сууринд хийсэн малтлагаас олон тооны чулуун зэвсгийн олдвор, амьтны яс илрүүлэв. Энэ жилийн малтлагаас леваллуагийн цуулалтын арга барилыг илэрхийлэх үлдэц, бэлдэц олдоогүй боловч нэлээд эртний хэв шинжтэй таргил үлдэц, дээд палеолитын эхэн үеийн үйлдвэрлэлийн арга ажиллагааг тодорхой харуулах зэрэгцээ цуулалтын зарчимд үлдэц болон бичил цуулалтад үлдэц илрүүлсэн.

Гэвч леваллуагийн залтас, леваллуагийн технологийг илэрхийлэх ялтас хэд хэдэн гарсан нь дээд палеолитын эхэн үеэс гарч ирсэн зэрэгцээ цуулалтын арга уламжлалт леваллуагийн технологитой хамт чулуун зэвсэг үйлдвэрлэлд ашиглагдаж байсны баримт болж байна.

Оцон цохионы палеолитын дурсгалын үлдцийн өөр нэг төрөл бол зэрэгцээ цуулалтын арга барилт эдлэлүүд юм. Энэ жилийн малтлагаас зэрэгцээ цуулалтад үлдэц 9 илрүүлээд байна.

Тэдгээрийн зарим нь хэмжээгээр жижиг бөгөөд дээд палеолитын хожуу үед холбогдох боломжтой. Харин арагшаа налуу, нарийн цохилтын талбай, нэг талдаа хавтгайдуу цуулалтын гадаргуу бэлтгэсэн том хэмжээтэй үлдэц дээд палеолитын эхэн үеийн арга барилаар бэлтгэгдсэн бөгөөд цуулалтын гадаргуу нь зэрэгцээ цуулалтаар ялтас салган авсан ул мөрийг хадгалдсан ажээ.

Хэв шинж, цуулалтын арга барилын хувьд дээр дурдсан үлдцүүдтэй адилсах эдлэл Сэлэнгэ мөрний дунд урсгалын Төлбөр-4, 15, 16, 21, Төв Монголын нутаг дэвсгэр дэх Цацын эрэг-2 зэрэг олон газраас илэрч олдсон бөгөөд он цагийн хувьд дээд палеолитын эхэн үед хамаатуулан үздэг.

Бичил ялтас авахад зориулагдсан үлдэцтэй адилсах эдлэл дээд палеолитын төгсгөл үед буюу Говь-Алтайн нурууны Чихэн агуй (stratum 3), Чихэн-2 (stratum 2,5)



дурсгалын дээд давхаргаас, Төлбөр-4; 15 дурсгалын 1-4-р давхаргаас олноор олдсон байдаг. Их Төлбөрийн голын дурсгалуудаас тэмээн хяруулын өндөгний хальсны хэлтэрхий олноор олдсон бөгөөд Төлбөр-4 дурсгалын 3-р давхаргаас илэрсэн тэмээн хяруулын өндөгний хальсанд хийсэн радикарбоны шинжилгээгээр  $14,547\pm 73$  (AA-93139), Төлбөр-15 дурсгалын 3-р давхаргаас илэрсэн тэмээн хяруулын өндөгний хальсанд хийсэн радикарбоны шинжилгээгээр  $14,056\pm 81$  (AA-84136) and  $14,930\pm 70$  (Beta-263742), 4-р давхаргаас илэрсэн тэмээн хяруулын өндөгний хальсанд хийсэн радикарбоны шинжилгээгээр  $14,680\pm 70$  (Beta-263744) and  $14,820\pm 70$  (Beta-263745) тэртээд холбогдож байна. Монголын дээд палеолитын хожуу үеийн чулуун зэвсгийн үйлдвэрлэлд бүс нутгийн ялгаа мэдэгддэггүй. Ерөнхийдөө бичил ялтас шахалтын аргаар гарган авах технологид суурилсан нийтлэг байдал ажиглагдах бөгөөд цаашдаа голоцены үед уламжлагдсан байна.

Энэ жилийн малтлагаас хоёрдогч боловсруулалт хийсэн багаж зэвсгийн зүйл тун цөөн илэрчээ. Цоолтуур зэвсэг, шүдлэг хүнхэр ирт зэвсэг, шүдлэг ирт зэвсэг, ирлэсэн ялтас зэрэг нь багаж зэвсгийн төрөл зүйлийг бүрдүүлж байгаа юм.

Дээрхээс үзэхэд, Оцон цохионы палеолитын суурин багаж зэвсгийн төрөл зүйлийн хувьд баялаг бус юм. Өмнөх судалгаа болон энэ жилийн малтлагаас харахад, дээд палеолитын хэв шинжийг илэрхийлэх ялтсыг ирлэх замаар багаж зэвсгийн зүйлийг хийж байжээ. Бүтэн ялтас, ялтасны хугархай олон буй нь чулуун зэвсгийн үйлдвэрлэлд ялтсан цуулалтын технологи давамгайлах болсныг илтгэж байна.

Оцон цохионы дурсгалт газар хийсэн малтлагаас чулуун зэвсгээс гадна олон тооны амьтны яс гарсан бөгөөд тэдгээрийн зарим нь урьд өмнө нь манай орны нутгаас олдоогүй шинэ төрөл зүйл юм.

Оцон цохионы сууринд 2018 онд хийсэн сорилын малтлагаас савагт хирсний далны яс илрүүлж байсан бол энэ жил нэлээд сайн хадгалагдсан чөмөгний хугархай гарав.

Сүүлийн хэдэн жилийн дотор Монгол орны зүүн болоод зүүн өмнөд бүс нутаг дээд палеолитийн эхэн үед хүмүүсийн хоол хүнсний гол эх булаг болсон олон зүйлийн ан амьтдаар баялаг газар нутаг байсан байж болох тухай хэд хэдэн баримт олдсон юм. Үүний нэг нь, Хэнтий аймгийн төвд барилгын ажлын явцад

санамсаргүйгээр илрүүлсэн савагт хирсний бүтэн араг яс бөгөөд он цагийн хувьд BP 42050-39450; BP 41970-39350 жилийн өмнөх үед буюу дээд палеолитын эхэн үед хамаарах нь тогтоогдсон байна.

Мөн манай төслийн судалгааны хэсэг Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын Тойг толгой хэмээх газраас хөрсөн дээр чулуун зэвсгийн олдвор, том амьтны ясны хэлтэрхий хамт тархсан нэгэн ил сууринг 2020 онд илрүүлсэн. Чулуун зэвсгийн олдворт тулгуурлавал, дээд палеолитын дунд, хожуу үед хамаарах магадлалтай. Энэ нь цаашид нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай дурсгал юм. Харин амьтны яс, ялангуяа, нэлээд чулуужсан хавирганы хэсэг нь савагт хирсний яс байх магадлалтай байна.

Энэ жилийн малтлагаас хэдийгээр гоёл чимэглэлийн зүйл гараагүй боловч тэмээн хяруулын засаж янзлаагүй өндөгний хальс нэлээд хэдийг илрүүлсэн.

Малтлагаас янз бүрийн хэмжээтэй улаан зос олон олдсоныг дэвсгэр зурагт баримтжуулсан. Оцон цохионы палеолитын дурсгалын орчимд улаан зосны орд байдаг тул эндэхийн палеолитын суурингийн зосны үлдэгдлийг хүний үйл ажиллагаа гэхээс илүүтэй байгалийнх байх магадлалтай. Гэхдээ дээд палеолитын үед холбогдох бууц суурингийн малтлагаас илэрдэг зосны үлдэгдлийг анхаарч үзэх, түүхий эдийн эх булаг нь хаана гэдгийг тогтоох, зөөвөрлөн авчирсан, эсэхийг анхаарах нь палеолитын судалгааны нэг асуудал юм. Тухайн үеийн хүмүүсийн хадны зураг зурах хэрэгсэл зосыг гоёл чимэглэл, шүтлэг, зан үйлийн үүднээс чухалчлан үзэж, зөөвөрлөн авчирдаг байх магадлалтай. Их Төлбөрийн голын хөндийд хийсэн дээд палеолитын бууц суурингийн малтлагаас зосны жижиг хэлтэрхий олон гарсны зэрэгцээ зүүлт чимэглэлийг улаан зосоор будсан ор мэдэгдсэн нь эрхгүй анхаарал татаж байгаа юм.

Түүнчлэн малтлагын талбайн баруун хэсгээс хүнийхтэй ихэд төстэй хөлийн хурууны яс, холбогч яс хэд хэд гарсан. Антропологичийн үзэж буйгаар энэ нь хүнийх биш бөгөөд мазаалайнх байх магадлалтай ажээ. Цаашид үүнийг лавшруулан судлах бөгөөд уур амьсгалын хувьд орчин цагийн говийн бүс нутгаас эрс ялгаатай нөхцөлд ойт хээр болон ойн бүсэд амьдрах зохилдолгоотой олон төрөл зүйл амьтадтай мазаалай зэрэгцэн амьдарч, эртний анчин, түүвэрлэгчдийн ан гөрөөний нэг болж байв уу? гэдэг нь сонин байна.

Зараа уулын палеолитийн дурсгал нь тухайн бүс нутгийн чулуун зэвсэг үйлдвэрлэлийн арга технологийг тодруулах, дөрөвдөгчийн сүүл үеийн амьтны аймаг, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг дагасан хүний нүүдэл зэрэг өдгөө бүрхэг хэвээр буй өвөг түүхийн олон асуултад хариулт өгөхөд бодит хэрэглэгдэхүүн болно хэмээн найдаж байна.

Хамтарсан төслийн багийн судалгааны нэг гол талбар бол Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн суурин юм. Энэ жилийн малтлага судалгааны үр дүнд мөстлөгийн дараах үеийн ахуй амьдралын ул мөрийг хадгалсан хар бараан өнгөтэй ялмагжсан хөрс 700 x 700 см орчим талбайд тэгш өнцөгт маягийн хэлбэр үүсгэн тогтсон нь тодорхой болсон. Энэ давхаргын дээд хэсэг баруун хойд буюу газрын налуу тал руу нэлээд урсаж гулссан нь анзаарагдав. Газрын өнгөн хэсэг 5-8 см зузаан элсэн хурдаснаас тогтох ба түүний доороос дээр өгүүлсэн ялмагжсан бараан өнгөтэй шаварлаг хөрс илэрсэн.

40-50 см зузаан энэ давхарга доод талдаа цайвар шаргал өнгөтэй шаварлаг хөрсөн дээр тогтжээ. Хар бараан давхаргын дээд хэсгээс чулуун зэвсэг, шавар ваарны хагархайн хамт илрүүлсэн амьтны ясны хадгалалт тааруу байгаа нь газрын гадаргад ойр буйгаас шалтгаалсан бололтой. Хар бараан хөрсний дээд хэсэгт, талбайн зүүн өмнөд хэсгээс галын ором, шатсан хөрс, өмнөх жилийн малтлагаас илэрч байсантай адил цайвар шаргал зурвас хөрс гарсан юм. Малтлагыг цаашид үелэн гүйцэтгэхэд хөрс илүү тод бараан өнгөтэй болж, амьтны ясны олдворын хэмжээ томорч, хадгалалт нь сайжирч байв. Галын ормын орчмоос олон тооны хатуурсан шавар гарсны зэрэгцээ амьтдын ясан дотор адуу, үхэр, зээр, үнэгний яс голлож байна. Чулуун зэвсгийн олдворын төрөл зүйл хязгаарлагдмал, дахин ашиглах оролдлогын ул мөртэй зэрэг өмнөх жилийн малтлагаас онцын ялгаагүй.

ТВ 13 малтлагаас амьтдын яс хагачиж хугалсан байдалтай олддог. Харин С0 өргийн 2b, 2c давхаргын заагаас илэрсэн нохойн яс анхны тавилтаараа бүтэн байсан нь сонирхолтой юм. Нохойг баруун хажуугаар нь тавихдаа хоншоороор нь зүүн тийш чиглүүлсэн байв. Малтлагаас гарч буй олдворын ихэнх яс байгаагаас харахад, Тамсагбулагийн эртний оршин суугчдын хүнсэнд мах голлож байсан бололтой. Харин нохойн ясыг огт хугачиж хагалаагүй нь хүнсэнд хэрэглээгүйг илтгэж байна. Нохойн ясанд он цаг тогтоох С14 шинжилгээ хийлгэх бөгөөд архезоологийн

нарийвчлсан хэмжилтийг гүйцэтгэж байна. Хүннү, сяньби зэрэг хожмын нүүдэлчдийн оршуулгын ёслолд нохой оролцуулж байсан тухай сурвалжийн мэдээ, археологийн баримт хангалттай байгаа ч 7-8 мянган жилийн өмнөх үед холбогдох Тамсагбулагийн эртний оршин суугчид нохойн оршуулга үйлдэж байсан уу? эсвэл энэ тохиолдол уу? гэдэг одоогоор хараахан тодорхой болоогүй байна.

Малтлагаас ахуйн хэрэглээний шавар сав суулганы хагархай гарахын зэрэгцээ ясан сүлбээр, шор ахуйн үйлд зориулагдсан олдвор эд өлөг нэлээд байгаа нь тэнд сууц оромж байсныг илэрхийлж байна. Мөн ясаар хийсэн оёдлын зүү, зүүний хугархай зэрэг ахуйн хэрэглээний эд зүйл ч үүний баталгаа болно.

Хар ялзмаг хөрсний доор цайвар шаргал өнгөтэй шаварлаг хөрсөн дээр хэд хэдэн баганы нүхний дугуй ором илэрсэн нь энд модон тулгууртай сууц байсныг илтгэж байна. Харин тухайн үедээ хаягдаж орхигдож ихэд эвдэгдсэн тул бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй болжээ.

#### 4. НОМ ЗҮЙ

Амартүвшин нар., 2012 – Амартүвшин Ч., Батболд Н., Эрэгзэн Г., Базаргүр Д., Эрдэнэ Б., Амгалантөгс Ц., Галдан Г., Буянхишиг Ц., Дашдорж Б., Пүрэвжал Х. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг дахь “Засаг Чандмань Майнз” ХХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Чандмань Хар уул” талбайд 2012 оны намар хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС.

Амартүвшин нар., 2013 – Амартүвшин Ч., Галдан Г., Одсүрэн Д., Бөхчулуун Д. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уул: Монгол-Америкийн хамтарсан “Дорнод Монгол: археологийн хайгуул судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС.

БНМАУ-ын., 1990 – Бүгд Найрамдах Монгол Ард Улсын үндэсний атлас. Минск, Таблица

Букинич, 1934 – Букинич Д.Д. Общий отчет по археологические работы за 1933-1934 г.г. Улаанбаатар. АХГБС.

Волков, 1975 – Волков В.В. Погребение в Норовлин уула (Монголия) // Археология Северной и Центральной Азии. – М.: Наука

Грубов В. И. 1982. Определитель у сосудистых растений. Л.: Наука, 441 с.

Гурван гол, 1990, 1991, 1992, 1993 - Gurvan Gol - Archaeological Research. A report on the joint investigation under the Mongolian and Japanese “Gurvan Gol” historic relic probe project. /1991-1993/. Tokyo.

Гүнчинсүрэн, 2000 – Гүнчинсүрэн Б. Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн он цагийн асуудлыг дахин авч үзэхэд // Археологийн судлал. Том. XX, fasc.2. Улаанбаатар.

Гүнчинсүрэн нар., 2012 – Гүнчинсүрэн Б., Базаргүр Д., Эрэгзэн Р., Алдармөнх П. Монгол-Солонгосын хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн 2012 оны хээрийн шинжилгээний тайлан. Улаанбаатар. АХГБС.

Гүнчинсүрэн нар., 2012 – Гүнчинсүрэн Б., И Сон Бук, Базаргүр Д., Ян Ши Өн, Эрэгзэн Г., И Жөн Өн, Ку Өн Бёл, Ким Жон Гин. Рашаан хадны дурсгалт газарт

хийсэн чулуун зэвсгийн малтлага судалгааны урьдчилсан үр дүн // Археологийн судлал. Том. XXXII, fasc. 1. Улаанбаатар.

Гүнчинсүрэн нар., 2018 – Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Изүхо М., Базаргүр Д., Одсүрэн Д., Изука Ф. Тарвагатайн амны палеолитийн сууринд хийсэн малтлага судалгааны ажлын үр дүн (2017 он) // Монголын археологи-2017. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар.

Дашням Б. 1974. Дорнод Монголын ургамлын аймаг, ургамалжилт. ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.

Доржсүрэн, 1957а – Доржсүрэн Ц. 1955 онд Төв ба баруун аймгуудад археологийн шинжилгээ хайгуулын ажил явуулсан тухай. ШУХБ. НУА. №2. Улаанбаатар.

Деревянко, 1970 – Деревянко А.П. Новопетровская культура Среднего Амура. Новосибирск

Дорж, 1969 – Дорж Д. Дорнод Монголын неолитийн үеийн булш сууц. // Шинжлэх Ухааны Академийн мэдээ. №3. Улаанбаатар.

Дорж, 1971 – Дорж Д. Неолит Восточной Монголии. Улан-Батор.

Ларичев и др., 1964 – Ларичев В.Е., Волков В.В. Мустиерские и неолитические памятники Южной Гоби <<Древняя Сибирь>> вып. 1 Новосибирск.

Мурзаев, 1952 – Мурзаев Э.М. Бүгд Найрамдах Монгол Ард Улс. (физик-газар зүйн тодорхойлолт) Улаанбаатар.

Намнандорж, 2003 – Намнандорж О. Бүтээлийн эмхтгэл. Улаанбаатар.

Одсүрэн Д., Бөхчулуун Д., Яанз Л., Розен А. “Говь, хээрийн бүсийн неолитийн судалгаа” төслийн 2016 оны хээрийн шинжилгээний ажлын үр дүн // Монголын археологи-2016. Улаанбаатар.

Одсүрэн нар., 2017 – Одсүрэн Д., Бөхчулуун Д., Яанз Л., Розен А. “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн 2017 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. ТАХБМТ

Одсүрэн нар., 2018 – Одсүрэн Д., Яанз Л., Бөхчулуун Д.. Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тухай // Монголын археологи – 2018. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар. 27-34

Окладников А.Д. Новые данные по древнейшей истории Внутренней Монголии. ВДИ, № 4.

Окладников и др., 1982 – Окладников А.П., Васильевский Р.С. Новые исследования Аршан хаде в Монголии. Изв. СО АН СССР. № 6, Вып. 2, Серия общественных наук. Новосибирск.

Цогтбаатар, 1994 – Цогтбаатар Б. Ханангийн чулуун зэвсгийн дурсгал // Археологийн судлал. Том. XIV, fasc.2, Улаанбаатар.

Цогтбаатар, 1998 – Цогтбаатар Б. Бугахайрханы хуучин чулуун зэвсгийн дурсгал // Археологийн судлал. Том. XVIII, fasc.4, Улаанбаатар.

Цогтбаатар нар., 2003 – Цогтбаатар Б., Амартүвшин Ч., Болдхуяг Д., Гантулга Ж., Эрдэнэ Б. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөдөө арал орчимд хийсэн археологийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС.

Эрдэнэ Б. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хөдөө арал орчимд хийсэн археологийн хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС.

Цогтбаатар нар., 2010 – Цогтбаатар Б., Болорбат Ц., Одсүрэн Д. Улаан хадны чулуун зэвүүд // Археологийн судлал. Том. (IX) XXIX, fasc.3. Улаанбаатар.

Цогтбаатар нар., 2012 – Цогтбаатар Б., Одсүрэн Д., Ишцэрэн Л. Монгол-Японы хамтарсан “Монголчуудын палеоантропологиян судалгаа” төслийн 2012 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. Улаанбаатар. АХГБС.

Цогтбаатар, Пүрэвжал, 2014 – Цогтбаатар Б., Пүрэвжал Х. Ачаат уулын чулуун зэвсгийн суурин // Археологийн судлал. Том. XXXIV, fasc.2. Улаанбаатар.

Цыденова и др 2012 – Цыденова Н.В., Тумэн Д., Эрдэнэ М. Древнее поселение Барга элс в Восточной Монголии // Древние Культуры Монголии и Байкальской Сибири. Улаанбаатар

Mania, 1963 – Mania D. Archäologische Studien in der zentralen Mongolei, Sonderdrucke aus der Wissenschaftlichen Zeitschrift der Martin-Luther-Universität Halle-Wittenberg. Heft 13.

Izuho, et al., 2005 – Izuho Masami, Tsogtbaatar Batmunkh, Tsurumaru Toshiaki. Mongol Tobu, Khenty Ken no Kyusekki Iseki Ipan Chosa Hokoku [Report of a Expedition of Paleolithic site at Khenty province, eastern Mongolia]. *Dai 6 Kai Kita Asia Chosa*

*Kenkyu Hokoku Kai Yokoshu [Abstracts for the 6th Annual meeting of the Research Association of the North Asia], pp.55-58. The Research Association of the North Asia, Tokyo. (In Japanese)*

Janz et al., 2021 – Janz L., Rosen A.M., Bukhchuluun D., Odsuren D. Zараа Uul: An archaeological record of Pleistocene-Holocene paleoecology in the Gobi Desert. // Plos ONE 16(4): e0249848. <https://doi.org/10.1371/journal.pone.0249848>

Payne, S., 1973. Kill-off patterns in sheep and goats: the mandibles from Asxvan Kale. Feng Li et al., 2018 – Feng Li, Steven L. Kuhn, Fuyou Chen, Yinghua Wang, John Southon, Fei Peng, Mingchao Shan, Chunxue Wang, Junyi Ge, Xiaomin Wang, Tala Yun, Xing Gao. The easternmost Middle Paleolithic (Mousterian) from Jinsitai Cave, North China. *Journal of Human Evolution* 114.





## Хавсралт 2. Албан томилолтын хуулбар

Монгол Улсын Боловсролын Их Сургууль



**АЛБАН ТОМИЛОЛТЫН  
ҮНЭМЛЭХ**

**ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ**

Хугацаа сунгах үндэслэл.....  
.....  
.....ажил  
гүйцэтгэх шаардлагын дагуу томилолтын хугацааг.....хоногоор сунгав.

Захирал .....

Дугаар-11

Тус сургуулийн Түүхийн тэнхимд багш ажилтай Д.Одсүрэнг албан ажлаар Сүхбаатар, Дорнод аймгуудад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 40 хоног ажиллуулахаар томилов.

МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль

Захирал  проф. Ж. Батбаатар

2022 он 06 дугаар сарын 06-ний өдөр

Томилолтоор ажилласан тухай тэмдэглэл

№	Хаана	Ирсэн	Буцсан	Гарын үсэг
7	Халхгол аймаг			

Албан томилолтын ажлыг дүгнэж зардлыг .....хувиар тооцоо хийхийг зөвшөөрсөн

/гарын үсэг/  
\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

### Хавсралт 3. Судалгааны ажлын удирдамжийн хуулбар

БАТЛАВ:  
МУБИС-ИЙН НХУС  
ИЙН ЗАХИРАЛ  
Ж.БАТБААТАР



#### “МОНГОЛЫН ГОВЬ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН НЕОЛИТЫН СУДАЛГАА” ТӨСЛИЙН 2022 ОНЫ ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН УДИРДАМЖ

2022.3.9.

##### Судалгааны зорилго:

Монгол орны говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалыг судалж холбогдох он цагийн хамаарлыг лабораторийн судалгаанд түшиглэн тодорхойлох, чулуун зэвсэг үйлдвэрлэлийн онцлог, эрхлэх аж ахуйн асуудлыг шинэ хэрэглэгдэхүүнээр баяжуулахад энэхүү төслийн зорилго оршино. Энэ оны хээрийн шинжилгээний ажлын зорилго нь Зараа уулын палеолитын суурингийн малтлага судалгааг үргэлжлүүлэх ба өмнөх судалгааны үр дүнг бататгах, шинэ эх хэрэглэгдэхүүн бий болгох; Монгол орны хээрийн бүс нутагт хамаарах Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн суурингийн нүхэн сууц байж болзошгүй хэсэгт археологи ба геоархеологийн судалгаа хийхэд чиглэгдэнэ.

##### Газарзүйн байршил:

1. Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уул (солбицол: N46 07 45.3 E111 42 33.3)-д малтлага судалгаа;
2. Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулаг (солбицол: N47 12 22.5 E117 21 57.5)-т малтлага судалгаа.

##### Судлагдсан байдал:

Говь, тал хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн дурсгалуудын судалгаа 1920-иод оноос эхэлжээ. 1922, 1923, 1925-1928 онуудад Р.Ч.Эндрюсийн удирдсан Америкийн “Төв Азийн экспедици” Монгол орны өмнөд болон баруун өмнөд хэсэгт ажиллаж, чулуун зэвсгийн олдвор тархсан олон дурсгалт газар илрүүлсний ихэнх шинэ чулуун зэвсгийн үед холбогдохыг судлаачид тэмдэглэсэн байна.

XX зууны эхэн үеийн Монголын томоохон сэхээтний нэг Д.Буддарь 1924 онд Дорнод аймгийн Халхгол сумын нутаг Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринг илрүүлсэн мэдээ байдаг бөгөөд 1949 онд А.П.Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги анхны эрдэм шинжилгээний тодорхойлолтыг хийжээ.

Устай, Бургастайн шинэ чулуун зэвсгийн томоохон дурсгалуудыг илрүүлсэн байна. 1960-1970-аад оны үед Монгол орны хээрийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн судалгаа харьцангуй эрчимтэй хийгдсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Бүрдийн баруун эрэг, Онгон элсний зүүн хэсэг, Онгон сумын төвийн баруун тал, Хонгор сумын Гүн булаг, наран сумын Эхэн ус, Дорнод аймгийн Хэрлэнгийн эргийн дурсгалууд, Овоот, Баруун, Зүүн Өлзийт, Дөрөө нуур, Ямаат нуур, Тогоот нуур, Мөнх толгой, Баруун шорвог нуур, Хүйтэн булаг зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлжээ. 1933-1934 онд археологич Д.Д.Букинич Халхын голын сав дагууд хайгуул хийж хэд хэдэн суурин илрүүлсэн мэдээ бий. 1949 онд Монгол-Зөвлөлтийн Түүх, Соёлын Хамтарсан экспедицийн чулуун зэвсгийн дурсгал судлах хэсэг Дорнод Монголын Хэрлэн, Халх голын сав, Буйр нуур орчмоор хайгуул судалгаа хийсэн бөгөөд Тамсагбулагийн дурсгалт газрыг илрүүлжээ. 1955 онд Монголын говийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн үед холбогдох томоохон дурсгал Дулааны говийн сууринг илрүүлсэн бөгөөд хожим 1978 онд дахин судалгаа хийжээ. 1954 онд О.Намнандорж

Сүхбаатар аймгийн Урт сумын нутаг Долир манхан, Их айлын манхнаас хас болон цахиур чулуугаар хийсэн шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий олдворууд түүвэрлэсэн байна. 1953-1955 онд Х.Пэрлээ Хэнтий аймгийн Гүрэмийн нуурын орчмоос шинэ чулуун зэвсгийн хэв шинж бүхий шавар ваарны хагархай, галын ором, чулуун зэвсгийн олдвор, Хэрлэнгийн баруун эрэгт орших Баянцогт овооноос шинэ чулуун зэвсгийн суурин илрүүлжээ. Мөн энэ үед нутгийн иргэдийн оролцоотойгоор Молцог элсний дурсгал, Устай, Бургастайн шинэ чулуун зэвсгийн томоохон дурсгалуудыг илрүүлсэн байна. 1960-1970-аад оны үед Монгол орны хээрийн бүс нутагт шинэ чулуун зэвсгийн судалгаа харьцангуй эрчимтэй хийгдсэн бөгөөд Сүхбаатар аймгийн Бүрдийн баруун эрэг, Онгон элсний зүүн хэсэг, Онгон сумын төвийн баруун тал, Хонгор сумын Гүн булаг, наран сумын Эхэн ус, Дорнод аймгийн Хэрлэнгийн эргийн дурсгалууд, Овоот, Баруун, Зүүн Өлзийт, Дөрөө нуур, Ямаат нуур, Тогоот нуур, Мөнх толгой, Баруун шорвог нуур, Хүйтэн булаг зэрэг газруудаас шинэ чулуун зэвсгийн дурсгал илрүүлжээ. 1967 онд МЗТСХЭ Чулуун зэвсгийн дурсгал судлах ангийн судлаачид Тамсагбулагт неолитын үеийн хагас газар сууц, цооног нүхэнд суугаа байдлаар оршуулсан булш оршуулга зэрэг сонирхолтой дурсгалыг малтан шинжилж, үр дүнг хэвлүүлсэн байдаг.

1990-ээд оны эхэн үед “Дорнод Монгол” төслийн хүрээнд Монгол, Солонгосын судлаачид Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Молцог элсний орчимд бага хэмжээний малтлага хийжээ. Монгол-Францын хамтарсан экспедици 1998 онд Тамсагбулагийн дурсгалт газарт ажиллажээ. Сүүлийн жилүүдэд МУИС-иас зохион байгуулсан “Дорнод Монгол” экспедицийн хүрээнд Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутаг Ваарт элс, Түвшинширээ сумын нутаг Тогоотын голд малтлага судалгаа хийж байна. Монгол-Америкийн хамтарсан “Говь, хээрийн бүсийн неолитын судалгаа” төслийн хүрээнд 2013 онд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Дарьганга сумын Молцог элс орчимд хайгуул судалгааг гүйцэтгэсэн бөгөөд Дэлгэрхаан уул орчимд Булагийн эхэн, Дунд булаг, Адагийн булаг, Тогоотын гол, Дэлгэрхаан уулын зүүн урд орших эртний нуурын савын ар, Зараа уул, Улаан зуух, Молцог элс орчимд Өлзийн булаг, Салаа булаг, Ганга нуурын зүүн эрэг, Сүмтийн нуур зэрэг газруудаас чулуун зэвсгийн дурсгалт газруудыг илрүүлсэн байна. Мөн 2015-2017 онуудад Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Зараа уулын шинэ чулуун зэвсгийн сууринд малтлага судалгааны ажил гүйцэтгэжээ.

2018 оноос Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн неолитийн судалгаа” төслийн хүрээнд Тамсагбулагт өргөн хэмжээтэй малтлага судалгааг эхлүүлсэн бөгөөд неолитын үеийн оромж сууцны үлдэгдлийг илрүүлээд байна. Мөн чулуун зэвсэг, шавар ваар савны хагархай, амьтны яс, гоёл чимэглэлийн зүйл агуулсан соёлт давхарга илрүүлэн малтлага судалгааг гүйцэтгэж байна. Малтлагаас олон тоогоор олдсон амьтны ясыг Канад улсын Трентийн их сургуулийн лабораторид нарийвчлан судалж буй бөгөөд хэд хэдэн дээжинд он цаг тогтоох шинжилгээ хийгээд байна.

#### **Судалгааны арга:**

Археологийн хээрийн шинжилгээний малтлага болон хайгуул судалгааны арга зүйг ашиглах ба илэрсэн олдвор хэрэглэгдэхүүний гар зураг болон бусад баримтжуулалт үйлдэнэ.

#### **Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүн:**

1. Д.Одсүрэн (МУБИС-ийн НХУС-ийн багш, доктор),
2. Лиса Яанз (Канад улсын Торонтогийн Их сургуулийн профессор),
3. М.Адьяасүрэн (Канад улсын Мкмастерийн Их сургуулийн докторант),
4. Зе Ма (Их Британий Дурхэмийн Их сургуулийн оюутан),
5. Сандра Мэй Грейтон (Канад улсын иргэн, продюссер),
6. Эмриш Наян Шах (Их Британий судлаач),

7. Шайлин Сиретт (Канад улсын судлаач),
8. Б.Чинзориг (жолооч),
9. Д.Одхүү (жолооч),
10. Тогооч: Ж.Нэргүйбаатар,
11. Туслах ажилтан: 5

*Унаа машин:* Ланд Крузер  
Мицүбиши Делика

*Хугацаа болон маршрут:*

- Тамсагбулагт 2022 оны 07-р сарын 15-наас 08-р сарын 20-ныг хүртэл ажиллана. Улаанбаатар – Чойбалсан – Тамсагбулаг – Чойбалсан – Улаанбаатар гэсэн чиглэлээр хөдөлгөөнөө үйлдэнэ.

**Санхүүжилт:**

Канад улсын Тронтогийн Их Сургууль

**Багаж тоног төхөөрөмж, машин техник:**

- Археологийн малтлагын багаж хэрэгсэл
- Олдвор, дээж хэрэглэгдэхүүний уут
- Майхан
- Гал тогооны хэрэгсэл
- Автомашин

**Судалгааны урьдчилсан үр дүн:**

Малтлага судалгааны явцад шинэ олдвор хэрэглэгдэхүүн илрүүлж нарийвчлан судлах. Тус экспедицид оролцсон талууд хамтарсан малтлага судалгаагаар олдсон хэрэглэгдэхүүнд боловсруулалт хийж, мөн малтлага судалгааны явцад илэрсэн дурсгалуудын талаар урьдчилсан үр дүнг мэдээлж, эрдэм шинжилгээний тайлан бичиж хүлээлгэн өгнө.

Удирдамж боловсруулсан:  МУБИС-ийн НХУС-ийн Түүхийн  
тэнхимийн багш Д.Одсүрэн



## II

### МОНГОЛ ТЭМЭЭНИЙ ӨВ СОЁЛ, УЛАМЖЛАЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгааг гүйцэтгэгч:

М.АЛТАНШАГАЙ –  
Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм  
шинжилгээний ажилтан

УЛААНБААТАР  
2023

## ЕРӨНХИЙ АГУУЛГА

УДИРТГАЛ БҮЛЭГ	73
• Хос бөхт монгол тэмээний гарал үүсэл ба гэршүүлсэн байдал	73
• Монгол нүүдэлчдийн бий болгосон ардын селекци	76
• Гэрийн амьтадыг зэрлэг амьтадтай эвцэлдүүлж байсан түүхээс	79
• Зэрлэг тэмээ буюу хавтгайн талаар	81
• Бэсрэг тэмээ (эрлийз тэмээ)	85
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХЭЭРИЙН СУДАЛГАА БА ЯРИЛЦЛАГА	86
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТЭМЭЭНД ХОЛБОГДОХ УЛАМЖЛАЛТ ӨВ СОЁЛ, ЗАНШИЛ, ЗАН ҮЙЛ	92
• Тэмээтэй холбоотой зан үйл, заншил, шүтлэгийн уламжлал	92
• Гүнжилхам бурханы дүр дүрслэл, бэлгэдэл	94
• Тэмээний даллага	98
ХАВСРАЛТ БҮЛЭГ:	102
• Тэмээ хэмээх амьтан дуунд туссан байдал	102
• Аман хууч, домог	104
• Тэмээний нэрээр нэрлэгдсэн тоглоом	107
• Тэмээтэй холбоотой нэрээр нэрлэгдсэн зарим газар	108
• Тэмээний нэрээр нэрлэгдсэн амьтан, ургамал	109
• Д.Цэвэгмидийн “тэмээн гөрөөс” тэмдэглэлийн хэсгээс	110
ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН	112

Монгол-Канадын хамтарсан “Говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн судалгаа” төслийн хүрээнд Монгол орны шинэ чулуун зэвсгийн дурсгалт газруудад малтлага судалгааг хийж олон тооны мал амьтны ясны цуглуулга бүрдүүлсэн юм. Үүний дотор үхрийн яс ихээхэн чухал бөгөөд тус төслийн судлаачид эртний үхрийн ясанд генетикийн нарийвчилсан судалгаа хийж байгаа юм. Монголын археологийн дурсгалын малтлагаас илрүүлсэн үхрийн ясанд гаршуулсан болон зэрлэг аль альных нь генетикийн баримт олдсон бөгөөд бид орчин үеийн ийм баримтыг илрүүлэхэд анхаарал хандуулсан юм.

Бидний хувьд тэмээ болон хавтгайн орчин үеийн үржил селекцийн үйл явц эртний гаршуулсан болон зэрлэг амьтдын үржил селекцитай ижил төстэй байх магадлалтай хэмээн үзсэн юм. Тиймээс энэхүү судалгааг “Говь, хээрийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн судалгаа (GSN)” төслийн захиалгаар гүйцэтгэсэн болно.

### **Судалгааны зорилго:**

Хос бөхт монгол тэмээний талаар тэр дундаа Монгол орны говийн өмнөд хэсгээр амьдрах гэрийн тэмээ, зэрлэг тэмээ буюу хавтгай, бэсрэг (эрлийз) тэмээнүүдийн ерөнхий байр байдал, нийгэм-соёлын нөлөөллийг тодруулах, түүнд холбогдох угсаатан, антропологи, биет бус соёлын өвийн мэдээ баримт цуглуулах.

### **Судалгааны хамрах хүрээ:**

Баянхонгор аймгийн Баянлиг, Шинэжинст, Өмнөговь аймгийн Цогт-Овоо зэрэг сумдын малчин иргэдтэй уулзаж, мэдээлэл цуглуулах.

### **Судалгаа хийгдэх хугацаа:**

2023 оны 01 дүгээр сарын 20-ноос 2023 оны 02 дугаар сарын 10-ныг хүртэлх хугацаанд үргэлжлэв.

### **Судалгааны арга зүй:**

Баянхонгор аймгийн Баянлиг, Шинэжинст, Өмнөговь аймгийн Цогт-Овоо зэрэг сумдаар нутаглах малчин иргэдээс ярилцлага авах (Interviewing), тэднээс холбогдох мэдээллүүдийг цуглуулах (Gathering information), зураг ба бичлэг авах (photos and audios), түүхэн судалгааны эх сурвалжуудтай танилцах (archive) зэрэг байдлаар түүх, угсаатны зүйн судалгааны арга зүйг хослуулан хэрэглэлээ.



## УДИРТГАЛ БҮЛЭГ

### Хос бөхт монгол тэмээний гарал үүсэл ба гэршүүлсэн байдал

Тэмээний гарал үүсэл. Одоогийн тэмээ нь салаа туурайтны баг (Artiodactyla), сайран хөлтний дэд баг (Tylopoda), тэмээний бүлд (Camelidae) багтан бөхт тэмээний овог (Camelini) ба бөхгүй тэмээний овгоос (Lamini) үүссэн байна. Бөхт тэмээн (Camelus) төрлөөс нэг ба хос бөхт тэмээ үүсчээ. Тэмээний дээд өвгийн сайран хөлтний дэд баг нь хэвэгч амьтдын дэд багаас нэлээд түрүү үед салсан бөгөөд үүний улмаас тэмээн төрөлтөн хэвэгч малаас олон талаараа ялгаатай болжээ. Тэмээ нь одоогоос 45-50 сая жилийн тэртээ Хойт Америк тивд амьдардаг туулайн чинээ биетэй хөлдөө дөрвөн сарвуутай, богино титэм бүхий шүдтэй протилопус хэмээх амьтнаас үүсэлтэй гэж үздэг бөгөөд Эоцений эхэн үе гэхэд 20 төрлийн амьтан болон өргөжсөн байна<sup>1</sup>.

Төв Ази, түүний дотор Монгол нутагт хүрэл ба төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан овог аймгууд тэмээг өсгөж үржүүлж, түүнийг уналга ачилгад хэрэглэж байжээ<sup>2</sup>. Одоогоос хэдэн мянган жилийн тэртээ бүтээгдсэн Монгол орны нутаг дахь хадны зургууд дээр тэмээ хөтөлсөн, тэмээ унасан, тэмээ идээшилж буй сэдэвтэй олон янзын зургууд дүрслэгдсэн байгаа нь тэмээг гэршүүлсэн нөхцөл байдлын тухай судалгаа хийхэд үнэтэй ач холбогдолтой үзүүлэх ажээ.

Өнөөг хүртэл Монголд хос бөхт тэмээг хэдий үеэс гэршүүлснийг нарийвчлан тогтоох талаар судалгаа хийгдээгүй байна. Хүн төрөлхтөн тэмээг гаршуулан өөртөө дасгаж ашиглан гэрийн болгосон хугацаа, газар орны тухай асуудлыг тогтоохдоо зоологи, палентологийн нээлт, ололтод тулгуурлахын зэрэгцээ эртний нийгмийн соёл, хэл судлал хүртэл ач холбогдолтой ялангуяа хос бөхт тэмээг гэрийн болгосон нь Түрэг-Монголын соёлтой холбоотой<sup>3</sup> гэжээ.

Нүүдэлчин монголчуудыг сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуйг хөгжүүлж ирсэн онцгой гавъяатай гэж үздэг. Монголын эртний түүхийн талаар нэлээд дэлгэрэнгүй судалгааг хийсэн эрдэмтэн Г.Сүхбаатар Хүннү улсын үеийн Монголын аж ахуйд монгол орны байгаль, газарзүйн онцлогт олон үеийн туршид шилмэл малыг шалгаруулан авах ардын уламжлалт селекцийн үндсэн дээр таван хошуу малыг бий болгосон байна<sup>4</sup> хэмээн үзсэний дотор монгол тэмээ онцгой байр суурь эзлэх нь дамжиггүй юм.

2000 жилийн тэртээд Монголын өвөг дээдэс болох Хүннүчүүд тэмээг харь дайсны эсрэг байлдаанд ашиглаж байжээ. Монголчууд олон зууны турш хилээ хамгаалах, харийн дайсан довтлоход тэмээг өргөн ашигладаг байжээ. Өвлийн цагт тэмээнд эсгий нөмөргөн хэвтүүлж, ус асган хөлдөөхөд сум нэвтрэхгүй бэхлэлт болдог байжээ (С.Жамбалдорж: 250).

Тэмээ түлхэх гэдэг нь говийн анчдын зээр гөрөөс, чоно агнахын тулд тэмээний бурантагийг нарийхан саваа модны үзүүрт уяж түүний алхааг тааруулан түлхэн явсаар агнах амьтандаа аль болох ойртон дөхөх агнуурын аргыг хэлнэ. Ан агнуурын энэ арга нь маш эрт дээр үеэс уламжлагдан ирсэн болов уу гэж үзэх үндэс бий.

<sup>1</sup> Монгол хос бөхт тэмээ / Эмхэтгэсэн Ө.Эрдэнэбилэг, Ч.Цогттуяа.- Даланзадгад.:Сод Пресс ХХК., 2016. т.13.

<sup>2</sup> Д.Цэвээндорж, Л.Батчулуун, Н.Батболд. Молор толгойн хадны зураг. УБ., 2004. т.38.

<sup>3</sup> Монгол хос бөхт тэмээ / Эмхэтгэсэн Ө.Эрдэнэбилэг, Ч.Цогттуяа.- Даланзадгад.:Сод Пресс ХХК., 2016. т.16. (дам ишлэв).

<sup>4</sup> Г.Сүхбаатар. Монгол Нирун улс (330-550) / Ред. Ч.Далай.-УБ.:Шинжлэх Ухааны Хэвлэлийн “Эрдэм” пүүс., 1992.т.87.

Тэмээг гаршуулж, гэршүүлэн хэрэглэж байсан тухайд холбогдох зарим мэдээ баримтууд хадны зурагт дүрслэгдэн хоцорсон байдаг.

Монгол орны хадан дээр дүрсэлсэн тэмээний төрхийг гурван хэлбэрт хуваан үзэж болох юм. Нэгд, тэмээний толгой, бөхийг жижиг, их бие хүдэр, болхи, хөл богино зурсан байх нь хуучин чулуун зэвсгийн үеийн уламжлалт арга барилд түшиглэн неолитын үед зурж урласан байж болно. Хоёрт, тэмээний олонхийн бие, нуруу, гэдсийг шулуун нарийхан, урд хөлийг зэрэгцсэн байдлаар, заримын тавхай, эр хүйсийг тод гаргасан байх ба ингэн тэмээ ботгоо дагуулан яваа, хоёр буур ноцолдож байгаа зэргээр дүрсэлсэн байх аж. Гуравт, тэмээний толгой, их бие, хөл зэрэг эрхтнүүдийн харьцааг сайн гаргаж, түүнийг зогсоож, алхаж, жонжиж, тэшиж яваа хөдөлгөөнийг мэдэгдэхүйц чадамгай дүрсэлсэн байна. Тэмээг дүрсэлсэн арга барилд хангай, говийн ялгаа ажиглагдаж байна. Говийн бүсэд байгаа хадны зурагт том биетэй зарим эрхтний хэт томруулах буюу жижигрүүлж зурсан байхад хангай талын хадны зурагт тэмээ жижиг бөхтэй, бие эрхтнүүдийг зөв харьцаатай зурсан, ялангуяа цохиж хонхойлгосон ором нь гүн байна. Нутгийн байршлын хувьд тэмээний олонхи хадны зургууд говь нутагт тааралдаж байна. Энэ нь тэмээг эртнээс гаршуулсан болон оршин амьдрах үндсэн нутаг нь говь байсан гэдгийг батлах нэг баримт юм. Хадны зурагт хавтгайг дүрслэн зурсан байж болох талтайн дээр гэрийн тэмээг хөтлөх, унах, туух, хүн маллаж байгаагаар зурснаар ялгагдана. Хүрэл зэвсгийн үеийнхээс өмнө зурсан тэмээний шинж төрх хавтгайтай адил төстэйгээс гадна зурсан арга зохиомж нь хуучин чулуун зэвсгийн үеийн агуйн зургийн зохиомжтой адил төстэй юм.

Зарим нутагт тэмээний хөл гуяыг маяг оруулан угалзлуулан зурсан байгаа нь Дундговь аймгийн орон нутаг судлах музейд байгаа хүрэл даруулгатай адилхан байна. Ер нь хүрлийн үеийн урчууд хадан дээр тэмээ сийлэх, хүрлээр тэмээ дууриалган цуггаж гоёл чимэг хийх, мөн нас барсан хүнд хүрэл тэмээ тавих, тэмээний толгойн яс дагалдуулах явдал байсан нь нэн эртнээс уламжлалтай юм. Энэ талаар жишээ дурдвал, Архангай аймгийн Хануй гол, Хойт Тамирын голд малтсан дөрвөлжин булшнаас тэмээний толгой, Чандмань ууланд малтсан төмрийн түрүү үеийн булшнаас тэмээний толгой дуурайлгасан хүрэл чимэг олдсон зургийг дурдаж болно. Тэмээ хойлоглох (үхэгсдийг эд юм, мал адгуусыг дагуулан оршуулах ёс) малд ордоггүй байсан бололтой. Гэвч дээр дурдсан дурсгалууд нь тэмээг хүндэтгэн бусад малын адил оршуулгад хэрэглэсээр ирсэн, тэмээний ашиг шимийг нүүдэлчид эрт үеэс хүртсээр ирсэн гэдгийг үгүйсгэх аргагүй юм<sup>5</sup>.

Эрт үеэс уламжлалтай Төв болон Дундад Азийг бусад газруудтай тэр чигт нь холбож дэлхийн худалдаа, нийгэм-соёлын амьдралд чухал үүрэг гүйцэтгэж байсан “торгоны зам” хэмээх маш том бүтээн байгуулалыг монголчууд эрхлэн гүйцэтгэж байсан түүхтэй билээ. Чухам энэ үед (XIII зуун) “Тэмээ ачааны яам” гэгчийг байгуулж, холын зам тээврийг холбох, ачаа зэвсэг ачих, олз тээвэрлэх ажлыг хийлгэж байсан тухай судлаач М.Төмөржав, Н.Хүрэлбаатар<sup>6</sup> нар тэмдэглэсэн байна. Мөн монголын нууц товчооны 249, 265-р зүйлд тэмээ өргөх, тэмээт иргэдийг олзлохтой холбоотой мэдээ баримт гардаг.

“Монголын нууц товчоо”-ны 244-р зүйлд бидний сэдэвт холбогдох нэгэн сонирхолтой мэдээ баримт таарч байна. Энэ нь Чингис хаан, Хасар хоёрын зөрчлийн тухай өгүүлдэг хэсэг юм. Тэдний маргааныг цааш нь газар авахаас урьтаж Хүчү, Хөхөчү нар Өэлүн эхэд хэл дуулгадаг. Үүнийг мэдсэн Өэлүн эх хойноос нь цагаан тэмээ хөллөж, харуутай тэрэгтэй шөнөжин явж нар ургахад хүрч очсон тухай тэнд тэмдэглэгджээ. Үүнээс

<sup>5</sup> Монгол хос бөхт тэмээ / Эмхэтгэсэн Ө.Эрдэнэбилэг, Ч.Цогттуяа.- Даланзадгад.:Сод Пресс ХХК., 2016. (дам ишлэв).

<sup>6</sup> М.Төмөржав, Н.Хүрэлбаатар. Монгол малчны эрдэм ухааны дээж оршвой. УБ., 2017. Т.136.

үзэхэд өгүүлэн буй үед Өэлүн эх хаана байсан бэ? Хаанаас хаа хүрсэн бэ? гэх зэрэг асуултууд урган гарч ирэх юм. Тэмээ эсвэл тэмээн тэрэг хөллөн наран ургахтай уралдан яаран сандран харанхуй шөнөөр хүрэх газартаа очиж байгаа нь юуг хэлж байгаа нь сонирхол татдаг. Өэлүн эх говиор нутагтай байв уу?

Дашрамд дурдахад, XIII зууны үеийн түүх сурвалжид томоохон хаад ноёд, хатдыг мухлаг тэргээр авч явдаг байсан тухай олонтаа дурдагддаг. Мухлаг тэргэнд морь, тэмээ зэрэг амьтдыг хөллөхөд ихээхэн тохиромжтой болно.

## Монгол нүүдэлчдийн бий болгосон ардын селекци

Шилмэл сүрэггүйгээр малыг өсгөж үржүүлэн, тоо толгойг нэмэгдүүлж, чанар чансаа, ашиг шимийг сайжруулах арга байхгүй гэдгийг монголчууд эрт дээр үеэс сайн мэддэг байжээ. Чухам ийм учраас тэд малд шилэлт сонголт явуулж, өсгөн үржүүлдэг, шилмэл сүрэг бий болгодог уламжлалт аргыг боловсруулжээ.

Монголын нууц товчооны 90, 169-р зүйлд Тэмүжиний 8 шарга, оготор хултай нийлээд 9 шилмэл морьтой, мэргид нь цагаан, ам цагаан хээр 2 сайн морьтойг тэмдэглэсэн байдаг бол 124-р зүйлд мөн л дээрх утга агуулгад нийцэх зүйл бичигджээ. Түүнчлэн Багдадаас өндөр хөлтэй аргамаг хүлэг (274-р зүйл), Алтан хаанаас (273-р зүйл) агт морь, Энэтхэгээс тэмээ, ямаа авч ирж байсан нь малын үүлдэр угсааны талаар тэр үеийн монголчууд хэр мэдлэгтэй байсныг илэрхийлдэг<sup>7</sup>.

Монголын малчид эцэг малыг эх, эцгийн удамшлын байдлаар, эх малыг гадаад шинжээр нь шалгаруулах хоёр зүйлийн аргыг хэрэглэж байжээ. Эцэг малыг шалгаруулж байгаа энэ хоёр хэлбэр бол хүйлгээр шалгаруулах ажлын нэг хэлбэр мөн. Зориудын шалгарлын дурдсан хоёр ажлыг ямаа, хонин дээр нэг нас хүртэлх хугацаанд зохиох ба үхэрт хоёр нас, адуу, тэмээнд гурван нас хүртэлх тус тус зохион явуулдаг<sup>8</sup>.

Малчдын туршлаганд эр малыг ашиглах талаар ихээхэн сонирхолтой асуудлууд байна. Жишээлбэл, эцэг мал болгон ашиглах, эр малыг ямагт бэлэг боловсрохоос өмнө өөрөөр хэлбэл, бэлгийн хоёрдугаар шинж үүсэхээс өмнө сонгон шалгаруулна. Эр төл бэлгийн хоёрдугаар шинж хөгжөөгүй байхдаа биеийн галбир, биеийн морфологийн шинжээрээ тухайн зүйл малын эм ба хөнгөлсөн эр малтай төсөөтэй байхын зэрэгцээ бодьгал биеийн хувилгаа явагдаагүй байдаг тул энэ үедээ аж ахуйд ашигтай шинжүүдийн хөгжлөөрөө бие биеэсээ хялбархан ялгагдах онцлогтой. Харин нэгэн зүйлийг онцгойлон тэмдэглэхэд эцэг мал болох төлд ямагт тэр сүрэгт өмнө нь байгаагүй ашигтай шинжийн хувьсалтай байхаар сонголт хийдэг байсан нь малд үүссэн амьдралыг дэмжих байгалийн мутуаци хувьслыг зөвхөн эцэг малаар дамжуулан сүрэгтээ түгээх үйл ажиллагаа нь болж, улмаар ашигтай мутуацийн хуримтлалыг санамсаргүй хийж байсан нь илэрхий байна. Энэ бол бэлчээрийн малд малчдаас хийж байсан селекцийн нэг онцлог тал даруй мөн<sup>9</sup>.

Хуучин Дайчин бээсийн хошуу одоогийн Дундговь аймгийн Өндөршил сумын Далай гэдэг нутагт Богд эзний Төмөр тэмээ гэж байжээ. Энэ нь уг чанартаа Манжийн хааны төмөр сүргийн нэг хэсэг билээ. “Төмөр тэмээ” гэсэн нь ямар ч зуд турхан болсон үрэгдэж хорогдох учиргүй гэсэн утгатай үг байв (С.Жамбалдорж 2009: 192).

### “Төмөр сүрэг” буюу манжийн хааны шилдэг сүрэг

Манж нар XVIII зууны нэгдүгээр хагасын эхэнд өөрийн цэргийн олон ангиудыг хятадын баруун хойт хязгаар ба халх монголд ирүүлж суулгав. Тэрчлэн байлдааны бэлтгэл, зүтгэх хүчин, хүнсээр хангах бодлогоор халхын ард түмнээс төрөл бүрийн олон зуун мянган малыг дайчлан гаргуулав. Энэхүү малыг цэргийн хэрэгцээнд нийлүүлэхийн хамт адуулах үүргийг монголын ард түмний нуруун дээр тохжээ. Манжийн цэргийн бэлтгэл малыг “*төмөр сүрэг*”, “*мөнх сүрэг*”, “*түмт мал*”, “*үржүүлэх сүрэг*”, “*албан сүрэг*” хэмээн

<sup>7</sup> Н.Эрдэнэцогт. Монголын нүүдлийн мал аж ахуй. УБ., 1998. т.128.

<sup>8</sup> О.Шагдарсүрэн. Монгол ардын селекци, түүний зарим арга барил (“Хөдөө аж ахуй” сэтгүүл. №01). УБ., 1969.

<sup>9</sup> Н.Эрдэнэцогт. Монголын нүүдлийн мал аж ахуй. УБ., 1998. т.132.

нэрлэж байжээ. Ийнхүү нэрлэсэн явдал бол уул малын тоо толгойг хорогдуулахгүйгээр байлгаж тоо ёсоор нөхөн төлүүлэх гэсэн харгис бодлого юм. “Түмт мал” бол түмэн толгой малаар сүрэг болгосноор тийнхүү нэрлэжээ. Эдгээр сүрэг малыг ардуудад үнэ хөлсгүйгээр албадан хадгалуулж байв. Уул сүрэг малаас өвчнөөр буюу хөгширч үхэх, чононд идүүлэх, алдах, аминдаа ашиглах, худалдах зэрэг янз бүрийн шалтгаанаар тоо хорогдох ахул адгуулагчдаас тоо ёсоор тулган төлүүлэх хийгээд, хөхүүлэх ба ял шийтгэл, торгууль төлбөр хүлээлгэх зэрэг хатуу журмыг тогтоожээ. Монгол цаазын бичигт заасан нь: нэгэн зүйл, монгол газрын адууны түшмэл цэрэг албаны адуу, үхэр тэмээг хулгух, эсвэл зоргоор худалдах, эс бол алж идэх ба өөрийн хөрөнгө болгож дарагчид бол 1-9 хүрвээс адууны түшмэлийг түшмэл эвдэж Хар мөрөнд цөлж алба хааж явуул, адууны цэргийг дэсийг үл бодон эм хөвгүүдийн хамтаар цөлж, цэргийн ардад боол болго<sup>10</sup> гэжээ.

1730-1732 оны үест Халхын 70 гаруй хошуудын ардуудад адуу 74 мянга шахам, тэмээ 64 мянга гаруй, хонь 238 мянга илүү, ямаа 80 мянга шахам бүгд хагас сая шахам толгой малыг албадан хариулгаж байжээ. Энэхүү малыг 2 мянга шахам айл өрх хариулж байсан нь мэдээж юм. 1730 хэдэн онд Засагт хан аймгийн 9 хошуу, Сайн ноён хан аймгийн 14 хошуудад хадгалуулсан **төмөр сүргийн тэмээнээс** ямар нэгэн шалтгаанаар хорогдсон 8 мянга гаруй тэмээг адуулагч ардуудаас тоо ёсоор тулган төлүүлж, хилс төлбөрт унагаж хохируулан сүйрүүлж байсан байна.<sup>11</sup>

1767 онд манжийн хааны зарлигаар Ховд, Улиастайд байсан тэмээнээс 80 бууртай, 2000 тэмээ Түшээт хан аймгийн бээс Дэчинранпилийн хошуу нутаг Онгийн гол, Шанхай зэрэг нутгуудад үржүүлэх болсон нь говьчуудад бас нэг их дарамт болж байжээ. Энэ тэмээг зүүн баруун хоёр хэсэг болгон 65 суурьт хувааж маллах хүнийг албадан гаргуулж, 10 суурь тутам ерөнхийлөн захирах түшмэл 1, занги 1, галч зарлага 8 хүн ажилладаг байжээ. Манжийн захиргаанаас 3 жилд 10 тэмээ тутмаас 5 ботго нэмэгдүүлэх болзол тогтоон түүнээс илүү үржүүлбэл шагнах, хорогдуулвал шийтгэх ба нөхөн төлөх журмыг тогтоосон байна. Ийм учраас нутгийнхан “төмөр сүрэг” гэж нэрлэжээ. Үүний хорогдох нь их байсан учир говийнхныг хоосруулах нэг нөхцөл тэр байв. 1880 онд Балдан засгийн хошууны төлбөрийн тэмээ 306-д хүрч Түшээт гүний хошуу маллаж байсан тэмээний хорогдлыг сүрэгчдийн хөрөнгө төлж хүрэхгүй болсон учраас төлбөрийг өөр хошуунд халдаан төлүүлж байсан байна. Тэмээ маллах хөлс өчүүхэн бага, төмөр сүргийн үнэ маш өндөр байжээ<sup>12</sup>.

Манжийн захиргаанаас сүрэг тэмээг хэрхэн бүртгэх, үржүүлэх тайлан хасах ба арван тэмээнээс гурван жил тутам 5 төл үржүүлэх болзол тогтоож, илүү үржүүлсэн ахул шагнах, хэрэв тогтоосон хэмжээнээс дутуу үржүүлэх буюу уул тэмээг хорогдуулах аваас ял шийтгэл хүлээлгэх, тоо ёсоор нөхөн төлүүлэх, хатуу журмыг тогтоожээ. Энэхүү сүрэг тэмээнээс үржих, хорогдох явдал тогтворгүй янз бүр байжээ. Жишээлбэл, 1779-1787 онуудад гагцхүү баруун үржүүлэх тэмээ 5177- 8306 хүртэл өсөж байсан бол 1807 онд зүүн баруун үржүүлэх тэмээ 6000 хүртэл буурчээ. Харин 1812 онд зүүн үржүүлэх тэмээ 13361 толгой хүртэл өсөж байсан байна. Ховд, Улиастай дахь албаны мал, үржүүлэх сүрэгт өвчин эмгэг буюу ган зуд тохиолдож хорогдох явдал байнга үргэлжилж, аймаг хошууд, адуулагч ардууд үлэмжхэн төлбөрт унаж байсан билээ. Эдгээр сүрэг малын хорогдлыг адуулагчдаас тулган төлүүлж

<sup>10</sup> Ц.Насанбалжир. Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911) / Ред. Х.Пэрлээ.-УБ.:ШУА-ийн хэвлэх үйлдвэр., 1964. т.106.

<sup>11</sup> Ц.Насанбалжир. Ар Монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911) / Ред. Х.Пэрлээ.-УБ.:ШУА-ийн хэвлэх үйлдвэр., 1964. т.107.

<sup>12</sup> С.Дамбадаржаа. Их говийн зоригтон / Ред. Л.Хайдав.-Даланзадгад., 1972.-т.7.

байсан бөгөөд хэрэв адуулагчдын хөрөнгө чинээ хүрэлцэхгүй ахул сүрэг адуулахаар ноогдсон аймаг хошуудад халдаан төлүүлж байжээ<sup>13</sup>.

---

<sup>13</sup> Ц.Насанбалжир. Ар монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911) / Ред. Х.Пэрлээ.- УБ.:ШУА-ийн хэвлэх үйлдвэр., 1964.-т. 110.

## Гэрийн амьтдыг зэрлэг амьтадтай эвцэлдүүлж (эрлийзжүүлж) байсан түүхээс

*Адууг хулан, тахьтай эвцэлдүүлж байсан нь:* Үржил селекцийн ажил гэдэг маш нарийн процесс юм. Манайд монгол адууг хулан, тахьтай эвцэлдүүлж байсан түүх бий. Хуланг монгол адуутай эвцэлдүүлж гаргаж авсан төл нь ааш ихтэй ч байгаль экологийнхоо нөхцөлд дасан зохицох чадвар өндөртэй байдаг аж. Эмээллээд мордоход оломныхоо ормоор хавдчихна, ухарна, булгихдаа ар гэдэргээ савж унана гэх мэтчилэн өөр араншин гаргаж байжээ. Намайг Төв аймгийн Жаргалантын САА-д байхад тахьтай эвцэлдүүлж гаргасан адуу байсан. Тэр үед Жаргалантын хөх Дэндэв гэгч уяач байсан юм. Тэр хүн тахийн эрлийздүү маягийн адуу уядаг, тэр нь ч сайн давхидаг байсан. Гэвч тэрхүү эрлийзүүд өдгөө түгээмэл тархаагүй нь бас учиртай. Учир нь тэр үед цус багадах буюу “анаэмиа” гэдэг өвчин дэлгэрсэн юм билээ. Энэ үед Жаргалантын САА-д оросын мэргэжилтнүүд ажилладаг байж. Тэд энэхүү өвчинг зөвхөн энэ хэсэг газрын адуугаар зогсохгүй нийт Монголын адууг хамрахыг үгүйсгэхгүй гэж үзээд өвчин туссан адууг бүгдийг устгасан гэдэг. Тэр устгалтанд тахийн эрлийз адууны ихэнх нь хамрагдсан гэж ярьдаг. Учир нь өвчин эмгэг тэсвэрлэх чадвараараа хамгийн бага байсан учраас монгол адуунаасаа илүү өвчин тусаад үгүй хийгдсэн нь тэр гэж үзжээ<sup>14</sup>.

*Зэрлэг ямаа (янгир)-г гэрийн ямаатай эвцэлдүүлж байсан нь:* Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн нутагт иргэн цорос овогт Ядамын Дорж 1962 оны өвөл Шижигтийн хавцалд урхи тавьж янгир ямаатай нийлж зэрлэгшсэн бор галзан эм ямаа барьж авч гэршүүлжээ. Уг ямаа тэр оны хавар төрж эр, эм хоёр ихэр ишиг гаргажээ. Эм нь цагаан, эр нь хар голтой хоо саарал зүстэй байс ан бөгөөд эрийг нь бороо, эмийг нь шовгоо гэж дуудахад эзэндээ гүйгээд ирдэг байжээ. Эр ишгээр нь тэх тавьж гэршүүлэн 8 жил үржүүлж янгир ямааны гаралтай 100 орчим ямаатай болсон байна. Тэх нь гадны хүнийг хотонд оруулдаггүй, эзнээсээ бусдыг мөргөж хөөдөг, 9-10 дугаар сард хээлтүүлэгт ордог, бусад үед нь ямаа хөөдөггүй, сүрэг дотроо байдаг байжээ. Тэх шөнийн цагаар эзнээ ч хотонд оруулдаггүй бөгөөд орсон үедээ өдрөөр ч эзнээ хотонд оруулдаггүй болохоор нь зассан боловч засаанаасаа болоод үхсэн байна. Я.Дорж нь ихэнх улиралд Шижигтийн хавцал, Тошинт, Таг зэрэг уулархаг газраар нутагладаг, хаварт Шижигтийн хавцалд бууж малаа төрүүлдэг байжээ. Анхны тэхийн өрөөсөн цагаан ишиг (ямаа) нь Ховдын голд ордоггүй, ууланд үлдээд эзнээ өвөлжөөнд буухаар ижил сүрэгтээ ирдэг байжээ. Янгирын эрлийз ямаа нь догшин, ноолуур муутайгаас цаашид үржүүлж, өсгөх бодлого бариагүй байна<sup>15</sup>.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд Эрдэнэбүрэн сумын нутаг Хонгион бэлчирээс дээш Хонгор Өлөнгийн гол дагуу нутагт “Орог сэрх” нэртэй газар бий. Тэгж нэрлэсний учир нь хуучин тэнд зэрлэгшсэн таван орог сэрх байсантай холбоотой ажээ (Н.Намсрай. 1999:98).

*Монгол үхэр сарлаг хоёр эрлийзжэх явдал бий.* Тэр хоёрын дундаас “хайнаг” төрөх бөгөөд хайнаг нь бие сайхан, том, бяр чадал ихтэй. Гэхдээ монголчууд хайнагаар бух тавьдаггүй аж. Харин монгол үхэр, хайнаг хоёрын дундаас “ортоом” гэж төрөх бөгөөд ортоом нь бие бялдар том байж болох авч ашиг шим муу, усан нүдтэй, ган зудад тэсвэр муутай гэдэг учраас малчин хүн төд их таашаадаггүй байна.

<sup>14</sup> Адуу судлаач доктор (Ph.D) Д.Мянганцэвээн: Тахитай эвцэлдүүлж гарсан төл онцгой хурдан байдаг (А.Тэлмэний 2013 оны 7-р сарын 09-ний өдөр хийсэн ярилцлага). Todmagnai.mn

<sup>15</sup> Цамбагаравынхан. Эмхэтгэсэн Д.Ширэндэв. УБ., 2001. т.26.

Дашрамд сонирхуулахад, Говь-Алтай, Ховд аймгийн зарим сумдад “хөх бух” хэмээх нэгэн амьтны тухай нутгийн ардууд ярьдаг. Заримдаа энэ амьтныг нуураас гарч ирэн айлын үхэр сүрэгт нийлээд буцдаг талаар олон янзын домог яригддаг. Эдгээрийн нэг нь “Дөрөө нуурын хөх бухын тухай” домгийн хувилбар юм. Тэнд өгүүлсэн нь: Эрт дээр үед Маам гэх айл олон балчир хүүхэдтэй, ядуу тарчиг амьдралтай, цайны сүүний 2 тугалтай үнээнээс өөр эд хөрөнгөгүй байж гэнэ. Марууш гуайн нэг хүү 2 үнээгээ нуурт услах гэж очтол нуураас нэг том хөх бух гарч ирээд үнээнүүдийг нь тойрч үнэрлээд байхаар нь нийлүүлээд туугаад явъя гэтэл хөх бух нуурын урдаас нь ороод хойд зүгийг чиглэн яваад өгсөн юм гэдэг. Түүнээс хойш тэднийх мал идээ арвижаж, баян тансаг айл болсон гэдэг. Хөх бух нэг жаранд үзэгддэг нь “Баяжихын бэлэгдэл” гэж нутгийн ардууд ярьж иржээ.

*Гэрийн тэмээ, хавтгай тэмээ хоёр эрлийзжэх явдал* нэлээд бий. Монгол оронд хавтгайн буур орооны үедээ дархан газрын хилийн дагуу нутаглаж буй малчдын гэрийн тэмээний ингэнүүдийг хураах, дархан газрын бүсэд орсон зарим эзэнгүй тэмээд хавтгайтай нийлэх зэргээр хавтгайн бууранд гарсан ингэнүүдээс эрлийз ботго төрөх тохиолдол цөөнгүй гарч байжээ (Банников, 1954, Жирнов, Ильинский, 1985). Энэ асуудал бүр эртнээс гарч Хятад дахь Лоб нуурын хавтгай популяцийн цэвэр эсэх нь эргэлзээтэй байсан тухай судлаачдын мэдээллүүд (Пржевальский, 1878; Певцов, 1895; Козлов, 1899) гарсан байдаг. Алтайн өвөр говьд хавтгайн бууранд гарсан гэрийн тэмээний ингэ хавар нь буцан ирж гэрийн сүрэгтэй нийлж, улмаар дараа жил нь эрлийз ботго төрүүлэх тохиолдол олонтаа гарч байв. Ийм эрлийз тэмээг монголчууд бэсрэг гэж нэрлэдэг. Говийн ДЦГ-т хийгдэж байсан олон жилийн ажиглалт судалгаагаар зэрлэг хавтгайн сүрэгт бэсрэг тохиолдож байгаагүй, харин хавтгайн сүрэгтэй нийлсэн гэрийн тэмээ тохиолдож байсныг сүргээс нь салган тусгаарлах арга хэмжээ авч байлаа. Говийн их ДЦГ-ын орчны бүс нутагт 2006 онд хийсэн бэсрэг тэмээний тооллого судалгаагаар Говь-Алтай, Баянхонгор аймгийн 5 сумын нутагт нийт 46 бэсрэг тэмээ тоологджээ. Эдгээр бэсрэг тэмээний 85 хувь Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын малчдын тэмээн сүрэгт байжээ<sup>16</sup>.

Сонирхуулахад, зэрлэг тэмээний талаар Н.М.Пржевальскийн (1878) тэмдэглэсэн нь: Хавтгай тэмээ хоёрдугаар сард орооных нь цаг болоод ирэхээр буурнууд нь хэт зоригжоод, Цайдамаас Аньси-жоу руу яваа жингийн тэмээдрүү ч дайрдаг гэх. Тийм үед жингийн тэмээд ч зэрлэг амьтадтайгаа нийлээд бүрмөсөн алга болдог<sup>17</sup> байна гэжээ. Гэвч Н.М.Пржевальскийн бичсэн зүйлд эргэлзээтэй зүйл бас бий. Тэр өгүүлсэн нь хавтгай тэмээг угаас зэрлэг омгийнх байж болзошгүй гэх ба гэрийн тэмээд хавтгай тэмээдтэй хэзээ ч үржилд ордоггүй, хүний туслалцаагүйгээр тэд эрлийзждэггүй гэх яриа<sup>18</sup> юм. Үүнийг Н.М.Пржевальский зохиож бичив үү? Эсвэл нутгийн ардууд худал ташаа мэдээлэв үү? гэдэг нь нягтлуштай мэт.

<sup>16</sup> Б.Мижиддорж. Алтайн чанад говийн хөхтөн амьтад. УБ., 2018. т 132.

<sup>17</sup> Н.М.Пржевальский. Монгол, Тангад нутгаар / Орч. Ж.Нэргүй.-УБ.:ЖиКом Пресс., 2012.-т.317.

<sup>18</sup> Мөн тэнд. т.318.



## Зэрлэг тэмээ буюу хавтгайн талаар

Зэрлэг тэмээг монголчууд хавтгай гэж нэрлэдэг. Яагаад хавтгай гэж нэрлэсэн талаар олон янзын таамаглал байдаг. Нимгэн банзан биетэй, өндөр зэгзгэр учраас жирийн тэмээтэй харьцуулахад хавтгай юм шиг харагддаг, мөн зэрлэг тэмээний духны ясны товгор хэсэг намхан байдгаас өрөвлөг нь тэмээнийх шиг товгор босоо биш хавтгайдуу харагддаг учраас хавтгай гэж нэрлэсэн гэсэн яриа байдаг.

Зэрлэг тэмээний гарал үүсэл, гэрийн тэмээтэй ямар холбоотой, цөлийн хатуу ширүүн нөхцөлд гайхалтай дасан зохицсон чадварыг танин мэдэх үүднээс геномын нэлээд өргөн хүрээтэй судалгаа хийгдээд байгаа ба зэрлэг тэмээний генетик-биологийн судалгаа өдрөөс өдөрт өргөжсөөр байна.

Хэдийгээр хавтгай, гэрийн монгол тэмээ хоёр олон зууны туршид Монголын говь цөлийн бүсэд экологийн ойролцоо нөхцөлд оршин амьдарсаар ирсэн боловч гэрийн тэмээ уналга, ачлагад хэрэглэж ирсэн зориудын эрлийзжүүлэг явуулсан зэргээс шалтгаалан галбир болон толгойн ясны бүтэц, бусад шинж тэмдэгт тодорхой ялгаанууд илэрсэн гэж мэдээлсэн байна<sup>19</sup>.

Хавтгай тэмээ одоогоос 200-300 жилийн өмнө Төв, Дундад Азийн говь цөлд түгээмэл дэлгэр тархацтай байжээ (Гептнер, 1966). Хавтгай тэмээний тоо толгой тархац нутаг нь хумигдсаар XX зууны эх гэхэд Хятадын баруун хойд хэсэг, Монголын баруун өмнөд цөл нутагт үлдэж хоцорчээ. Орчин үед хавтгай тэмээ Монголын Алтайн өвөр говь буюу Говийн их ДЦГ-ын “А” хэсэг, Хятадын Шинжаан мужийн Такламаканы цөл болон Аржин шан уул, Лоб нуурын хавтгай хамгаалах нөөц газар болон Ганьсу мужийн Гашууны говьд тархжээ. Монгол орны хавтгай тэмээний үндсэн тархац нутаг Говийн их ДЦГ-ын “А” хэсэгт хамаардаг. Гэвч хааяа өвлийн улиралд цөөн тооны бодгалууд Баянхонгор аймгийн Баянлиг, Баянговь сумын урьд говь, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Нэмэгтийн хоолой, Ингэн хөөврийн хоолой, Сэврэй сумын урьд говьд гүйдлээр тохиолдоно<sup>20</sup>.

Ороо нийллэг нь 1-2 дугаар сард болж нэг жил өнжөөд, 3-4 дүгээр сард төллөж, нэг ботго төрүүлнэ. Хээлээ 408-430 хоног тээнэ. Ингэ 3-4 нас, харин буур 5 нас хүрч үржилд орно. Буур хэд хэдэн ингэ хурааж хээлтүүлнэ. Бууртай хавтгайн сүрэг дунджаар 10-аас илүү бодгалтай байх авч, заримдаа 17-33 бодгалтай том сүрэг тохиолдоно. Орсон буур орооныхоо үед идээшлэхгүй, гэдсээ татна. Өглөө, орой ихэвчлэн бэлчээрлэнэ<sup>21</sup>.

Говийн их дархан газрын захиргаа анх 1987 оны хавар хавтгайн нялх ботго барьж тэжээснээс хойш гучин жил улирчээ. 1989-1991 оны хавар жил дараалан нийтдээ 20 гаруй ботго барьж гэрийн ингэнд авахуулан хөхүүлэх, хуурай сүү болон ингэний сүүгээр угжиж торниулан, дараа нь өвс бэлчээрт гарган хариулж маллах зэргээр бойжуулж, үржлийн насанд хүрсэн эр, эм бодгалийг орооны үед гэрийн тэмээнээс тусгаарлан хашиж үржүүлэх зэргээр манай орон хавтгайн ботго барьж гаршуулан өсгөх, Захуйн говьд нутагшуулан үржүүлэх гэсэн хоёр үе шаттайгаар хагас зэрлэг байдлаар үржүүлж ирсний дүнд өнөөдөр Захуйн усны хавтгай үржүүлгийн төвд 33 хавтгай бүхий үржлийн сүрэг бүрдсэн байна. Хавтгай гаршуулан үржүүлэх ажил шулуун дардан замаар яваагүй янз бүрийн бэрхшээлтэй байнга тулгарч иржээ. Дархан газрын захиргаа улсаас тусгайлан олгосон төсөв хөрөнгөгүй,

<sup>19</sup> Монгол хос бөхт тэмээ / Эмхэтгэсэн Ө.Эрдэнэбилэг, Ч.Цогттуяа.- Даланзадгад.:Сод Пресс ХХК., 2016. т.134-135. (дам ишлэв).

<sup>20</sup> Б.Мижиддорж. Алтайн чанад говийн хөхтөн амьтад.-УБ.:Мөнхийн Үсэг., 2018.-т.125.

<sup>21</sup> Мөн тэнд. т. 128.

өөрсдийн хүч, нөөц бололцоонд тулгуурлан энэхүү ажлыг 1987-2003 он хүртэл дангаар хийж, 2003 оноос Английн “Хавтгай хамгаалах сан” хавтгайн хашаа барих, хавтгай маллагчийн цалин, өвс тэжээл авах, тэвэрлэх зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтарч ажиллаж ирснийг мэргэжилтнүүд өгүүлдэг<sup>22</sup> байна.

Төв Азийн нутаг дахь зэрлэг тэмээ буюу хавтгайны талаархи мэдээллийг Оросын жуулчин Н.М.Пржевальский, П.К.Козлов, М.В.Певцов, А.Д.Симуков болоод Э.М.Мурзаев нарын олон тооны экспедицүүдийн шинжилгээнээс харж болно.

Харин XX зууны эхэн үеэс өнөөг хүртэлх хугацаанд Монгол орны хавтгайн талаар зориуд шинжлэн судалсан эрдэмтэд гэвэл А.Г.Банников, В.Е.Соколов, В.Н.Орлов, Л.В.Жирнов, В.О.Ильинский нар. Харин Монголын эрдэмтдээс А.Болд, Д.Цэвэгмид, О.Шагдарсүрэн, С.Дуламцэрэн, Р.Тулгат нарыг дурдаж болох юм. Эдгээр эрдэмтэд хавтгайн тоо толгой болоод тархалт, байршил, үржил зэрэг биологийн олон янзын онцлог шинж байдлуудын тухай илүү нарийн судалжээ.

Зөвхөн Алтайн өвөр говьд хамаарах хавтгайны талаархи илүү тодорхой тоон мэдээлэл анх XX зууны 40-өөд оны үед хамаарагддаг. Говиор аялсан хээрийн шинжилгээний материалын үр дүнгээс авч үзэхэд, хавтгайн тоо толгой 300 орчим байсан талаар А.Г.Банников (1945) тэмдэглэжээ. 1959-1960-аад оны үед энэ бүс нутаг дахь тэмээн тоо толгой хэдийн 400-600 тоо толгойд (Дементьев, Цэбегмид: 1963) хүрчээ. Хавтгайн тоо хэмжээг тогтоох дараачийн оролдлогыг А.Г.Банников 1975 онд гүйцэтгэжээ. Автомашинаар 600 км аялан явахад 28 тэмээтэй тааралдаж, нийт хэмжээгээр 900 хэмээн тооцоолжээ<sup>23</sup>. Эдүгээ хавтгайн тоо толгой 800 гаруйд (2012 оны байдлаар) хүрээд байна.

Тэмээг биологийн хийгээд мал аж ахуйн талаас нь маш олон эрдэмтэд судалжээ. Тэдгээр эрдэмтдийн хийсэн судалгаанаас тус ажилдаа чадахын хэрээр ашиглалаа. Харин ёс заншил, зан үйл, нийгэм-соёлын амьдралд үзүүлэх тэмээний талаарх судалгаа төдий л олон биш байна. Тэмээг монголчууд олон зуун, мянган жилийн турш тээвэр, уналгын байдлаар ашиглаж ирсэн түүхтэй. “Торгоны зам”, “Цайны зам” зэрэг улс орны эдийн засаг, стратегид чухал ач холбогдол, үүрэг нөлөөтэй оролцож ирсэн тэмээтэй холбогдох сэдвээр угсаатны зүйч Ц.Гочоо “Тэмээн уралдааны тухай (этнографийн тэмдэглэл)” (1965), “Тан тулга, мөнгөн буйл” (“Угсаатан судлал” сэтгүүл, 1965), “Аян жин тээхтэй холбогдсон зарим зан үйлийн товч тэмдэглэл” (2002?), Ц.Насанбалжир “Монголын аян жингийн асуудал” (ШУА-ийн мэдээ, 1975:№04), Д.Нансалмаа “Халх аян жингийн уламжлалт ёс горимоос” (“Түүхийн судлал” сэтгүүл, 1990), М.Энхбаатар “Тэмээ ачих дараалал” (“Угсаатан судлал” сэтгүүл, 2017), Д.Өрнөхдэлгэр “Монголчуудын тэмээн жингийн соёл” (2021) зэрэг өгүүллүүдийг нийтлүүлжээ.

---

<sup>22</sup> Л.Батцэнгэл. Тэмээн гөрөөс хэмээх зэрлэг хавтгай байгаль дээр цөөрсөөр / “Өдрийн сонин”-ы нийтлэл. 2017 оны 11-р сар.

<sup>23</sup> Л.В.Жирнов, П.Д.Гунин, Яд. Адьяа. Дикий двугорбый верблюд Центральной Азии: среда обитания, биологические особенности и проблемы сохранения. М., 2011. Стр 102.

## Хавтгай тэмээний хорогдол

Судлаач Х.Түмэннасан, Ч.Батцэцэг<sup>24</sup> нарын судалгаанаас үзвэл Алтайн өвөр говийн саарал чононы идэш тэжээл дотор том хөхтөн амьтад дундаас хавтгай тэмээний эзлэх хувь хэмжээ хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.



Алтайн өвөр говьд саарал чонон идэш тэжээлд ийнхүү хавтгай тэмээ зонхилж байгааг юуны өмнө хавтгай тэмээний ботгоны хорогдолтой холбон үзэх боломжтой. Тухайлбал, 1986-1988 мөн 1990-1994 онд Р.Тулгат нарын явуулсан судалгаагаар хавтгай тэмээний популяцид ботгоны эзлэх хувь 3-5 сард дунджаар 12.4 хувь байснаа 9-12 сард 4.5 хувь болон буурч өөрөөр хэлбэл 3 ботго тутмын 2 нь 0-8 сарын настайдаа хорогдсон байгааг тогтоожээ.

Энд мөн тус судлаачдын гаргасан бас нэг сонирхолтой дүгнэлт нь: Хавтгай тэмээний буур орооны өмнөх үедээ хоорондоо ноцолдож, бие биенээ гэмтээх, улмаар барих ч тохиолдол ажиглагддаг байна. Х.Түмэннасан, Ч.Батцэцэг нарын судлаачдын 2004, 2005 оны үед хийсэн хэрийн судалгааны явцад хавтгай тэмээний орооны дараа шархдаж гэмтсэн 6 буур байгааг тэмдэглэсэн бөгөөд тэдгээрийн 2 нь хорогдсон болохыг тогтоожээ (хүснэгт 2).

№	Газрын нэр	Солбицол	Огноо	Тайлбар
1	Давхар харын нуруу	N 43 37 165 E 096 59 945 Alt 1075 m	2005.02.15	Залуу буур хойд хөл доголлон байсан бөгөөд 600-аад метр ойртсон.
2	Хар сайрын хөндий	N 43 50 506 E 096 50 234 Alt 1120 m	2005.02.17	Хээлтэй 6 ингэ, 1 залуу буур бүхий сүрэг. Буурны зөв талын урд хөл доголлон байв.

<sup>24</sup> Х.Түмэннасан, Ч.Батцэцэг. Алтайн өвөр говийн саарал чоно (canis lupus)-ны идэш тэжээлийн асуудалд //Хавтгай тэмээний хамгаалал ба менежмент олон улсын хурал 2006//, Ред. Я.Адъяа, Б.Лхагвасүрэн., УБ., 2007. т.57.

3	Арслан хайрхан		2004.01.15	Урд болон хойд хөл нь шархдсан, хүзүүний дунд хэсгээрээ цус болсон хавтгайн залуу буур.
4	Атасын ар аараг	N 43 28 750 E 096 47 116 Alt 1146 m	2004.02.01	1 сүргийн 8 буур үзсэнээс нэг нь хойд хөл түнхээрээ гэмтсэн болов уу гэмээр гишгэж чадахгүй хөлөө чирэн явж байсан.
5	Арслан хайрхан уулын баруун тоот өндөрлөг	N 43 35 915 E 096 16 710 Alt 1196 m	2004.02.11	Хоолойгоо чононд хазуулан үхсэн буурны сэг байв (Энэ буур 2004.01.15-нд тэмдэглэгдсэн буур биш).
6	Атасын ар хоолой	N 43 28 750 E 096 47 116 Alt 1075 m	2004.04.08	Баруун хойт хөл доголон буур

Хүснэгт 2. Орооны үед гэмтэж бэртсэн хавтгайн буурны мэдээ

Ийнхүү гэмтэж шархадсан буур нь үхэх эсвэл биеэ хамгаалах чадвар муудсаны улмаас чононд бариулж хорогдох нөхцлийг бүрдүүлдэг бололтой. Ийм тохиолдлыг өмнөх судлаачид ч мөн тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд хавтгайн буурын хорогдолд бэлгийн шалгарлын нөлөө байна<sup>25</sup>.

Үүний зэрэгцээ нутгийн анчид эрт дээр үеэс хавтгай тэмээний өөх махыг хүнсэндээ ашиглаж ирсэн тухай аман мэдээ байдаг ба агнахыг хориглож, амьдрах нутгийг улсын тусгай хамгаалалтад авснаас хойш ч хулгайгаар агнах тохиолдол гарч байжээ (Бадамханд нар, 1990). Говийн их ДЦГ-ын ажилтнууд 1992-2012 оны хооронд хавтгай агнасан 6 зөрчил илрүүлж, хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлж байжээ... Мөн хил давах тохиолдлууд ихээр гардаг байна. ДЦГ-ын биологич мэргэжилтнүүд болон хилийн цэргийн ажилтнуудын мэдээлснээр 1994, 1995 оны намар, өвөл нийт 60 гаруй хавтгай бүхий 2 сүрэг, 1998 онд 23 хавтгай, мөн ганц нэгээрээ болон цөөнөөрөө хил давсан тохиолдлуудыг тооцвол 1992 оноос хойш дор хаяж 100 гаруй хавтгай өмнөд хөршийн хил давжээ. Харин өмнөд хөршийн нутгаас манай нутагт орж ирсэн нь тун ховор. Хатан суудлын хил орчмоор 2009 оны өвөл 1 дүгээр сард 8 толгой хавтгай орж ирсэн гэхээс өөр мэдээлэл алга байна. Сүүлийн жилүүдэд “Синьхуа” агентлаг болон хятадын Ойн товчооны мэдээллийн сайт болох [www.greentimes.com](http://www.greentimes.com) болон бусад хэд хэдэн сайтуудад Хятадын Шинжаан Уйгур болон Ганьсу мужийн зэрлэг тэмээн сүрэг мэдэгдэхүйц олширсон тухай мэдээлжээ. Эдгээр мэдээллийн заримаас дурдвал 2015 онд Ганьсугийн нутагт 124 хавтгай өөр газраас нүүдэллэн ирсэн тухай, 2016 оны 6-р сард Ганьсу мужийн Жиньзи гэдэг газарт шинээр 33 хавтгай бүхий 3 сүрэг, үүнээс 4 ботго ирснийг бүртгэжээ. Хавтгайн популяцид нөлөөлөх нэг хүчин зүйл бол халдварт өвчин байна. 1980-аад оны үед цэргийн ангийн гэрийн тэмээ хамуурснаас хавтгай тэмээнд халдварлаж байсан тохиолдол гарч<sup>26</sup> байжээ.

<sup>25</sup> Х.Түмэннасан, Ч.Батцэцэг. Алтайн өвөр говийн саарал чоно (canis lupus)-ны идэш тэжээлийн асуудалд //Хавтгай тэмээний хамгаалал ба менежмент олон улсын хурал 2006//, Ред. Я.Адъяа, Б.Лхагвасүрэн., УБ., 2007. т.60.

<sup>26</sup> Б.Мижиддорж. Алтайн чанад говийн хөхтөн амьтад.-УБ.:Мөнхийн Үсэг., 2018.-т.131.

## Бэсрэг тэмээ (эрлийз тэмээ)

Эрлийз тэмээ маллаж буй малчдын судалгаанаас (2006) үзвэл Бэсрэг тэмээний бараг 98 хувь нь хавтгайн “хөөгдмөл” буур ирж ингийг хураасантай холбоотой юм. Энэ нь тухайн малчны талаас ямар нэг хууль, дүрэм зөрчөөгүйг нотлох баримт болж (хэрвээ малчны орчны бүсэд амьдардаг бол) байна. Учир нь хавтгайн буур орооны үед маш догшин ширүүн болж, хүн барих аюултай болдгоос түүнийг хөөж туух нь түүний амь насанд шууд эрсдэлтэй алхам болдог. Ийм үед их дуу чимээ гаргах, тухайлбал буу тавихаас өөр арга байхгүй боловч энэ нь хориотой учир ингээ хураалгаад өнгөрдөг байна. Ийм байдлын зохицуулах талаар ТХГН, түүний орчны бүс, хамгаалалтын дэглэм журманд заасан арга хэмжээ байдаггүй нь хавтгай тэмээ хамгаалах цогц бодлого өнөө хүртэл байхгүйтэй холбоотой байна. Бэсрэг тэмээ хэрхэн бий болдог вэ?

Нэгд. Өвлийн улиралд байгаль цаг уурын бэрхшээлтэй үед дархан газрын хамгаалалтын бүсэд малчид гэрээгээр нутагладаг. Энэ үед хавтгайн хөөгдмөл буурнууд монгол буурнаас ингийг булаан авч үржилд ордог.

Хоёрт. Бэсрэг тэмээний хурд ихтэй, хүч тамир сайтай, тууш хол замд эдэлгээ сайн даадаг, хоол тэжээл голдоггүй гэх зэрэг зарим давуу талыг илүүд үзэж зарим малчид санаатайгаар гэрийн тэмээгээ хавтгай тэмээний байршил нутагруу ойртуулан бэлчээдэг.

Гуравт. Малчин өрхүүдийн гаргаж авсан бэсрэг тэмээний ингэнүүд цаашид үржилд орж үе үеийн эрлийзүүдийг төрүүлсээр байгаа болно. Малчин өрхүүдэд байх бэсрэг тэмээний эрийг ихэвчлэн агтлах тул, бэсрэгэн буур гэж байдаггүй. Харин бэсрэг ингэ цаашид үржилд орж 2-3 үеийн эрлийзүүдийг төрүүлдэг. Гэвч эдгээр нь ашиг шим, амьдрах чадварын хувьд монгол болон бэсрэг тэмээнээс муу байх тул малчид төдийлөн дуртай биш. Малчин өрхүүдэд байгаа бэсрэг тэмээ нь хавтгай тэмээний тоо толгой, удмын санд үзүүлэх ноцтой сөрөг нөлөө бага, харин монгол тэмээний зарим нэг сул талыг сайжруулах ач холбогдолтой гэх үзэл гарчээ<sup>27</sup>.

---

<sup>27</sup> Д.Энхбилэг, Г.Довчиндорж, А.Доржготов, Яд.Адъяа. Говийн дархан газрын А хэсгийн орчны бүс нутгийн бэсрэг тэмээний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх менежментийн асуудал //Хавтгай тэмээний хамгаалал ба менежмент олон улсын хурал 2006//, Ред. Я.Адъяа, Б.Лхагвасүрэн., УБ., 2007. т.45.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### МОНГОЛ ТЭМЭЭНИЙ ӨВ СОЁЛ, УЛАМЖЛАЛЫН ТАЛААРХИ СУДАЛГААНЫ ХӨТӨЛБӨР -2023

Судалгааны агуулгад тохируулан доорх асуулгуудыг боловсруулсны үндсэн дээр ярилцлагаа төлөвлөн гүйцэтгэлээ. Тэгэхдээ ерөнхий асуулгуудаас эхлэн асуултаа гүнзгийрүүлэх байдлаар асууж, асуудлын гүнд нэвтрэхийг эрмэлзэв. Судалгаа хийхэд орон зай, алслалтын байдал, цаг хугацаа давчуу зэрэг байдлаас хамаарч зарим хүндрэл бэрхшээлтэй зүйлүүд тулгарч байсныг тэмдэглэмээр байна. Хэдий тийм боловч энэ нь судалгааны үндсэн чиг шугамд нөлөөлөөгүй билээ.

#### ЭХЛЭЛ

1. Таны алдар нэр хэн бэ?
2. Хэдэн настай вэ? Өөрийнхөө тухайд товч танилцуулна уу?
3. Таны ургийн овог юу вэ?
4. Та одоо хаана амьдардаг вэ?
5. Тэмээнээс өөр зэрлэг амьтад болох хулан, тахь, аргаль, янгирын тухай та юу мэдэх вэ?
6. Та ямар мал малладаг вэ?

#### ЕРӨНХИЙ АСУУЛГА

7. Танайх тэмээтэй юу?
8. Та хэдэн тэмээтэй вэ?
9. Яагаад тэмээ өсгөх болсон бэ?
10. Та хэдэн жил тэмээ малласан бэ?
11. Аль үүлдрийн тэмээ малладаг вэ?
12. Таны тэмээн дотор онцгойлж хайрладаг тэмээ байдаг уу?
13. Та зарим тэмээндээ нэр өгдөг үү?
14. Хэрэв тийм бол ямар нэр өгдөг вэ?
15. Эрхэмлэдэг тэмээний өнгө зүс юу вэ?
16. Тэмээтэй холбоотой эд хэрэглэлүүд юу байдаг вэ? Нэрлэнэ үү?
17. Тэмээ, ингэ, буур гэх зэрэг нэр орсон газрын нэр юу байдаг вэ?
18. Орсон буур аюултай амьтан уу? Хэрэв хүнрүү дайрвал яаж хамгаалах вэ?

#### ХАВТГАЙ БА БЭСРЭГ ТЭМЭЭНИЙ ТАЛААРХ МАЛЧДЫН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

19. Хавтгай тэмээний талаар та юу мэдэх вэ?
20. Хавтгай тэмээ үзсэн үү?
21. Хавтгай ер нь ямар онцлогтой амьтан бэ?

22. Танай тэмээнд бэсрэг тэмээ бий юу?
23. Бэсрэг тэмээний онцлог нь юу байдаг вэ?
24. Ач холбогдолтой болон сул тал нь юу байдаг вэ?
25. Та сүрэгтээ бэсрэг тэмээг нэмэгдүүлэх тухай боддог уу?

#### МОНГОЛ ТЭМЭЭНД ХОЛБОГДОХ УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛ, ЗАН ҮЙЛ, ШҮТЛЭГ

26. Та тэмээтэй холбоотой зан заншил мэдэх үү?
27. Гүнжлхам гэж мэдэх үү?
28. Тэмээтэй холбоотой овоо тахилга, ном судар мэдэх үү?
29. Тэмээтэй холбоотой зүйр үг, хууч яриа, аман домог мэдэх үү?
30. Тэмээг оршуулганд хэрэглэдэг байсан талаар юу мэдэх вэ?
31. Тэмээний бурантагны модыг яаж авдаг вэ? Ёс горим бий юу?

#### МОНГОЛ ТЭМЭЭ НИЙГМИЙН АМЬДРАЛД

1. Тэмээн жингийн талаар та юу мэдэх вэ?
2. Жингийн болон нүүдлийн үед тэмээний зохион байгуулалт яаж хийгддэг вэ? Ямар тэмээг хаана байрлуулах ёстой байдаг вэ?
3. Та тэмээн уралдаанд оролцож байсан уу?
4. Тэмээн уралдаан анх хэзээ танай нутагт зохиогдож эхэлсэн бэ?
5. Танай нутаг “мөнгөн буйл”-тай юу?
6. Танай нутагт “алтан ботго”-ны эзэн бий юу?

#### МОНГОЛ ТЭМЭЭНИЙ ЭДИЙН ЗАСАГ БА ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

7. Тэмээг хэдий үед ноосолдог вэ?
8. Тэмээнээс хэдэн кг ноос гардаг вэ?
9. Өөрсдөө тэмээний ноосоор юм хийдэг үү?
10. Тэмээний сүүн цагаан идээний талаар ярина уу?
11. Онцлог нь юу вэ?
12. Тэмээний мах иддэг үү?
13. Хэр иддэг вэ? Ямар үед иддэг вэ?
14. Тэмээ одоо ямар үнэ ханштай байгаа вэ?
15. Тэмээтэй холбоотой өөр шагнал, урамшуулал юу байдаг вэ?
16. Төрөөс тэмээнд холбогдох ямар нэгэн бодлого, дэмжлэг, урамшуулал юу байдаг вэ?
17. Тэмээний хэрэглээ нэмэгдэж байна уу? буурч байна уу?
18. Цаашид тэмээгээ малласаар байх уу?
19. Удам залгах тэмээчин бий юу? Бэлтгэж байгаа юу?

**Судалгаанд оролцогчидын талаархи ерөнхий мэдээлэл**

№	Судалгаанд оролцогчид	Хаана амьдарч байгаа вэ?	Ямар мал малладаг
1	Гэндэнгийн Дашчирэв	Баянхонгор аймгийн Шинэжинст сум, сумын төв	Тэмээ
2	Сонгуулийн Жуул	Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын “Зэлтэрийн гялаан”-д	Тэмээ, хонь, адуу, ямаа
3	Хайдавын Ишцэн	Баянхонгор аймгийн Баянлиг сумын “Цагаан толгой”-д	Тэмээ, ямаа
4	Чимбэгийн Сугар-Очир	Баянхонгор аймгийн Баянлиг сумын 5-р багт	Тэмээ
5	Рэндоогийн Нансал	Баянхонгор аймгийн Баянлиг сумын 5-р багт	Тэмээ
6	Готовын Тойвгоо	Баянхонгор аймгийн Баянлиг сумын “Тарав”-д	Тэмээ, адуу, хонь, ямаа

Судалгаанд оролцогчид дотроос хамгийн залуу нь 44 настай, ахмад нь 74 настай байна. Мал сүргийн бүтцийг харвал голдуу тэмээ эсвэл тэмээ, ямаа гэсэн мал маллаж байна. Энэ нь тухайн бүс нутгийн бэлчээрийн онцлогт тохирдогтой холбоотой аж.

№	Судалгаанд оролцогч	Нас	Хүйс	Ургийн овог	Тайлбар
1	Гэндэнгийн Дашчирэв	73	Эр	Бэсүд	Тэтгэвэрт
2	Сонгуулийн Жуул	44	Эр	Шармаан	“Алтан ботго”-ны эзэн
3	Хайдавын Ишцэн	74	Эр	Өвгөн Жигжид	Тэмээчин
4	Чимбэгийн Сугар-Очир	67	Эр	Өөлд	Хөдөлмөрийн баатар “тэмээчин”
5	Рэндоогийн Нансал		Эм	Халанхай	“Алтан ботго”-ны эзэн
6	Готовын Тойвгоо	70	Эр	Алдар	Хөдөлмөрийн баатар “тэмээчин”

Судалгаанд оролцогчдын тэмээ өсгөх болсон шалтгаан нь голдуу үе удам залгамжилсан онцлогтой буюу 3-4 үеийн тэмээчин удамтай нь ажиглагдаж байна. Хугацаа давчуу байсан тул бусад үүлдэр болох Галбын говийн улаан, Төхөм тунгалагийн хүрэн зэрэг үүлдрийн тэмээ малладаг малчидтай ярилцаж чадсангүй. Гэвч хугацаа товлосон болно.

№	Судалгаанд оролцогч	Хэдэн тэмээтэй?	Аль үүлдрийн тэмээ малладаг?
1	Гэндэнгийн Дашчирэв		Ламын гэгээний улаан тэмээ
2	Сонгуулийн Жуул	500 гаруй	Ханын хэцийн хүрэн
3	Хайдавын Ишцэн	150-160 орчим	Ламын гэгээний улаан
4	Чимбэгийн Сугар-Очир	200 гаруй тэмээтэй.	Ламын гэгээний улаан
5	Рэндоогийн Нансал	Тэмээгээ цөөлсөн	Ламын гэгээний улаан
6	Готовын Тойвгоо	580 гаруй	Ламын гэгээний улаан



Эдгээр малчид бүгд тэмээтэй холбоотой эд хэрэглэлүүдийг нэрлэж байсан ба тэмээндээ онцгойлж хандах буюу нэр зүс өгөх явдал түгээмэл болох нь илт байна. Түүнчлэн тэмээ, ингэ, буур зэрэг нэр орсон газрын нэрс болоод холбогдох зарим тайлбарыг хийж байлаа. Ишцэн гуай Баянхонгор болоод Өмнөговь аймгийн зааг дээр “Цагаан буур хайрхан” гэж байдаг ба түүнийг зүүн тийшээ хараад шавж буй хэлбэртэй, өмнө нь тахиж байсан хайрхан байсан талаар бидэнд мэдээлэв. Энэ мэдээллийг тэмээчин Г.Тойвгоо мөн батлан өгүүлсэн болно.

Орсон буур нь хэдий аюултай амьтан боловч зарим тохиолдолд тухайн буурныхаа зан араншин зэргээс шалтгаалдаг болохыг эдгээр тэмээчид ярьж байлаа.

Хавтгай ба бэсрэг тэмээний талаар эдгээр малчдын ерөнхий ойлголт бага зэргийн зөрүүтэй гэвч ихэнх тохиолдолд нэгдмэл байр суурьтай байгаа нь ажиглагдлаа. Өмнөговийн тэмээчин С.Жуул болоод хөдөлмөрийн баатар тэмээчин Г.Тойвгоо нар хавтгай тэмээг биеэр үзээгүй ч бэсрэг тэмээний талаар тодорхой хэмжээний ойлголттой байна. С.Жуулын хувьд аймаг, сумынхаа тэмээн уралдаанд төдийлөн оролцож байгаагүй, оролцдоггүй тул “бэсрэг тэмээ”-тэй болох шаардлагагүй гэж үздэг аж. Бэсрэг тэмээний нэг онцлог нь их хурдан гэнэ. Харин Ч.Сугар-Очирын ажигласнаар бэсрэг тэмээ нь 1, 2-р үедээ их ярдаг догшин, эдэлгээнд хатуу байх ба дараа дараагийн үе буюу 3-4 дүгээр үедээ их зөөлөн дөлгөөн, эдэлгээнд таарч ирдэг тухай ярих. Бэсрэг тэмээ буюу зэрлэг тэмээ нь сүү ихтэй, их тослог, уураг сайтай байдаг тухай малчин Р.Нансал ярих. Тэрээр олон төл (ботго) бойжуулан өсгөсөн тул “алтан ботго”-ны эзэн, аварга саальчингаар тодроод байгаа билээ.

Дашчирэв гуайн хувьд Шинэжинст сумын иргэн агаад хуучин түүний багад нутаг оронд нь хавтгай тэмээ ихээр сүрэлгэн амьдарч байсан гэнэ. Харин одоо хавтгай байсан тэр газар огт эзгүйрчээ. Түүний үзэж буйгаар байгалийн шалгарал явагдаж хавтгайн буурнууд хүчтэй нь хүчгүйгээ хөөсний улмаас “хөөгдмөл буур”-нууд нь шахагдан малчин айлын тэмээн сүрэгт ойртож монгол тэмээний буурнуудыг хөөн ингийг нь хурааж байгаа болохоос биш малчид өөрсдөө санаатайгаар тэмээгээ хээлтүүлэх зүйл байдаггүй аж.

Бэсрэг тэмээний онцлог нь их хурдан ба хол тууш замд эдэлгээ сайн даадаг, сүү сааль арвинтай байдаг гэнэ. Харин сөрөг тал нь ноос үс багатай, эдэлгээнд хатуу, ярдаг догшин зантай байгаа нь ажиглагддаг тухайд малчид санал нэгдэж байна.

Ишцэн гуайн тэмээнд 2000 хэдэн оны үеэр нэгэн хавтгайн буур орж ирэн тэдний хэд хэдэн ингэ хээлтүүлсэн гэнэ. Одоо тэр бэсрэгийн 4-р үеийн эрлийзүүд сүрэгт нь байдаг аж.

Тэмээ салхи сөрж явдаг онцлогтой амьтан тул байгалийн хүчин зүйлээс шалтгаалж айлын малд ойртож ирэх тохиолдол байдаг тухай маш сонирхолтой мэдээллийг тэр бидэнд өгсөн юм.

Монгол тэмээтэй холбоотой зан заншил, уламжлалт шүтлэг болоод тахилгатай уул хайрхан буй эсэх талаар С.Жуул, Х.Ишцэн нарын мэдээлэл үнэ цэнтэй байна. Тухайлбал С.Жуулын ярьсан нь: Буйлыг бол дэлгүүр хоршоонд зарж л байдаг юм. Миний хувьд бол өөрөө яваад авчихдаг. Буйлыг говьд ургадаг буйлс гэж мод байдаг, тэрүүгээр хийдэг. Гэхдээ тэр модыг авдаг газар, авдаггүй газар гэж бас бий. Ерөнхийдөө бол *идэр гурван есийн хүйтэнд лус савдаг унтаж байх үеэр очиж авдаг ном журамтай* хэмээсэн юм.

Х.Ишцэн гуайн ярьсан нь: Орсон буурын орой (толгой) дээр лхам бурхан залардаг гэж ярьдаг. Тиймээс орсон буурыг зоддоггүй, харааж зүхдэггүй, уналгад хэрэглэдэггүй юм гэдэг. Орсон буурыг ихэд хүндэтгэдэг. За тэгээд орсон буур байхад буурны ижил сүрэг рүү боохой орно гэдэг тун ховор шүү дээ. Хааяа нэг тохиолдол л байна гэхээс биш. Манайхны айлуудад тэр Гүнжилхам бурхан гэж байдаг. Харин манайд бол байхгүй. Тэмээний банзрагч гэж бурхан бий. Хоёр талдаа даавуун савхитай том бурхан байдаг. Цагаан сараар бол буур

жинхэнэ ид улаан галзуу дээрээ байдаг. Энэ үед цагаан сарын өглөө эрт босоод буур хаашаа хараад шавж зогсож байна. Түүгээр зун болно гэж бид байгаль дэлхийг шинждэг гэв. Энэ мэдээлэл бол тэмээтэй холбоотой уламжлалт шүтлэг, зан үйлийн судалгаанд чухал ач холбогдолтой юм.

Монгол тэмээний нийгмийн амьдралд гүйцэтгэж байсан үүрэг хийгээд тэмээн уралдаантай холбоотой сонирхолтой мэдээллүүдийг малчид өгч байлаа. Х.Ишцэн гуайгийн аав Хайдав бол ХХ зууны эхэн үед тэмээн жинд олон удаа явж байсан туршлагатай жинчин байжээ. Мөн тэр өөрөө орон нутгаасаа хамгийн сүүлд жин тээсэн цөөн хэдэн хүний нэг гэнэ. Энэ бол 1967 он байжээ. Одоо тэр үед Х.Ишцэн гуайтай хамт жин тээж явсан 9 хүнээс цөөн хэдэн өвгөд үлджээ. Тэд Баянлиг сумаас Хархорин, Баянлиг – Улаанбаатар гэсэн чиглэлээр гурил будаа зэрэг ачаа тээж ирсэн байна. Тухайн үед жин тээхээр бригад тус бүрээс 3 хүн ороод есүүлээ болж байж. Нийтдээ 100 гаруй тэмээтэй явж байсан гэнэ. Тэмээгээ сонгож авахдаа ачаа даах, алс хол явах чадал чансаатай тэмээнүүдээ айлууд нь өөрсдөө сонгоод өгч байсан гэнэ. Нэг тэмээ ойролцоогоор 250 орчим кг ачаа даадаг. Харин алсын жинд бол 170, 180 орчим кг ачаа л ачиж явдаг учиртай аж.

Ачаалж явахад, хамгийн номхон, ачаа сайхан даадаг тэмээгээ “гарын тэмээ” гэж гарт авч явдаг. Жаахан авир араншинтай тэмээгээ хойно нь хавчуулдаг гэнэ. Тэгээд тэрхүү ачааны хамгийн сүүлийн тэмээнд хонх явдаг. Шөнө дөл явж байгаад хонхны дуу гарахгүй бол ямар нэгэн саад гарч ачаа тасарсан байх магадлалтай. Хүн заримдаа үүрэглэж барьж, анхаарал алдах тохиолдол бас байдаг аж. Ард, өмнө талд нь бас “ачаа шорлож явдаг хүн” гэж хоёр хүн явна. Ард яваа хүнийг бас “хоргол хөөж яваа хүн” гэж ярьдаг байж. Харин арай өмнөхөн яваад энд тэнд ганга эрэг байна гэх зэрэг газар үзэж явдаг хүнийг ачаа шорлож явдаг хүн гэдэг байжээ. Хэрэв ачаатай хамт хүүхэд нүүж яваа бол хүүхэд ачсан тэмээгээ нэг гартаа барьдаг аж. Тэгээд араас нь бурхан ачсан тэмээгээ уядаг байна. Харин хүүхэдгүй бол бурхан ачсан тэмээгээ эхэлж гартаа барьж явдаг гэнэ.

С.Жуулын төрүүлсэн эцэг нь БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, тэмээчин Түдэвийн Шар гэж хүн байжээ. Тэр хүн 1980-аад оны сүүлчээр “алтан ботго” (алтан төл) авч байжээ. Харин С.Жуулын хувьд 3 жил орчмын өмнө энэхүү шагналыг авч байжээ.

Монгол тэмээнээс гарч байгаа ашиг шим өнөөгийн монголын нийгэмд хэрхэн үнэлэгдэж буй эсэх талаар бид зарим зүйлийг тодруулав. Тэмээний үнэ ханш нь нас болоод биеийн хэмжээнээсээ хамаараад янз бүр аж. Ингэ 1 сая гаруй, сайн атан тэмээ 2 сая, харин тором зэрэг багаахан амьтад 500 мянгаас 1 сая төгрөгийн хооронд үнэлэгдэх жишээтэй байна. Түүнчлэн хэрэв цаг үе хатуу, ган зудын байдалтай байвал тэмээний гаралтай зарим түүхий эд тухайлбал, хоормогны үнэ зэрэг нь нэмэгддэг аж. Учир нь тэмээ бол жил өнжиж ботголдог, сааль урттай амьтан гэнэ. Тэмээний ноосны үнэ ханш жил жилд янз бүр байдаг аж. Саяхан хэдэн жилийн өмнө гэхэд л нэг удаа тэмээний ноос 1 кг нь 20 мянган төгрөгд хүрч байжээ. Харин өнгөрсөн жилд 1кг нь 10 мянга орчимтой байсан гэнэ. Тэмээ мөн л нас, хүйснээсээ хамаараад ноосны жин зөрүүтэй гардаг аж. Багадаа 5, 6 кг түүнээсээ дээшлээд нэг тэмээнээс 20 орчим кг хүртэл гарах тохиолдол байдаг гэнэ.

Судалгаанд оролцогчид бүгд одоо тэмээний мах иддэг хэмээн хариулсан юм. Харин урьд үеийнхэн нь буюу аав, ээж, өвөө, эмээгийнх нь үед тэмээний мах иддэггүй тэрбүү хэл тэмээний мах идсэн айлд орох хүртэл хориотой байсан тухай дурсацгааж байна. Тухайлбал, Ишцэнийн ярьсан нь: Тэмээг манай нутагт тэнгэрийн амьтан гэж үзээд нухаж иддэггүй байсан юм гэнэ билээ. Тэгээд энэ Өмнөговийн урд талын сумдыг Балдан засгийн хошуу гэдэг байсан. Тэнд л тэмээ иддэг байсан гэж ярьдаг байлаа. 1950 хэдэн оны үеэс хойш л тэмээ нухаж иддэг болсон. Бүр тэмээ нухаж идсэн айлд ордоггүй, зугатдаг байсан юм гэнэ

билээ. Одоо ч цаг нь өөр болоод тэмээ нухсан айл руу хошуурдаг болсон юм даг уу. Тэр Балдан засгийн хошууныхныг л дээр үеэс тэмээг хүнсэнд хэрэглэдэг байсан юм гэнэ гэж ярьдаг байсан. Одоо бол тэмээг хамгийн чанартай махтай, хамгийн аагтай өвс ногоо идэж уудаг гээд ноднингоос авахуулаад тэмээ рүү их хошуурдаг болоод байна гэж өгүүлэв. Харин Дашчирэвийн ярьсан нь: Дээр үед бол улсууд хавтгай агнадаг л байсан гэдэг. Нэгдэл нийгмийн үед мал цөөтэй хэцүү л байсан. Мал мах тоо хэмжээтэй ч байлаа, махны бичиг авдаг байв. Тийм нэг үед ан хийж л амьдарч байсан байгаа. Иддэг ургамал нь ижил учир хавтгай, гэрийн тэмээ хоёрын махны амт нь адилхан л байх гэв. Үүнээс үзэхэд ХХ зууны дундуур буюу 1950 хэдэн оны үеэс хойш говийн олон сумын иргэд тэмээний махаар хүнс хийх болсон нь харагдаж байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЭМЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗАН ҮЙЛ, ЗАНШИЛ, ШҮТЛЭГИЙН УЛАМЖЛАЛ

Өөлдийн оршуулгад тэмээнд холбогдох нэгэн зан үйл хадгалагдан хоцорчээ. Талийгчийг оршуулахын урьд өдөр оршуулах газрыг үзэж тогтоодог байна. Үүнийг “Сал авах” гэдэг аж. Шарилыг гаргахдаа гэрийн ханыг гэдрэг нь унагаад яг гэрийн буурь дотор тэмээгээ хэвтүүлдэг аж. Гэрийн эзэн ахмад хүн бол өрхөнд нь гэрийн эзэн биш бол эсгий зэрэгт боож сур, аргамжаар баглаад, аргийг нь уруу харуулж тэмээнд тэгнээд тэр араг дээрээ хөндлөн шарилын толгойг нь буруу тал уруу харуулж ачна. Шарилыг баглаж оролдож буй хүн ханцуйгаа дотогш нь чихсэн байх ёстой.

“Ханцуйгаа дотогш чихдэггүй  
Гэрийн бууцанд тэмээ оруулдаггүй  
Ханыг гэдрэг нь унагаадаггүй

Хатавчаар шагайдаггүй” гэдгийн учир энэ ажээ. Хөдөөлүүлэх газар уруу очихдоо морины шогшоогоор хурдан явна. Оршуулах газар очоод тэмээгээ хэвтүүлээд тэмээн дээр нь шарилын баглааг тайлж нүцгэнээр оршуулахаар өргөж тавина. Тавихдаа нөгөө хураасан журмаар баруун гарыг нь дэрлүүлэн, зүүн гарыг биеийг нь дагуулан тавьж нар руу харуулан нимгэн чулууг гарын доор тавьж дэрлүүлдэг аж. Дээрээс нь номын хөнжил гэдэг зурагтай нимгэн цаасаар бүтээгээд орхино. Дэргэд нь арц уугиулна. Оршуулахад шарилыг оролцуулан тэгш тоотой явж, буцахдаа сондгой тооны хүн буцах ба замдаа арагтай харгана, мод хийж, түлш түүн буцаж ирдэг. Оршуулганд явсан хүмүүсийг ирэхэд замд нь хоёр хэсэг гал түлсэн байна. Хүмүүс түүний дундуур гарч ирнэ. Оршуулганд явсан хүн, морь, тэмээ, аргамж дээс бүхнийг ариутгана. Хүмүүс гар нүүрээ угааж арц рашаанаар ариутгаад гэрт орно<sup>28</sup>. Үйл ажиллагаа энэ мэтээр цааш үргэлжилдэг байна. Өөлдийн дунд мөн

*“Аавдаа хайртай бол*

*Ачаа чанга тат”* гэсэн хэлц байдаг<sup>29</sup> нь энэхүү тэмээгээр шарил зөөвөрлөхтэй холбоотой болов уу. Өөрөөр хэлбэл, “Сал авах” буюу оршуулахаар сонгосон газраа заавал шарилыг хүргэхийн тулд ачаа татлага сайн байх хэрэгтэй гэсэн санаа ажээ. Хэрэв ачаа татлага сайн уяагүй, эсвэл өөр ямар нэгэн байдлаар шарил гээгдвэл, уламжлал ёсоор тэр газар нь шарилыг орхихоос өөр аргагүйд хүрдэг байна.

Судалгааны материалаас үзэхэд эцэг эхийг нутаглуулах газрыг сонгоход онцгой анхаарах ёстой ажээ. Учир нь эцэг эхдээ газар хэрхэн сонгож нутаглуулснаас хамаарч үлдэж хоцорсон үр хүүхэд, ах дүүдээ сайн муу нөлөө үзүүлдэг гэх яриа байна. Үүнд эцгийгээ буруу газар нутаглуулбал үр хүүхдэд нь насан туршид нь муугаар нөлөөлдөг, эхийн газрыг сонгоход сайн муу нөлөөлөл нь гурван жилээс хэтэрдэггүй<sup>30</sup> гэж хэлэлцэх нь бий.

Ийнхүү эцэг эх, элгэн садан, өвөг дээдсээ хүндэтгэн оршуулахтай холбоотойгоор оршуулгын зан үйлд тэмээний үүрэг багагүй байх ажээ. Монголчууд өөд болсон хүнийг гэрт нь зул барьж 3-7 хоног байлгаад хөдөөлүүлдэг. Нас барсан хүний цогцос тээсэн тэмээн хөсөгтэй замд хүн тохиолдвол, бие бараг эр бол тэмээний хом шатны баруун хойд хэсэгт, харин эмэгтэй бол тэмээний хом шатны зүүн талд гар хүрч уй гашуудал илэрхийлдэг.

<sup>28</sup> Н.Намсрай. Өөлдийн соёл, түүхийн бичиг оршивой. УБ.,1999. т.36.

<sup>29</sup> Г.Мөнхтуул (64н, эр, шар шавь ястай, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын харьяат)

<sup>30</sup> Б.Отгонбаатар. Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун) / Хян. Г.Цэрэнханд.-УБ., 2009. т.48.

Шарилыг үхэр тэрэг, тэмээгээр зөөнө. Шарил ачсан тэмээг зардаггүй, нядалдаггүй, хадаг самбай зүүж зөнөтөл нь дархалдаг<sup>31</sup> байна.

Хуучин цаг буюу машин техник хэрэглэхээс өмнөх үед шарил авч явах морь, тэмээ гэх мэт малын зүсийг чухалчилдаг байсан бол одоо цагт цөөн боловч машины өнгө зүсийг харгалзах болсон байна. Өөрөөр хэлбэл, морь малын зүстэй ижил өнгийн машинд талийгаачийг авч явахыг эрхэмлэх болжээ. Зарим тохиолдолд, шарил ачсан мал (морь, тэмээ зэрэг)-ыг 49 хоног дотор уг малыг уналга, эдэлгээнд хэрэглэхээ болих<sup>32</sup> тохиолдол байдаг. Энэ нь үхсэн хүний “яс хүнд байдаг” гэж үздэгтэй холбоотой байна.

Шарил нутаглуулахад ус гол гатлахыг цээрлэдэг байжээ. Ус гарах тохиолдолд усны цаана хүнийхээ сүнсийг үлдээхгүйн тулд “шарил авч яваад гол гарах бол “алтан гүүр хаяна” гэж хөвөөний хоёр талд алтан утас татдаг байжээ... Ийнхүү шарилыг аваад явж байхад гол гатлах бол тэмээнийхээ хойт хөлөнд (ачлаганд) алтан утас уядаг, утасгүй бол усанд мөнгө цацдаг байжээ<sup>33</sup>.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын<sup>34</sup> нутагт “Буурын ам” хэмээх нэртэй газар бий бөгөөд энэ газарт эрт дээр үеэс нааш өнөөг хүртэл өвгөд, дээдсээ оршуулж, нутаглуулсаар ирсэн түүхтэй юм. Мөн “Тэмээчийн улаан толгой” хэмээх газар бий бөгөөд тэр газар нь авгас угийн тэмээч шар Түгж гэдэг хүн байсан талаар судлаач Н.Намсрай бүтээлдээ тэмдэглэжээ.

Ер нь Монгол нутгийн аль ч хэсэгт тэмээ, буур, хавтгай, ингэ, ботго гэсэн нэр оруулж газар нутгаа нэршсэн тохиолдол нэлээд түгээмэл ажиглагддаг. Буурын гол, Буур хээрийн хөндий, Буурын хяр, Буурын толгой, Цагаан буур хайрхан, Ингэн толгой, Ботгон толгой, Ботгон шанд, Галбын говийн өмнөд хэсгээр Хавтгайн шанд, Хавтгайн хоолой, Хавтгайн хөв гэх зэргээр нэрлэх боломжтой байна. Үүнээс гадна “Монголын нууц товчоо”-нд “Буур хээр” хэмээх нэртэй газар [105, 109, 152-р зүйл] хэд хэдэн удаа тэмдэглэгддэг билээ.

Оршуулгын зан үйлээс гадна хуримын зан үйлд тэмээтэй холбогдох ёс бий гэдэг. Говь нутгийн малчин ардууд хүүдээ бэр гуйхдаа “тэмээний эрэлчин” хэмээн хэлдэг уламжлал бий. Энэ сайхан ёс заншлыг дэлгэрүүлж судлах нь зүйтэй юм.

Хуучнаар Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу буюу одоогийн Дундбаянгийн нутагт орших Дэчинлхүндэвийн овоог Говь мэргэн вангийн бүх овоонуудын “ах” нь гэж үзэн хамгийн түрүүнд тахидаг байжээ. Түүний зүүхэн хойно нь Гүнжлхамын овоо гэж байдаг аж. Гүнжлхам нь тэмээний бурхан бөгөөд хар нүдтэй цагаан тэмээ сэтэрлэж тахидаг байсан гэх аман мэдээ (А.Уранжаргал) байдаг.

<sup>31</sup> С.Жамбалдорж. Тэмээ тэнгэрийн амьтан. УБ., 2019. т.253.

<sup>32</sup> Б.Отгонбаатар. Монголчуудын оршуулгын зан үйл (XX зуун) / Хян. Г.Цэрэнханд.:УБ.,2009. т.68-69.

<sup>33</sup> Мөн тэнд. т.70.

<sup>34</sup> Энэ нутгийнхны дунд тус тусын учир шалтгааны үүднээс босгосон зарим овоотой байна. Тухайлбал, “Мааньтын хар толгойн овоо”-г “Жанцан мод” ямааны өвчин (годрон, хамуу) гарахад, “Салхитын овоо”-г тэмээний өвчин гарахад илааршуулах зорилгоор босгосон гэдэг.

## Гүнжилхам бурханы дүр дүрслэл, бэлгэдэл<sup>35</sup> (Тэмээний тэнгэр)

Гүнжилхамыг буддын шашинт улс орнууд өргөн дэлгэр шүтдэг. Түүнийг төвдөөр Гүнжи Лхам, санскритаар Хэманта Дэви, монголоор Өвлийн охин тэнгэр хэмээн нэрлэдэг. Гүнжилхам бурхан нь арван хангалын нэг, догшин сахиус Балданлхамын нөхөр, өвлийн улирлыг даасан боловч монголчууд түүнийг “Тэмээний тэнгэр” хэмээн шүтэх нь өргөн дэлгэр ажээ. Ялангуяа монголын говь нутгийн ардууд Гүнжилхам бурханыг тахих нь түгээмэл байдаг.



Өвлийн охин тэнгэр буюу Гүнжилхам бурхан хөх бараан өнгөт догшин дүртэй, гурван мэлмийтэй, ширэлдсэн улаан шар үстэй, хохимой толгойн титэм бүхий зургаан зүйлийн ясан чимэг зүүж, хар өнгөт хивнэг унжуулжээ. Тэрбээр баруун мутартаа шулмасын мод барин далайж, зүүндээ цуст гавал аяга барин саарал зүсмийн атан тэмээн дээр зүүн тийш харан хоёр хөлөө хумин заларч, цагаан галт хуй татуулан тэшүүлнэ.



Бэлгэдэл:  
Гурван мэлмий – Сансарын хамаг зовлонг тольдон болгоож, асран гэтэлгэх, өнгөрсөн, одоо, ирээдүйн аль ч цагийн зовлон бүгдийг төвөггүй харах увидас чадлыг бэлгэднэ.  
Хохимой титэм – Таван хорыг дарахын бэлгэдэл  
Атан тэмээ (хар буур М.А) – Азийн орнуудад тэмээ нь үлгэр домгийн амьтан бөгөөд Монголчууд тэмээг тэнгэрийн амьтан гэж үздэг  
Цус бялхсан гавал – Ядам бурхад зүүн мутартаа зүрхэн тус талдаа амьдралыг тэтгэхийг бэлгэдэн барьдаг

Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж байгаа Их хүрээний зураач Цагаан Жамбын бүтээсэн “Тэмээн сүрэг” гэх бүтээлийн төв дээд хэсэгт Өвлийн охин тэнгэр буюу

<sup>35</sup> The Fine Arts Zanabazar Museum (official address)

Гүнжилхамыг дүрсэлжээ. Уг бүтээлийн онцлог нь бурхан дүрслэлийн хэмжээ харьцааг баримталсан боловч зохиомжийн хувьд чөлөөтэйгээр байгальд тэмээн сүрэг хэсэг тахийн хамт байгаагаар дүрсэлсэн нь зураачийн монгол зурагт тэр дундаа хүрээний хэв маягийг гаргаж өгсөн нь онцлог юм.



Эрдэнэзуу музей дэх шүтээн зураг

Хөх өнгөт лагшинтай, нэг тэргүүн, гурван мэлмийтэй, догшин дүрт Өвлийн охин тэнгэр буюу Гүнжинлхам бурхан буур хөлөглөн, эрчлэн хуйларсан улаан гал, хуй салхи татуулан сүмбэр уул, цусан далайг гатлан явна. Баруун мутраараа шулмасыг дарах эрээн мод далайж, зүүн мутраа энгэртээ авч цустай гавал барьжээ. Зургийн зүүн дээд хэсэгт Янжинлхам бурхан, баруун талд Ловон Бадамжунай солонгон өнгөөр хүрээлсэн дугуй гэрлэн бие цацруулаэ бадам цэцгийн мандал дээр заларна.

Балданлхам бурханы дагуул дөрвөн улирлын охин тэнгэрийн Жиджи лхамо нь хаврын тэнгэр, Яржи лхамо нь зуны тэнгэр, Донжи лхамо нь намрын тэнгэр, Гүнжи лхамо нь өвлийн тэнгэр юм. Дэвсгэр хэсэгт сэтэрлэсэн буур, ботготой ингэ, тэмээн сүргийг дүрсэлжээ<sup>36</sup>.



Говь нутгийнхан тэмээн сүргээсээ аль нэгийг шилэн сонгож онгон дархан болгохыг сэтэрлэх гэнэ. Тэмээний хүзүүнд улаан даавуугаар бүрсэн хонины ноосон оёмол дээсээр хүзүүвч хийн аравнайлж улаан даавуунд шар будаа хийж оёод хадаг зүүж сэтэрлэх ёсыг гүйцэтгэдэг байна.

Мөн говьчууд тэмээ малаа жил бүрийн намрын дунд сард тахиж даллага авдаг уламжлалтай. Бүх тэмээгээ хурааж хотондоо цуглуулаад сэтэртэй тэмээг барьж бусдыг нь төлөөлүүлэн түүнийг гэрийн үүдэнд зогсоон толгойг нь тонгойлгож гэрт оруулж, арц хүжээр утан ариусгаад хадаг зүүж тавина. Үүний дараа арц хүж шингээсэн гурилан балин барьсан хоёр морьтой хүн хоттой малаа зөрөн тойрч нийт малыг ариулна. Энэ нь малаа онд мэнд оруулах, өсгөж үржүүлэхэд малчин хүний хүсэл сэтгэлийг шингээсэн дом, бэлгэдлийн зан үйл юм.

Тэмээг сэтэрлэх, даллага авахаас гадна түүний эд зүйлийг бэлэгшээн авч хэрэглэх тохиолдол бий. Зарим айлд түүний зогдорыг авч хадгалах, томж гэрийн чагтага үйлдэх эсхүл мод шонгийн үзүүрт бэхлэж чулуун овоон дээр босгох зан үйлийг хийх ёс бий. Энэ нь өөрийнхөө мал сүргийг өсөж үржихийг бэлгэдсэн утгатай байна. Гэрийн чагтага бол монголчуудын хамгийн хүндэтгэдэг зүйлийн нэг юм. Монголчууд өрх тусгаарлаж байгаа хүүхдүүддээ гэр төхөөрч өгөхдөө долоон буурын зогдор, өвдөгний ноосоор хүүхний талын эмэг эх нь шинэ гэрийн чагтагыг томж хийдэг байжээ (С.Жамбалдорж 2019: 129,201).

Монголчууд цагаан сарын шинийн нэгний өглөө гэрийн зүүн өмнөөс наран ургах чигт чулуун овоо босгож “Залам” нэртэй ёслолын жижиг мод байрлуулдаг. Залам модонд азарга, буур зэрэг эцэг малын дэл зогдор, хадаг уяж гурвантаа эргэн мөргөж ёсолдог. Тэгээд “буур ноцолдуулах” наадам хийдэг байжээ (С.Жамбалдорж 2019: 114).

Монголын ихэнх нутагт ургадаг “шүдэн цагаан” гэдэг цэцэг цэцэглэх үедээ цөөхөн хоногт хортой учир ялангуяа бог мал идсэнээс амархан хордож үхдэг. Уг өвчнөөс сэргийлэхийн тулд тэрхүү ургамлыг цэцэглэхээс нь өмнө өөр нутагт нүүх эсвэл эм домын засал хийдэг байна. Тухайлбал, хотон дотроо хаш чулуу, ятууны мах, тэмээний толгой булах юм уу мод босгож, үмхий хүрэн, тарвага, аргаль, зээрийн арьсаар хот орноо ариутгах зэрэг дом заслыг хийдэг байна (С.Жамбалдорж 2019: 210).

<sup>36</sup> Монголын бурхан шашны урлаг (Монголын музейн шилдэг бүтээлээс). Нэгдүгээр боть. Ред. Зара Флеминг, шастри Ж.Лхагвадэмчиг. Сериндиа., 2011. т.918.



Морь, тэмээ зэрэг амьтдыг эвшээхэд монголчууд ихэд бэлэгшээдэг. Тэмээ эвшээх нь тун ховор үзэгддэг ба хэрэв эвшээж байвал хүнд хишиг буянаа хайрлаж байна гэж үздэг аж.

Халимаг монголчууд далны ясны хамар буюу “маяа” гэж нэрлэдэг төвгөр ясны хажуугийн нарийн зурвасыг “тэмээн зам” хэмээн нэрлэж мэргэ тавьдаг. Тэмээний тарни, даллага ч гэж бий.

## Тэмээний даллага

Монголчуудын эртний уламжлалт зан үйлийн нэг нь тэмээний даллага юм. Ардын аман зохиолд тэмээний даллагын хэд хэдэн хувилбар байдаг ажээ.

А.

Цан шувуун ирэхүйд  
Цаст уул гэсэхүйд  
Цагаан ингэ ботголохүйд  
Цаглашгүй буян хишиг чинь  
Энд ирэн орштугай  
Өндөр их биет  
Бат урт нурууг  
Бадрангуй их луут  
Балттай их тав  
Бага их тэмээний  
Буян хишиг даллага авнам  
Хурай, хурай, хурай  
Богд Чингист ачлага болсон  
Бударга, баглуур идэшт  
Буйлдсан модон буйлт  
Бурантаг шижим сайт  
Хөхөлбөр олон тэмээний  
Буян хишиг нь иртүгэй  
Хурай, хурай, хурай  
Сүргийг олон болгогч  
Сүр жавхлант бүрдсэн  
Сүрхий их буурт  
Солби олон бөхт  
Ингэ ботголохүйд  
Сүүлт зээрний өвчүүгээр тахинам  
Сүрэг сүрэг тэмээний  
Буян хишиг иртүгэй  
Тансаг сайхан тэмээний  
Буян хишгийг хүсэж  
Таван өнгийн хивээр  
Сайтар ороон чимсэн  
Тас өдөт сумаа  
Гартаа барьж  
Тал дүүрэн тэмээний  
Буян хишгийг авнаа  
Хурай, хурай, хурай  
Хүсэх сэтгэлээр  
Даллан дуудна би

Б.

Хан ширээ бөхт

Хас эрдэнэ соёот  
Хаад ноёдын хөсөг болсон  
Хар тогмагийн тэмээний  
Буян хишиг энд ирэн орштугай  
Хурай, хурай, хурай  
Салаа мэт ширээ бөхт  
Саахуй тугам арвин их сүүт  
Шар шувуун өрөвдөг  
Шарагч ингэний  
Буян хишиг энд ирэн орштугай  
Арслан дүрт  
Айх мэт дуут  
Алдар их нэрт  
Атгар хар зогдорт буурны  
Буян хишиг энд ирэн орштугай  
Хурай, хурай, хурай  
Арван хоёр жил бүрдсэн  
Ар, өвөр улсад ачлага болсон  
Аян явдлаа гүйцээн чадагч  
Асар олон тэмээний  
Буян хишиг энд ирэн орштугай  
Монгол оронд заан болсон  
Муж бүхий улсад ачлага болсон  
Мундалгүй олон тэмээний  
Буян хишиг энд ирэн орштугай  
Хурай, хурай, хурай  
Тун эртнээс бүрдсэн  
Торгон гал голомт чамдаа  
Тос өөхөө дусааж  
Тунгалаг тахил өчгий чинь өргөн би  
Тус их өлзий хутаг  
Энд ирэн орштугай  
Хурай, хурай, хурай  
Бэлэг бэлгийн  
Буян хишиг хутгийг  
Баруун этгээдээс гуйнам  
Хурай, хурай, хурай  
Урт насны  
Хүү сангийн хутгийг  
Зүүн этгээдээс гуйнам  
Хурай, хурай, хурай  
Урт насны  
Сайн ерөөлийн хутгийг  
Умар этгээдээс гуйнам  
Хурай, хурай, хурай  
Өмнө этгээдийн

Далай таван хааны газраас  
Алт мөнгөн эд агуурсан  
Хутгийг гуйнам  
Хурай, хурай, хурай  
Өрнө этгээдийн  
Балбын газраас  
Хонины буян хишгийн  
Хутгийг гуйнам  
Хурай, хурай, хурай  
Түвд ерөөлийн газраас  
Үхрийн хутгийг гуйнам  
Хурай, хурай, хурай  
Эрдэнийн сант  
Бодисадын алган дахь  
Эрдэнэт хулганы амнаас буух  
Эрдэнийн сангийн буян хишиг  
Хутгийг гуйнам  
Хурай, хурай, хурай  
Сайн буян арвидан дэлгэртүгэй!

“Урьд монгол хүн үхвээс чинээ чинээгээр тэмээ, морийг алж хойлог хэмээн хамт булах бөлгөө” гэж Саган Сэцэний 1663 онд бичсэн “Эрдэнийн товч” хэмээх номонд өгүүлжээ. Иймээс эрт дээр нэгэн цагт монголчууд өөд болоочоо үдэхэд хойлгийн тэмээ оролцуулан гашуудал илэрхийлдэг ёсон байжээ (С.Жамбалдорж 2019: 238). Гэвч энэ мэдээг нягтлах нь зүйтэй.

Монголчууд тэмээг ихэрлэвэл их сайн гэдэг. Харин адууг ихэрлэвэл төдий л дуртай биш байх ба цэргийн уналга гарлаа гэж үздэг учиртай байжээ (Н.Намсрай, 1999: 41).

#### Тэмээ заслын судар

Нүүдлийн сонгодог мал аж ахуйг бүтээж ирсэн монголчуудын уламжлалт ардын мэдлэг ухаанд малыг анагаах, эмчлэх арга ухаан онцгой байр суурыг эзэлдэг билээ. Үүний нэгэн жишээ нь мал амьтныг гэмтэж, бэртсэн үед ханах, хатгах, утах, эмийн ургамлын эмчилгээний хандыг хэрэглэх зэрэг явдал юм. Тэмээ бусад малын адил өвчлөх нь элбэг. Халдварт ханиад, бэтэг, хачигтах, гууртах, хамуурах, амруутах гээд олон янзын өвчин тусах нь бий. Эдгээр тэмээнд туссан өвчнийг эдгээх үүднээс зохиогдсон уламжлалт мал эмнэлгийн нэлээн хэдэн судар төвд хэл дээр туурвигджээ. Цэвэлванчигдоржийн<sup>37</sup> “Сүрэг малчин дор тус хүргэж үйлдэхийн уг, тэтгэх аргууд” хэмээх таван жижиг судар байдаг аж. Түүний гурав дахь судар нь “Сүрэгчин тэргүүтэн дор тус хүргэж, үйлдэхийн уг, тэмээний тэтгэхийн аргын зэргээр тэмээний өвчнийг засах арга” хэмээх нэртэй байна. Уг сударт тэмээний 30 орчим өвчнийг нэрлэн, эдгээр аргыг заасан байдаг ажээ (С.Жамбалдорж: 215).

#### Есөн цагааны алба буюу бэлгийн тэмээд

1638 онд Түшээт хан Гомбо элч зарж, манжийн хаанд морь, тэмээ, булга, бүргэдийн өд, орос буу бэлэглэж байжээ. Манж хааны зарлигаар халхын гурван ханыг жил бүр цагаан

<sup>37</sup> Цэвэлванчигдорж нь XIX зууны эцэс XX зууны эхэн үеэр Арвайхээрт амьдарч байсан мэргэн оточ аж.

тэмээ нижгээд, цагаан морь наймаадыг бариулахтун хэмээн тушаажээ. Үүнийг есөн цагааны алба хэмээн үүрд хууль болгожээ. Мөн онд Цэцэн хан Шолойгоос морь, хуяг, дуулга, булга, бүргэдийн өд, орос буу, нум, зэр, эмээл хазаар, сүх, цагаан хэрмийн арьс, хар үнэгний арьс зэргийг бэлэглэж байжээ. Засагт хан Сувдайгаас морь, жич өрөөсөн зайдат тэмээ, сүүлгүй хонийг манж хаанд бэлэглэжээ. Дараагаар Түшээт ханы ойр төрлийн хүн Данзан лам бэлэг барьж байж. 19635 оноос 1691 он хүртэл халхын хаад, ноёдоос манжийн хаанд есөн цагааны бэлэг хүргэх явдал бараг үргэлжилсээр<sup>38</sup> байжээ.

Тэнгэрийн тэтгэсний 54 (1788) онд Түшээт хан аймгийн нэгэн хошууны тамгын газраас чуулганы дэд дарга Жун ванд мэдүүлсэн бичгийн дотор урьд богд эзний 60-70 сүүдрийн баярт аймгаас бурхан 80, цагаан морь 72, мөнгөн буйлтай тэмээ 9, булган молцог зэргийг барьсаар ирснийг цөм дансанд тэмдэглэжээ... 1831 онд Цэцэн хан аймгийн чуулганаар хэлэлцэж манж хаанд барих есөн цагаан морь нэг бүр 12 лан, цагаан атан тэмээ нэг бүр 30 лан, хүргэгчдийн уналга ачлагын тэмээ нэг бүрийн хөлс эр шүдлэн хонь 12, морины хөлс эр шүдлэн хонь 6-аар бодож үнэ хөлсийг тогтоож байжээ<sup>39</sup>.

1859 онд Жавзандамба хутагтын шанзав, манж хаанд бараалхахаар явахдаа хэрэглэсэн тэмээ 115, морь 42, уул морь, тэмээ замын зуур эцэж хүчин хүрэлцэхгүй болсон учир зөвхөн угтаж сэлбэх тэмээ 61, морь 31, хүнсний иргэн хонь 15, хар ажлын хүмүүс 10-ыг нийлүүлсэн байжээ<sup>40</sup>.

Манж хааны сүргийг халхын нутагт Дариганга гэдэг газар нутаглуулснаас Даригангын сүрэг гэж нэрлэжээ. Даригангын сүрэг нь 198 сууриас бүрэлдэнэ. Үүний дотор адуун сүрэг 74, тэмээн сүрэг 44, хонин сүрэг 80-аар тус тус бүрэлдэж, суурь тутамд 10-аад өрх байжээ. Даригангын сүрэг малын тооны талаар зарим нэгэн баримтыг дурдвал 1820 онд жуулчлан явсан оросын түшмэл Димикровскийн (Е.Ф.Тимковский болов уу М.А) тэмдэглэлээр тэмээ 20 мянга байжээ. Харин манжийн сүүлчийн үеийн албан баримтад өмнөд гарын адуу нэг түмэн мянга, умард гарын тэмээн сүрэг 2500, дунд гарын хонин сүрэг 88 мянга бүгд 101 мянга 500 толгой болохыг мэдэгджээ. Даригангын сүрэг бол манж хааны Мөнх сүрэг юм<sup>41</sup>.

---

<sup>38</sup> Ц.Насанбалжир. Ар монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911) / Ред. Х.Пэрлээ.- УБ.:ШУА-ийн хэвлэх үйлдвэр., 1964.-т. 10.

<sup>39</sup> Мөн тэнд.т. 14-15.

<sup>40</sup> Мөн тэнд. т. 17.

<sup>41</sup> Ц.Насанбалжир. Ар монголоос Манж Чин улсад залгуулж байсан алба (1691-1911) / Ред. Х.Пэрлээ.- УБ.:ШУА-ийн хэвлэх үйлдвэр., 1964.-т. 25.

## ХАВСРАЛТ БҮЛЭГ

Тэмээ хэмээх амьтан дуунд туссан байдал

Тэмээ хийгээд тэмээчний тухай олон янзын монгол дуунууд бий. Тухайлбал, “Улаан бууртай тэмээ”, “Говийн өндөр”, “Ширээ улаан тэмээ”, “Нарийн цагаан ботго”, “Өнчин цагаан ботго”, “Тэмээн сүргийн говь” зэрэг олон дууг нэрлэж болно. Үүнээс сонгон “Өнчин цагаан ботго” хэмээх түүхэн дууг доор сонгон орууллаа.

Өнчин цагаан ботго (түүхэн дуу)

Өнчин цагаан ботго  
Өлсөхдөө нэг буйлна  
Өл манхан ээжээ  
Санахдаа нэг буйлна  
Гуу дагуу хэвтэгч  
Гучин цагаан тэмээ  
Гучхан лангийн үнэтэй миний ээж хаачив!  
Та дагуу хэвтэгч  
Таван цагаан тэмээ  
Тавьхан лангийн үнэтэй  
Миний ээж хаана очив!  
Жалга дагуу хэвтэгч  
Жаран цагаан тэмээ  
Жархан лангийн үнэтэй  
Миний ээж хаана очив!  
Туул голын усыг  
Гаталсан гэж санасангүй  
Туг сэрээ (ширээ) бөхөө  
Сашилна гэж санасангүй  
Алтайн шилийн давааг  
Давна гэж санасангүй  
Ар шилийн зогдорыг  
Хайчилсан гэж санасангүй  
Өмнө хангайн давааг  
Давна гэж санасангүй  
Өмнө өвдгийн зогдорыг  
Хайчилсан гэж санасангүй<sup>42</sup> (Н.Намсрай: 1999: 81).

**Хэрэв тэмээ хайчилж байвал,**

“Өвдөг зогдор нь  
Өвс боггуа<sup>43</sup> цэвэр

<sup>42</sup> Хонгио багийн Осор овогтой Маньбазар 1973 онд бичүүлэв (Н.Намсрай).

<sup>43</sup> Борог өвсгүй гэсэн утгыг хэлж буй нутгийн аялга

Авах ноос нь  
Арвин ургах ноос нь ут<sup>44</sup> болог ээ!”<sup>45</sup> мөн  
Туг сайхан зогдор нь  
Сэрэлзээд байдаг  
Туулай сайхан уруул нь  
Шоволзоод байдаг  
Хүний чинаан? бөх нь  
Сэрэлзээд байдаг  
Хүрзийн чиниан? таваг нь  
Цайлзаад байдаг  
Хүнд хүлгин? ачиж эдэлдэг  
Хүчтэй сайхан тэмээ өсөх болтугай<sup>46</sup>.

### Буур шинжилж тавих ерөөл

Өндөр уул дээр нь  
Дээдсээсээ тахисан тахилгатай  
Өлкин эх бүр талд нь  
Өвгөдөө тавьсан газартаа  
Элэнцийн үеийн зуслан  
Өвгийн үеийн өвөлжөө  
Аавын буурь, ээжийн суурь  
Зэлээ татсан хавтгай  
Адуугаа манасан ар  
Хонио хариулсан өлкин  
Өлзийгөө өгсөн дэлхий  
Хавирга хайрласан нутаг  
Шимээ хайрласан бэлчээр  
Зүүн талын уул нь  
Зүр гураар баян  
Ар талын уул нь  
Аргаль угалзаар баян  
Өмнө талын уул нь  
Үхэр хониор баян  
Өнөр баян энэ нутгаа  
Өндөр газар нь гэрээ барьж  
Өргөн газар нь зэлээ татаж  
Баатар аавын буурьт бууж  
Баян ээжийнхээ суурьт сууж  
Зээгээ танихгүй өнөр болж  
Зэлээ танихгүй баян болж  
Айлын их нь болж  
Амьтны дээд нь болж

<sup>44</sup> Урт гэсэн утгыг зааж буй нутгийн аялгатай үг

<sup>45</sup> С.Баттулга. Өөлд ардын аман зохиол / Хян. Х.Сампилдэндэв.-УБ.:Бэмби сан., 2013.-т. 89.

<sup>46</sup> Мөн тэнд. т. 90.

Буур нь өлзийтэй болж  
Бие нь мөнх болтугай!<sup>47</sup>

Малын холбоотой ерөөлд:

Үр төл олонтой

Үржил шим сайтай хуц болоорой

Сүрэг нь дэлгэр болог

Сүмбэр уулын өвс ид

Сүн далайн ус уу

Түмэн хонины түрүү

Түнтгэр халзан хуц бол

Мянган хонины түрүү

Мантгар халзан хуц бол<sup>48</sup> хэмээн өгүүлж байгаагаас эцэг малд ямаршуу ач холбогдолтой хандаж ирсэнийг харж болохоор байна.

Монголд тэмээ, ингэ, ботгоны тухай магтаал ерөөл 30 шахам бий. Монголын ойрадуудын дунд өргөн тархсан энэхүү хуурын татлагыг ингэнд ботго авахуулахад аялгуулан хуурдаж дуулдаг байна. Үүнээс гадна туульч урин хайлуулах тохиолдол ч байжээ. Монгол тэмээний уралдаан эрт цагаас үүсч хөгжиж ирсэн түүхтэй. Морь цоллодогтой нэгэн адил тэмээг мөн цоллох нь бий.

Тэмээний уриа дуудлага: малчин хүн тэмээгээ “дуур дуур”, “тоор тоор” гэж дуурлаж, тоорлож дууддаг. Дундговь зэрэг аймагт тэмээгээ “хөөс хөөс”, “гүүр гүүр”, Ховдод “түүш түүш” гэх мэт дууддаг байна. Тэмээг үргэж, зугатах, догшироход “дуур дуур, хаа хөө” гэх мэт үг хэлж тайвшруулдаг (С.Жамбалдорж:197).

### Аман хууч, домог

Эрт урьд цагт нэг хүн гал түлдэг тулгаа тэмээний үдээрээр үдчихээд “За одоо ч ягшгалдай болсон шүү” гэсэн гэдэг. Тэмээний үдээр хэдий бөх боловч галд шатна гэдгийг бодохгүй байгаа тэр хүний жишээгээр аливаа ажлыг бодлогогүй хийх, тэнэг ажил хийх гэсэн утга санааг илэрхийлдэг байна (С.Жамбалдорж 2019: 265). Аливаа болж бүтэхгүй зүйлийг монголчууд хэлэхдээ “*Тэхийн эврийг тэнгэрт тулж, тэмээний сүүлийг газарт хүргэхийг хүлээхтэй адил*” гэж зүйрлэн ярилцдаг байна.

Буур унасан хүн босоо буудаггүй. Дээхнэ үед нэгэн хүн орсон бууранд хөөгдөж худагт оржээ. Гэтэл нөгөө буур нь худгийн амыг таглан дээр нь хэвтэхэд нөгөө хүн буурыг босгох санаатай дороос нь хутгаар гэдсийг зүсэхэд буур босолгүй байсаар хоёул тэндээ үхсэн эмгэнэлт явдал гарч байсан гэдэг (Х.Ивансан).

Говь нутгийн нэг зүйл аалзыг Цагаан тэмээ гэнэ. Энэ аалзны тухай говь нутагт айдас төрүүлэм элдвийн домог яриа байдаг. Цагаан тэмээ буйлахад шороон шуурга үүсэх бөгөөд

<sup>47</sup> Мөн тэнд. т.104.

<sup>48</sup> Х.Сампилдэндэв. Малчин ардын зан үйлийн уламжлал / Ред. Д.Дашдорж. УБ., 1985. т.54.



түүнийг уурлуулбал цус хурсан бие нь хагарч сэхэшгүй аюул учруулна гэдэг. Үнэхээр энэ аалз өвөрмөц сонин амьдралтай, хортой юм. Цагаан тэмээ нь орооныхоо үед хосоороо амьдрах боловч удалгүй эмэгчин нь хажиг зожиг болно. Аяганы амсарын дайтай цооног нүхэн үүр барьж 400 орчим өндөг төрүүлнэ. Хавар ичээнээс гарахдаа олон арван нялх аалзанцраа нуруундаа үүрч явдаг. Ардын эмнэлэгт түүнийг хорыг хэрэглэдэг байжээ (С.Жамбалдорж 2019: 247).

Ховд аймгийн нэгэн жинчний Мэлтгэр хүрэн гэдэг тэмээ ямар ч уулын өндрөөс сүр цохидоггүй тэмээ байсан гэнэ. Оросын нутагт байх алдарт Чуйн замын өндөр даваагаар давахад уулын өндрөөс сүр цохиж ачаатай тэмээ их осолддог тул бүх тэмээний нүдийг боож уул давуулахад ганц мэлтгэр хүрэнгийн нүдийг боодоггүй байсан хэмээн эзэн нь дурсан бичсэн байдаг (Х.Ивансан).

#### Орсон буурын тухай домог

Орсон бууртай тэмээнд чоно ч айгаад ойртдоггүй билээ. Үүнээс үүдэн чоно Орсон буурны дуу сонссоноос, Оготор шарын дуу сонссон нь дээр гэсэн домог яриа байдаг. Орсон бууранд морьтой хүн хөөгдөж бууранд бариулсан, суудлын машиныг шөргөөж өмнүүр хэрж хөндөлдөөд явуулахгүй байсан гээд баримттай болсон явдал, хууч яриа олон байдаг. Говийн нэгэн аймагт Жанжин хүрэн хэмээх буур ид орооныхоо үед өөр нэгэн бууртай тэмцэлдэн хүч тэнцээд бие, биеэ отож хөдлөхгүй хэвтсээр хоёул тэндээ үхсэн гэсэн домог яриа ч тэмдэглэгдэн үлджээ.

#### Сангийн дархан хар буурын домог

Хавтгайн буур эсвэл гэрийн тэмээний аль нь ч байсан тухайн тэмээнийхээ догшин зан араншингийн байдлаас шалтгаалаад нэрд гарсан буурын тухай аман домог, хууч яриа хийгээд болсон явдал цөөнгүй бий. Урьд Баатар хунтайжийн сангийн дархан хар буур гэгчийг тэмээчид хариулж эс ядаад Зүүнгарын Дэлдэнгийн говьд ингэтэй нь ялгаж хаясанаас замаар явж буй энгийн хүмүүсийг явуулахгүй хөөж гүйцээд алаад байсан тухай яриа гарч, түүнийг даруулахаар хүлэг баатараа илгээж буй<sup>49</sup> тухай нэгэн домог бий.

*“Яриг цагаан ингэний сариг цагаан ботго”*-ны тухай монгол ардын маш эртний уламжлалт домог байдаг ба энэ домог олон нийтэд ихээхэн түгсэн байна. Тэмээний талаар олон сонирхолтой баримт мэдээллүүдийг цуглуулж бүтээл туурвисан С.Жамбалдоржийн “Тэмээ тэнгэрийн амьтан” бүтээлд тэмээнд холбогдох зарим сонирхолтой аман хууч, домгууд байгаагаас доор сийрүүлбэл:

#### Тэмээ үнсэнд хөрвөөх болсон учир

Урьд бурхан Монгол хуанлийн арван хоёр жилд адгуусан амьтдын нэр өгч байхдаа арван нэгэн амьтны нэрсийг шууд оноогоод сүүлчийн буюу арван хоёр жилийн хамгийн эхний жилд ямар амьтны нэр өгөх вэ гэтэл тэмээ хулгана хоёр нэрээ оруулж арван хоёр жилд багтахаар булаалджээ. Бурхан аль алиныг гомдоохгүйн тулд өөрснөө шийд гэж айлджээ. Тэр хоёр маргааш өглөөний мандах нарны туяаг хэн түрүүлж үзсэн нь арван хоёр

<sup>49</sup> Ч.Мөнхөө. Баатар хунтайж / Эрх. На.Сүхбаатар.-УБ.:Соёмбо принтинг., 2015.-т. 138.

жилийн түрүүчид тохоогдохоор болж мэлзээ тогтоосон ажээ. Тэмээ нар гарах дорно зүг харж нар гарахыг хүлээж зогсов. Хулгана яаж ч хичээгээд тэмээнээс өндөр гарч чадахгүй тул авирч бөхөн дээр нь гарч харах гэтэл тэмээ зүүн зүг харахыг хориглов. Хулгана (тэмээний бөхөн дээр гарч аваад) баруун зүг харан цаг ямагт уулын орой ширтэж байв. Тэгж байтал нар гарах цаг болж ургах нарны анхны туяа баруун уулын оройд туссанд хулгана нарны гэрлийг түрүүлж үзлээ гэжээ. Тэмээ мэлзээсээ алдсандаа уурлан хулганыг дэвсэж алах гэж ухасхийгэл хулгана овоолоостой үнсэн доогуур гүйн орж амь хоргодож гэнэ. Тэр цагаас хойш тэмээ үнс асгасан газар харагдах бүрд өнөөх өстөн дайсан хулганыг бяц дарах санаатай үнсийг дэвсэлж хөрвөөдөг болсон гэнэ. (Ингээд хулгана арван хоёр жилд багтаж, тэмээ хасагдах болсон гэнэ. Тэмээ арван хоёр жилд багтаагүй боловч арван хоёр жилд багтсан бүх амьтны шинжийг цөмийг биедээ агуулсан байдаг гэнэ. Уг шинж нь: Хулгана чихтэй, үхэр гэдэстэй, бар тавагтай, туулай хамартай, луу биетэй, могой нүдтэй, морин дэлтэй, хонин ноостой, мичин бөхтэй, тахиа өрөвлөгтэй, нохой гуятай, гахай сүүлтэй гэнэ.

#### Зовлонт тэмээ амилж байна

... Говь нутагт ганц цагаан ботготой шарагч ингэтэй ядуу нэгэн ард байжээ. Тэгтэл манжийн хааны төрсөн өдөр есөн есөн наян нэгэн цагаан тэмээний бэлэг өргөх болж ганц цагаан тэмээ дутжээ. Энэ үед ноён нь ядуу айлын цагаан ботгыг хүчээр булаан авчээ. Гэвч шар ингэ хойноос нь нэхэн очиход ингийг алж ботгыг нь булаан явжээ. Ботгоо санасан ингэ алагдсан боловч цоролзсон хуй салхи болон хувирч ботгондоо эргэж ирдэг болсон хэмээх домогтой ажээ. Иймээс говь нутагт “босоо эргүүлэг” нэртэй хуй салхийг “Зовлонт тэмээ амилж байна” гэж ярьдаг болжээ (С.Жамбалдорж 2019: 145).

#### Тэмээ унасан чоно

Эрт урьд цагт говь нутагт тэмээ унасан чоно байсан тухай домог бий. Анчны хавханд орж урьд, хойт хоёр хөлөө хугалсан өлөгчин чонотой нэг азарган чоно байжээ. Тэр чоно нэгэн нинжин сэтгэлт тэмээг өөртөө дасгажээ. Тэгээд дөрвөн мөчгүй өлөгчин чонын дэргэд тэмээ хэвтэхэд азарган чоно дэмнэн өлөгчин чоноо тэмээний хоёр бөхний хооронд гаргаж унуулаад, бурантгаас нь хөтлөн явж ус уулгадаг байжээ. Үүнийг танадаж мэдсэн нэгэн анчин тэднийг ус уухаар ирэхэд нь азарган чоныг буудан алжээ. Гэтэл өрөвчхөн сэтгэлт тэмээ гэнэт улангасан догширч таваргасаар ирээд анчны дэргэд бөөн бөөн нулимс асгаруулан хамаг бие нь чичирч зогссон гэнэ. Элэг эмтрэм ийм явдлыг үзсэн анчин дөрвөн мөчгүй өлөгчин чоныг өрөвдөхийн эрхэнд алаад түүнээс хойш ан хөөж амьтанд нүгэл үйлдэхгүй хэмээн цахиур буугаа уулан дээр тавьжээ гэсэн домогтой гэнэ (Л.Ширчин 1990).

#### Хар ат буюу хараат хайрхан уулын домог

Бөмбөгөр сумын хойд талд эргэж хараад зогссон тэмээтэй төстэй сүрлэг уул байдаг. Энэхүү уулыг урьд Хар буур гэж нэрлэдэг байжээ. Гэтэл нутгийн нэг омогтой эр ботго чононд идүүлчихлээ хэмээн уг уулыг засаж байгаа юм хэмээн хойд талаас нь сойр бөөрөнхий чулуу хаяад хар ат гэж нэрлэсэн гэдэг. Энэ нэр нь сунжирсаар “Хараат хайрхан” нэртэй болсон учиртай. Өөр нэгэн хувилбарт энэхүү уулыг эх нутгаа манж хятадын цэргээс хамгаалж буй хүчирхэг хар буурын шинжтэй эх оронч уул гэж нэрлэсэн байх ба Дашдоо гүний үед энэ хошуу үнэхээр ч олон тэмээтэй байжээ.



### Тэмээний нэрээр нэрлэгдсэн тоглоом<sup>50</sup>

*Буур хаших* – говийн хүүхдүүд тоглодог энэ тоглоомд нэг хүүхдийг буур, нөгөөг ингэ гэж нэрлээд бусад хүүхдүүд гар гараасаа барилцан тойрог хашаа болно. Буур хашааны гадна, ингэ дотор талд нь байна. Буур гар гараасаа барилцсан хүүхдийн тойргийг нэвтрэн, ингийг барихаар тэмүүлнэ. Буур хүүхдүүдийн атгалцсан гарыг салгахгүй, дээгүүр нь үсэрч, эсвэл доогуур нь шургаж орно. Буур хаагуур орох гэнэ, тэр зүгт хашааны хүүхдүүд бие биедээ ханаран наалдаж, зай завсар гаргахгүйгээр ингийг хамгаална. Буур хашааны дотор талд нэвтрэхэд хүүхдүүдэд шаламгайлан хөдөлж, шинэ хашаа үүсгэн ингийг хүрээлэн зогсоно. Тэгж амжаагүй бол буур, ингийг барьсанд тооцно. Буур болсон хүүхэд буурын алхаа, гишгээ, хөдөлгөөнийг дууриан гүйнэ. Баригдсан ингэ (хүүхэд) нь буур болж тоглоом үргэлжилнэ (Ц.Түвшинтөгс<sup>51</sup> 2007: 27).

*Тэмээн таваг* – эртний монголчуудын хөлөгт тоглоомын нэг бол “тэмээн таваг” юм. Уг тоглоомын хөлөг нь тэмээний тавагтай адил бөгөөд нэг худагтай, таван буудал байна. Хоёр хүүхэд, хоёр хүүгээр тоглоно. Хүүг шулуун ба муруй зураасны дагуу нүүдэг. Тоглогчдын нэг нь хоёр харыг, нөгөө нь хоёр цагааныг авч, цагаан хүү авсан хүн эхэлж нүүгээд нэгийгээ нүүдэлгүй болгон хожилцоно (С.Жамбалдорж 2019: 208).

*Тэмээ сөгдүүлэх* – Энэ тоглоомоор 2-оос дээш хүн тоглоно. Тоглоом эхлэхээс өмнө хэдэн шагайгаар тоглохоо хэлэлцэнэ. Гурван хүн тоглоно гэж үзвэл тус бүр 10 шагайгаар нийлж, бүгд 30 шагай болгон эхний хүн орхино. Гэтэл 5 хонь, 3 тэмээ буужээ гэж үзвэл 5 хонио түүж аваад, 3 тэмээнийхээ 1-ийг эхлээд 1 хониор няслахад тэмээ нь ямаа, морь хонь болгон өөрчлөгдөж, нясалсан шагай нь хонь хэвээрээ буувал “тэмээ сөгдлөө” гэнэ. Нэгэнт тэмээ сөгдүүлсэн учраас 2 шагайг авна. Нясалсан шагай нь хониноос өөр буувал нясалсан хүн авахгүй, үлдсэн 2 тэмээнийхээ 1-ийг няслах эрхтэй болж, үргэлжлүүлэн нясална. Хэрэв хонь буухгүй бол гартаа байгаа түрүүчийн хонь болж авсан шагайнаас нийлүүлж, дараачийн хүн

<sup>50</sup> Ер нь шагайн тоглоомуудын ихэнх нь ямар нэгэн байдлаар тэмээтэй холбогддог.

<sup>51</sup> Ц.Түвшинтөгс. Цагаан тэмээцэх / Хян. О.Мөнхтуяа.-УБ.:Интерпресс ХХК., 2007.

орхих жишээгээр тоглоом үргэлжилнэ. Хониороо тэмээг нясалж сөгдүүлж чадахгүй хэвээр нь байлгавал өөрийн авсан шагайнаасаа төлбөр болгож, нэг шагайг орхих шагайтай нийлүүлэх ба тэмээг сөгдүүлэхээр нясалсан шагай нь тэмээ болж буувал бас нэг шагайг төлбөрт өгнө. Хэрэв тэмээг сөгдүүлэхээр няслахад онохгүй, нясалсан хонь нь тэмээ болж буувал 2 шагайг төлбөр болгож өгнө. Тэмээг сөгдүүлэх шагайгүй бол дараа нөхөж өгөхөөр өртэй үлдэнэ. Хэн олон тэмээг сөгдүүлж олон хонь болгон олон шагай авсан, хонио буцааж тавилгүй тоглож бүх шагайг авсан нь хожно (Ц.Түвшинтөгс 2007: 20).

*Тэмээ уях* – Энэ тоглоомоор хэдэн ч хүн тоглож болно. Тоглоомын гол зорилго нь аль болохоор олон хонь, цөөн тэмээ буулгахад чиглэнэ. Тоглогчдын хамгийн ах нь бүх шагайг гартаа аваад тараан хаяна. Тэгээд хонь буусан бүх шагайг түүж авах ба харин тэмээнүүдийг тэр хониороо цохиж хонь болгон унагахыг хичээнэ. Хэрэв тэмээ босохгүй байвал зөвхөн хоньдыг түүж авна. Морь, ямаа буух нь энэ тоглоомын хожилд нөлөөлөхгүй. Хонь байхгүй дандаа тэмээ босвол түрүүчийн авсан хониороо тэмээг цохиж унагах ба хонь болсон шагай нь хүрэлцэхгүй бол илүү гарсан “тэмээг уяна”. Өөрөөр хэлбэл, хоньтой болсон цагт уясан тэмээг цохино. Тоглоомын эцэст, хэн тэмээ уяагүй, олон хонь авсан нь хожно. Тоглолтын явцад хаясан шагай нь цөм ижил буувал тоглогчид булаалдан, хэн олон шагай авсан нь тоглоом эхлүүлнэ (Ц.Түвшинтөгс 2007: 21).

*Төгс хаях* – Энэ тоглоомоор 2-4 хүн хэдэн ч шагайгаар тоглож болно. Хэдэн шагайгаар тоглохыг өөрсдөө тохирдог. Хоёр хүн 20 шагайгаар тоглоно гэвэл бүх шагайгаа орхино. Гол зорилго нь аль болох олон морь, аль болох цөөн тэмээ буулгахыг хичээнэ. Хонь ямаа буувал хожилд хамаарахгүй. Тэгэхдээ тэмээний тоогоор морь өгч торгууль хүлээдэг. Хэн урьтаж 10 морь авсан нь хождог (Ц.Түвшинтөгс 2007: 25).

*Цагаан тэмээлцэх* – Тоглогчид буур, ингэ, ботго болно. Тоглоомд ихэвчлэн 10-14 хүүхэд оролцоно. Тоглоомд 1 буур тусдаа гарах ба нэг ингэнээс бусад нь цувран, ботго болж бие биеэсээ барина. Буур ингэнээс “Цагаан тэмээ ноос өгөөч” гэж гуйна. Ингэ бууранд үйл хөдөлгөөнөөр ноосноосоо авч өгөөд явуулна. Буур дахин ирж ноос гуйна.

Буур: Цагаан тэмээ ноос өгөөч?

Ингэ: Одоо ноос байхгүй

Буур: Чи ноосоо яаж орхив?

Ингэ: Ноосоороо ширмэл ширдэг ширээд ширээ бөхөндөө угласан.

Буур: Тэгвэл чиний отгон ботгыг авна даа гэж хэлээд хамгийн сүүлчийн ботго руу дайрна. Энэ үед нөгөө ингэ буураас ботгоо хамгаалан зайлуулахыг эрмэлзэн, хоёр гараа алдлан буурын хөдөлгөөнийг дагуулан сарвайлгаж займчихад, түүний аясаар ботгонууд даган займчина. Буур, отгон (сүүлчийн) ботгонд гар хүрмэгц ботго баригдсанд тооцогдоно. Отгон ботгыг барьсны дараагаар буур аль ч ботгыг барих эрхтэй болно. Ингэ хурдан шалмаг хөдөлж ботгоо харамлах ба ботгонууд хоорондоо тасрахгүйгээр займчиж зугатаана. Буур олон ботго баривал хожно. Олон ботго болон бусад ботгоо өгөлгүйгээр буурын дайралтыг олон удаа буцааж чадвал ингэ нь хожно. Буур хэдэн удаа дайрч ботго барихыг завдахаа тоглоомын эхэнд хэлэлцэж тогтоно (Ц.Түвшинтөгс 2007: 24).

## **Тэмээтэй холбоотой нэрээр нэрлэгдсэн зарим газар**

*Тэмээн чулууны ам* - Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт “Тэмээн чулууны ам” нэртэй газар бий. Тэнд археологийн түүхэн дурсгалууд нэлээд бий бөгөөд археологич Д.Наваан тэдгээрийг судлан бүртгэлжүүлжээ.

*Тэмээн чулуу* - Өнөөгийн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт, сумын төвөөс урагш 3-5 км орчим зайд “Тэмээн чулуу” нэртэй нэгэн газар байна.

*Тэмээн шавар* - Өмнөговь аймгийн Булган сумын нутагт орших “Баянзаг”-т тийм нэртэй газар байна. Алсаас харахад тэмээ шиг хэлбэртэй учир тийн нэрийдэгджээ.

*Тэмээн тавхай* - Баянхонгор аймгийн Өлзийт сумын нутагт Зүүн уушиг гэдэг газрын нэгэн өндөр цохионы орой дээр жижиг гэрийн буурийн хэртэй тэмээн тавхайн мөр байдаг. Цохионы орой тэгш, хавтгай гадаргуутай учраас нойтон шавар дээр тэмээ ганц гишгээд өнгөрсөн мэт хоёр алтан хумсны ор тод харагдана (С.Жамбалдорж 2019: 208).

*Тэмээн хээр* - Монголын нууц товчоон гардаг газрын нэр.

*Буурын ам*: Өнөөгийн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт, сумын төвөөс хойш 20 орчим км-т бий.

*Буур уул (Буурын хяр?)* - Өмнөговь аймгийн Номгон, Хүрмэн, Ханхонгор сумдын зааг нутагт орших уул. Өндөр нь далайн төвшнөөс дээш 2096 метр өндөр.

### **Тэмээний нэрээр нэрлэгдсэн амьтан, ургамал**

*Тэмээн сүүл* – харганын төрөлд багтдаг, сөөг ургамал, ойн бүсээс дээш уулын оройд ургана. Мал төдий л иддэггүй.

*Тэмээн таваг* – Ихэвчлэн өндөр ууланд ургадаг хөхөмдөг өнгөтэй өвс. Хасгаар сартваань гэдэг. Тэр ургамлыг адуу дуртай иддэг. Ялангуяа унагалах гүү бүр ч дуртай иддэг.

*Тэмээн хавирга* – Иш эгц босоо, 30-40 см өндөр, навчгүй юм уу үндэс орчмын нэг навчтай өндөр уулын ургамал. Мөн талын тэмээн хавирга гэж ургамал бий. Асга хад, хөвд хаг бүхий газар ургана. Улаанбаатар орчмын ууланд тохиолдоно (С.Жамбалдорж 2019: 211).

*Тэмээн харгана* – 1.5-2 м өндөр, салаалсан мөчиртэй, шар ногоон хальстай, хос хосоор ургадаг, өдлөг навчтай, сөөгөрхөг ургамал.

*Тэмээн хоолой* – Иш өндөр болоод хонгилтой ургамал. Навчиндаа сондуутай уг ургамлыг боловсруулж хоолондоо иднэ (Монгол толь).

*Тэмээн хэл* – 20-30 см өндөр олон наст ургамал, том бөгөөд уртавтар гонзгой, навчтай, цэцгийн өнгө нь тунгалаг ягаан, бас шар өнгөтэй ч бий (Монгол толь).

*Тэмээлзгэнэ* – Хүзүү бие урт, хэвэл их, жигүүртэй, бусад хорхойг барьж иддэг шавьж. Энэ амьтныг бас *тэмээлзгэнэ царцаахай*, *тэмээлзгэн хорхой* гэж нэрлэх нь ч бий (Монгол толь).

*Тэмээн аалз* – Талын цагаан тэмээн аалз гэх нь ч бий. Энэ амьтан маш хортой амьтан ба хүн хазуулсны дараа шууд толгой эргэх эсвэл ухаан алдаж унах нь ч бий гэнэ.

*Тэмээн гөрөөс* – Хоёр бөхт зэрлэг тэмээ буюу хавтгайг монголчууд бас тэмээн гөрөөс хэмээн нэрлэх нь ч бий.

*Тэмээн хараацай* – Биеийн урт нь 22 см орчим, өдний хэмжээ 25 см орчим урт, хортон шавьж иддэг шувуу (Монгол толь).

### Д.Цэвэгмидийн “Тэмээн гөрөөс”<sup>52</sup> тэмдэглэлийн хэсгээс

1943 оны зун цаг Атас уул, Ээж хайрхан хоёрын хооронд Отгоны хоолойд нэг өдөр хоёр дахин, эхлээд зургаа, дараа нь есөн хавтгайтай дайралдсан боловч, гэрийн тэмээнээс онц ялгагдах шинж тэмдгээр бага байсан учир анхандаа хавтгай мөн эсэхийг танин ядан, харилцан маргалдсаар зугтуулсан билээ. 8 дугаар сарын дунд үе жин үдийн халууны цаг, элсэрхэг зөөлөн хөрстэй барагдашгүй урт хөндийг уруудан, цохио орсон мотортой ачааны хүнд машинаар арайхан гэж зүтгүүлж явтал, хоёр зуугаад метрийн цаана загийн бутнуудын завсарт нэг том хүрэн улаан тэмээ биднийг ширтэн зогсож байв. Бас түүний дэргэд таван тэмээ бөөгнөрөн хэвтэх нь харагдана...

Өнгө, зүс, биеийн хэмжээ нь гэрийн тэмээнээс ялгах зүйлгүй. Гэтэл гэнэт цаашаагаа хуйлран эргэж, жонжин тэшээр яах ийхийн зав чөлөө өгөлгүй далд орон явчив. Хойноос нь гүйж, өндөрлөг дээрээс гарч харвал, тэртээ алсын гүвээ өөд цувран гарч байх нь үзэгдэв. Ингэж зугатаахыг үзвэл хавтгай байсан нь зайлшгүй гэж бодогдон ул мөр, хэвтэш зэргийг ажиглан үзээд, цааш аяны замдаа оров...

Зэрлэг амьтан нэг өнгөтэй байдаг атлаа, эдгээрийн зүс нь олон янз. Хамгийн томоохон нь хар бараан, олонх нь улаан хүрэн, хоёр нь цайвар байхыг үзэхдээ хавтгай мөн эсэхэд эргэлзэн гайхсан билээ.

Маргааш нь Алтайн нурууны өвөр бэлийн Захуй голын Улаан доvon гэдэг газраа хүрэлцэн ирж, нутгийн айлуудаас урьд өдөр Отгоны хоолойд үзсэн тэмээний тухай асуухад “Хавтгай мөн, тэр хөндийд айлын тэмээ хүрэх ёсгүй” гэв.

Ийнхүү 16 жилийн өмнө Отгоны хоолойд үзсэн хавтгайтай зэрэгцүүлбэл саяхь хоёр хавтгайн биеийн төрх байдал, өнгө зүс, зан ааш нь үнэхээр зэрлэг амьтны шинжтэй байв. Наран Сэвстэйгээс баруун хойт зүг эргэж Талын мэлтэс, Хонгор Сухайтын булаг, Гучин Нарин ба Мянган Тооройн худаг, Цэнхэр Номины говиор дайран, Аж Богд хүртэл явах замдаа хэд хэдэн удаа хавтгайтай дайралдаж нэгийг олзлов. Энэ удаа ажиглагдсан хавтгайнууд гэрийн тэмээнээс эрс ялгавартай. Элсэн шаргал хуа өнгөтэй, үс нь тачир, зогдор нь богино, бөх нь жижиг, хөл нь нарийн урт, тавхай нь бага, хүчирхэг хурц хумстай, маш соргог, биеийн ерөнхий төрх нь хээрийн зэрлэг амьтны шинж бүрэн байв.

Гэтэл тэр жил Отгоны хоолойд үзэгдсэн хавтгайнууд болон удаа дараа Эдрэнгийн нурууны өмнө бэлээс олзлогдсон зарим хавтгай гэрийн тэмээтэй бараг ижлээр ажиглагддаг нь сонирхолтой юм.

Алтайн цаадах говийн хойт захаар айлд ойролцоо орших хавтгай, гэрийн тэмээтэй нийлдэг удаа буйг нутгийн ардуудаас олж сонсов. Говь-Алтай аймгийн Бигэр сумын дарга Чулуун, хавтгайн бууранд хураагдан хөөгдөж, алдуул болсон айлын хориод тэмээг эрж

<sup>52</sup> Д.Цэвэгмид. Алтайн цаадах говьд. УБ., 1987.

яваад, Цэнхэр Номины говьд хавтгай олныг үзсэн тухай болон айлын таван ингэн тэмээ алдагдаад, эрэл сурал болж, бүтэн жил өнгөрсний дараа нэгэн хавар цас хайлах үеэр нутагтаа эргэж ирэхэд, тэд нарыг хавтгайн буур дагаж явсан бөгөөд, гэрийн бараа үзмэгц буцаж зугатаасан, тэгээд мөнхүү ингэн тэмээдээс эрлийз ботго гарсан нь ороо догшин ааштай байсныг яриу.

Хавтгайн буур гэрийн тэмээнд гүйж ирдэг тухай 1943 онд Өмнөговь аймгийн Ноён Богд сумын хашир малчдаас сонссон билээ. Үүнээс үзвэл, Алтайн цаадах говийн хавтгай гэдэг тэмээн гөрөөсний сүрэгт гэрийн тэмээтэй цус холилдсон бодгаль байдаг нь дамжиггүй юм.

Цаг улирлын байдлаас тэмээн гөрөөсний нутагшил өөрчлөгдөх бөгөөд зун намрын цагт шар мод, багалуур, харгана, хойрог, цагаан өвс, хөмөл, таана, хонхорцог, хавьсгана, хулангийн унд, заг мод зэрэг баялаг ургамал бүхий сайр, хоолой, намхан гүвээ толгодоор, өвөл, хаврын цагт зээргэнэ, заг, бударгана зэрэг бут сөөг голлон ургасан бэлчээрт оршино. Үүнчлэн зун, намрын цагт багалуур, хөмөл, цагаан өвс, хавьсгана, хойрог, шар мод, загийн навч, өвөл хаврын цагт тооройн навч, зээргэнэ, шар мод, загийн мөчир, дэрс, говийн хялгана зэрэг нь тэмээн гөрөөсний тэжээлийн гол ургамлууд болно.

Тэмээн гөрөөсний өдөр шөнийн амьдрал, идэвхтэй цаг үеийг тогтоох явдал амьтан судлалд сонирхолтой боловч, энэ талаар бидний мэдлэг хомсхон байна. Өвлийн цагт өдөржин бэлчээрлэж, шөнө нь нөмөр дулаан газраа хэвтэж хонодог бололтой. Харин зуны цагт өглөө, оройн сэрүүнээр идээшилж, үдийн халуун болоход хараа сайтай газрыг сонгон амарч хэвтэх ба энэ үед сүргийн дотроос нэг нь, голдуу буур нь манаанд гарч, орчин тойрныг сонор соргоогоор ажиглан зогсоно...

Бидний ажигласнаар, Алтайн цаадах говьд орших тэмээн гөрөөс нь биеийн гадаад төрх, зан ааш, өнгө зүсээрээ гэрийн тэмээнээс ялгавартай. Гэхдээ энэ ялгавар нь зарим сүрэгт ихээхэн, заримд нь багаар ажиглагддагаас үзвэл, анхны зэрлэг тэмээдийн зэрэгцээгээр айлын сүргээс алдагдаж зэрлэгшсэн хэсэг, гэрийн ба зэрлэг тэмээ хоёроос гарсан дундын хэсгүүд холилдон оршиж байдаг бололтой.

*Хайдавын Ишцэн. Баянхонгор аймгийн Баянлиг сумын харьяат. 74н, эр, өвгөн жигжид овогтой.*

Та эхлээд өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?

Би Баянхонгор аймгийн Баянлиг суманд насаараа тэмээ маллаж байгаа *Зах хавиар нутагтай, заг голдуу түлээтэй* Ишцэн гэдэг хүн байна.

Та хэний Ишцэн бэ?

Хайдавын Ишцэн.

Та одоо нас сүүдэр хэд хүрч байна вэ?

Одоо 74 настай. Би бол 1949 оны хүн.

Таны ургийн овог юу вэ?

Өвгөн Жигжид.

Энэ ямар учиртай овог вэ?

Энэ бол миний буурал аавын аавын нэр байгаа юм. Насаараа л мал маллаж байсан. 1800-аад оны дундуур бурхандаа явсан хүн юм билээ.

Та одоо амьдарч байгаа газраа тодорхой хэлнэ үү?

Баянхонгор аймгийн Баянлиг сумын хөдөө “Бага баян” буюу 3 дугаар багийн нутаг “Цагаан толгой” гэдэг газар өвөлжиж байна.

Та одоо голчлон ямар мал маллаж байна вэ?

Ерөөсөө тэмээтэй л насыг барж байгаа хүн. Нэг хэсэг бог малтай байсан. Хэсэг тэмээ, ямаа хоёртой л байлаа.

Тэмээ, ямаа хоёрыг хослуулж маллахад хэр тохиромжтой байдаг вэ? Бэлчээр нь тохирдог уу?

Тохирно оо. Говь бол ер нь тэмээ, ямаа хоёрын л нутаг. Түүнээс хангайд байдаг ямаа бол говьд нутагшихгүй л байх. Яг нутагтаа өсчихсөн тэмээ, ямаа хоёрт бол нутаг нь таардаг юм. Тэмээ гэдэг амьтанг бол ямаа шиг ээ хариулдаг цаг ч бий. Гэхдээ голцуухан алсын бэлчээрт л явж байдаг амьтан. Усандаа ирнэ гэж байдаг. Алсын хяналт тавигддаг амьтан. Бүл чадалтай айл бол тэмээ, ямаагаа зэрэгцүүлээ л маллалчихдаг.

Танайх одоо хэдэн тэмээтэй вэ?

Одоо 150, 160 орчим тэмээ л байна. Манай хүү маллаж байна. Төллөх хугацаа нь арай л болоогүй байна. Алсын хяналтаар эргэж тойрч байна. Өөрийнх нь төллөх хугацаа нь болоод дөхчихвөл төрөх ингээ ялгаж авч байгаад ойртуулж ирээд төллүүлдэг. Гэхдээ зарим тэмээ бол арай эрт төллөх, цагаан сараар гарах нь бий. Тэрийг бол насаараа тэмээ маллаж ирсэн улсууд учраас малчид бид нар сайн мэддэг, ойртуулж ирж байгаад авдаг. Одоо манай энд ботго гарчихсан л дуулдаж байна.

Та яагаад тэмээ өсгөх болсон бэ?

Ерөөсөө л миний ээж, аав намайг энэ алтан дэлхийд мэндлэхэд л тэмээ, ямаатай байсан. Тэгээ л нэгдэл бог малыг нь авсан. Дундуур нь цэрэгт би 3 жил болсон. Тэгээ л тэмээн дээрээ эргэж ирсэн. Удам залгасан л тэмээчин хүн.

.....хулуу болтлоо тэмээтэй цуг байсан хүн 06:56 /нөхөх/

Таны тэмээнүүд дунд онцгойлж хайрладаг тэмээ бас байдаг байх даа?



Байлгүй яхав. Тийм атан тэмээнүүд бий. Наадамд сойж унадаг, гоё ганган, том сайхан тэмээнүүдээ бол нандигнадаг.

Танд ямар нэртэй тэмээнүүд байдаг вэ?

Нэг байнга уралддаг цагаан тэмээ бий. “Хонин цагаан” л гэдэг юм. Заримдаа уралдаанд айрагдаж л байдаг. Би бас ойр орчимд унадаг “Өндөр улаан” гэж том улаан ат бий. “Өндөр хүрэнгийн ногоон”, “Том халтарын бор”, “Өндөр халтарын бор” гэх зэрэг тэмээнүүд бий.

Та хавтгай тэмээний талаар хэр мэдэх вэ?

Хавтгай тэмээнүүд говьд бий. Нийлээд, салаад л байж байдаг юм. Хааяа монгол тэмээнд орж ирж хэрэг тарих нь бий. Хавтгай тэмээтэй ойр тойрон хамт нутаглаж явсан үе бий. Хавтгай тэмээ хааяа манайханд орж ирдэг. Ялангуяа өвөл буурын орооны үед тэмээнд орж ирж ингэ, ботго салгаж хөөх, туух юм зөндөө гардаг.

Хавтгай танд ер нь ямар онцлогтой амьтан шиг санагдсан бэ?

Хөгшчүүд лусын амьтан гэж ярьдаг байсан. Тэмээ тэнгэрийн амьтан гэж хэлдэгтэй ялгаа байхгүй. Дээр үед зэрлэг амьтанг нухаж хоол хүнсэнд хэрэглэдэг байх үедээ зарим нь амлаж, мөргөж байж бууддаг байсан юм гэнэ билээ. За танаас одоо ийм тийм юм гуйлаа гэж ном, тарни уншиж байгаад тэгээд дараа нь цахиур буугаар буудаж авдаг байсан юм гэсэн. Баянхонгорын Шинэжинстийн говь, Баян-Өндөрийн говь, Эдрэнгийн нуруу гээд тэдгээр газруудаар байдаг. Манай руу бол зах зайдуухан хааяа нэг ганц хоёр, хоёр гурваараа шахуу ирчихээд л явдаг. Заримдаа манайхны ингэн тэмээнүүдтэй эрлийзэждэг. Саяхан хэдэн жилийн өмнөхөн нэг хавтгайн буур орж ирж манай сүрэгт нэлээн хэдэн эрлийз тарьчихаад явсан.

Яг хэдий үеэр вэ?

За даа 2000 он гарах үеэр шиг. 2006, 2007 оны үед юм уу даа. Нэлээн хэдэн ингэ тарьчихаад явсан. Тэр үеийн л эрлийзүүдийн үрээр манайхан их уралдаж байна шүү дээ. Их догшин ааш муутай хэрнээ хурдан амьтан байдаг.

Танайхыг хаагуур нутаглаж байхад тэр буур ирсэн бэ?

Одоо нутаглаж байгаа “Цагаан толгой”-д. Энд манайх 1993 оноос хойш л нутаглаж байна.

Тэр хаанаас ирсэн хавтгай байсан юм бол?

Баян-Өндөрийн говиос ирсэн хавтгай. Алтайн салбар уулсууд гэж ярьдаг, Нэмэгт, Их, бага Баян богд гэдэг ч юм уу энэ уулсууд нь тууш тууш хонгил үүсгэсэн байдаг. Тэр хонгилуудын нэг нь Өмнөговьор Хятадын хилрүү ордог. Тэгээд түүнтэй Шинэжинстийн, Баян-Өндөрийн говь харалдаа оршдог. Түүгээрээ явж байгаад тэмээ малтай нийлдэг.

Тэмээ бол салхиддаг амьтан, салхи хөөж явдаг. Говьд халуу шатахаар сэрүүн салхируу цувдаг. Салхи сөрж явдаг амьтан гэсэн үг. Тухайлбал, зүүнээсээ салхилбал салхиа дагаж сөрөөд зүүн тийшээгээ ороод ирнэ гэсэн үг. Тийм байдлаар ганц нэг нь үлдээд тэмээ мал руу орж, гарч эрлийзжүүлэх нь бий. Тэр эрлийзээс гарсан ботго нь манай гарын тэмээнүүдийг бодвол их ааш муутай, догшин. Эдэлж, хэрэглэхэд нэлээд чадал ордог. Ер нь л их эвгүй.

Танайд тийм бэсрэг тэмээ олон уу?

Бий бий.

Хэдэн үеийнх вэ?

4 дэх үе дээрээ яваа юм байна. Цэвэр хавтгай орсон манай нэг ингэнээс ботго төрөөд, тэрүүгээр нь манайх буур тавьсан юм. Тэгээд түүнээс гарсан төл нь гэсэн үг. Гэтэл манай мал жаахан нүсэрдээд, малаар цуг яваад байх хэцүү. Тэгээд тэр эрлийзийн буурыг зогсоосон.

Та тэр буурыг зогсоосон гэв үү? Тэгэхээр зассан гэсэн үг үү?

Тийм ээ, тэгээд үржүүлгийг нь зогсоосон.

Яагаад зогсоосон бэ?

Их ааш муутай, чадал чансаа шаардсан тэмээ байдаг. Тэгээд дараа нь монгол бууранд эрлийз ингээ тавиад ирэхээр зан нь зөөлрөөд номхроод ирдэг юм. Манай нутагт тиймэрхүү эрлийз, хурлийзүүд зөндөө бий бий.

Танай сүрэгт одоо хичнээн бэсрэг тэмээд байдаг вэ? Та тооцоолж үзсэн үү?

Манайд 10 гаруй бий байх. Бэсрэг тэмээ яг л хангал догшин морь шиг л гэсэн үг. Тангарах, тийрэх, ёврох, хазах, хайрах гээд их юм бий шүү. Гарын тэмээнээс хамаагүй чанга. Тэрнийг номхруулж малаа болгож авахын тулд нэлээн л юм болно.

Бэсрэг тэмээний ач холбогдолтой тал нь юу байдаг вэ?

Унаж, эдлэхэд сайхан. Явах шиг л болдог. Өглөө мордоод гарахад орой унаатай л ирнэ гэсэн бодолтой явж болно гэсэн үг. Түүгээрээ их онцлог сайхан чанартай. Гэхдээ шууд эрлийз гэхээсээ гурав дахь, дөрөв дэх үерүүгээ ороод ирэхээр арай дээр байдаг. Ухаандаа манайхны тэмээ рүү шингээд л байна гэсэн үг. Бас сүү их сайтай. Зарим нь бүр онцгой гардаг. Зарим нь ч бас тааруу.

Та ер нь цаашид өөрийнхөө сүрэгт бэсрэг тэмээ нэмэгдүүлье гэж бодож байна уу?

Яахав чадал чансаатай, яруухан ярьдаг, сэлүүхэн явдаг цагт бол цөөн тоотой байлгаад байж болох л юм билээ. Олон тоотой бол хэцүү юм билээ. Залуу зандан насандаа бол үржүүлж явсангүй, хөгширсөн хойноо үржүүлж болох л байж гэж бодож явсан үе байсан. Харин манай хүүхдүүд нөгөө хэдийгээ жаахан монгол тэмээ талруу нь шингээгээд байгаа юм билээ. Цусыг нь бол нэх холдуулаагүй байлгаж л байна.

Аа бас тэгээд манайхны тэмээг бодвол он цагийн хатуу, зөөлнийг сайн даадаг амьтан юм билээ, төрөлх чанар нь л байх. Өнөө залуусын хэлдгээр ёстой гүрийнэ шүү дээ. Муу л юм харагдаад байдаг. Манайхны ботго үхээд байхад, тэдний ботгонууд үхэхгүй шүү дээ. Тэр талаараа бас онцлогтой.

Та тэмээн уралдаанд оролцож байсан уу?

Насаараа оролцсон. Одоо ч манай хүү уралдаад л байгаа.

Тэмээн уралдаан танайд анх хэзээ зохиогдож эхэлсэн бэ?

Анхнаасаа миний ээж аав, буурал аав, буурал аавын аав зэрэг өвөг дээдсийн үеэс уралдуулсаар л ирсэн. Цагаан сараар хамгийн сайхан, гоё ганган тэмээгээ унаад л өглөөнөөс эхлээд орой нар жаргах хүртэл уралдуулдаг байсан гэж ярьдаг. Энэ бол их дээрээс уламжилж ирсэн зүйл юм билээ. Одоо бол яг морь шиг л болсон.

Нас, насаар нь уралдуулах уу?

Тийм ээ. Яг даага уралддаг шиг торомоо уралдуулна. Гурван настай тэмээг шилбэн тайлаг гэдэг. Шилбэн тайлагны уралдаан бий. Дөрвөн настайг хөгшин тайлаг гэдэг. Хөгшин тайлагний уралдаан бий. Тэр хоёрыг бас хооронд нь холиод уралдуулдаг. Их насны тэмээ гэж бас бий. Гурван насны л тэмээний уралдаан болдог. Эрлийз тэмээ уг нь тусдаа уралддаг байсан. Одоо үе дамжсаар хурлийз нь цуг уралддаг болсон.

Гаднаасаа мэдэгдэх үү?

Мэдэгдэнэ ээ, андаш байхгүй. Гаднаасаа чөрийсөн том толгойтой, хөх, ухаа шар юмнууд бий.

Мориор бол соёолон их хурдан байдаг бол харин тэмээнд?

Хөгшин тайлаг гэдэг бол соёолонгийн урдах нас байгаа юм.

Та тэмээтэй холбоотой ямар нэгэн зан заншил, хорио цээр мэдэх үү?

Өдөр судрыг нь тааруулж байгаад хөгийг нь авах зэрэг олон зүйл бий л дээ.

Та Гүнжлхам гэж дуулсан уу?

Энэ бурхан биз дээ. Орсон буурын орой (толгой) дээр лхам бурхан залардаг гэж ярьдаг. Тиймээс орсон буурыг зоддоггүй, харааж зүхдэггүй, уналгад хэрэглэдэггүй юм гэдэг. Орсон буурыг их хүндэтгэдэг. За тэгээд орсон буур байхад буурны ижил сүрэг рүү боохой орно гэдэг тун ховор шүү дээ. Хааяа нэг тохиолдол л байна гэхээс биш.

Танайд Гүнжлхам бурхан бий юу?

Манайд бол байхгүй. Айлуудад байдаг юм билээ.

Та өөр тийм бурхан мэдэх үү?

Тэмээний банзрагч гэж бурхан байдаг. Хоёр талдаа даавуун савхитай том бурхан байдаг. Цагаан сараар бол буур жинхэнэ ид улаан галзуу дээрээ байдаг. Энэ үед цагаан сарын өглөө эрт босоод буур хаашаа хараад шавж зогсож байна. Түүгээр зун болно гэж байгаль дэлхийг шинждэг.

Шавах гэдгийг та тодруулж хэлэхгүй юу?

Буур шавах гэдэг нь буур орохоороо оцойж зогсоод сүүлнийхээ үзүүр дээр шээгээд хойд хөлийнхээ ар дээр цохиж шавахыг хэлдэг. Газар зүгээр шээхгүй. 25:38 гэж ярьдаг. Тиймээс сүүлнийх нь үзүүр дээр цагаан мөс болчихсон явж байдаг амьтан. Өглөөд нэг ингэ усалчихаад хоёр, гурав баалгана. Бэлчээр дээр гараад дөрөв, тав өвс үмхэнэ. Тэгээд өөр идэж, ууна гэж байхгүй. Зохих хэмжээний нөөц нь тэгж таардаг амьтан шиг байна билээ. Буур дотроо олон янз. Сайхан зантай буур бий. Ааш муутай буур гэж бий. Ааш муутай буур бол орооны цагт маш хэцүү. Ерөөсөө барагтаа хүн ойртуулдаггүй буур ч бий. Сайхан налалзсан амьтан ч бий.

Буур орохоороо хүрхрэх (хүрхрэх) гэж нэг юм бий. Машин шиг дуугарна. Зарим нь хур хур гээ л дуугарна. Түүгээр нь тэдний буур сайхан дуугарч байна. Тэдний буур муу дуугарч байна гэж хүндэтгэдэг, шинждэг юм бий. Шилж шилж байж л буур болгодог юм шүү дээ.

Тэмээтэй холбоотой домог, аман хууч зэргийг мэдэх үү?

Уулган шар гээд хууранд оруулдаг домог бий. Би ч өөрөө оролддог л юм. Сайн тэмээ байсан гээд ярьж л байдаг юм.

Аян жинд явж байсан тухай нэг домог ярьж өгье. Дээр үед хангайнхан бол үхэр тэргээр жинд явж байсан. Гөвийнхон бол тэмээн жингээр явж байсан. Бээжин, Хөх хот зэрэг газрууд руу явдаг жинчид байсан гэдэг. Тэд нар ийш тийшээ явах болохоороо би тэдний тэр тэмээг авч явна гэж өөрсдөө сонгодог байж. Тэгэхэд жил болгон жинд явуулдаг, ачаа сайн даадаг том атнууд байдаг байжээ. Тэгж байтал нэг шинэ хүнд том хүрэн ат ороод явж байжээ. Тэгээд тэр хүн Хүрээ орох гээд Туул голын хөвөөн дээр очоод яадаг юм бол, хаагуур нь гардаг юм бол гээд ихэд эргэлзээд тулгараад зогсож байж. Тэгсэн тэр хүрэн тэмээ дунд нь хавчуулаатай явж байгаад эзнээ яахыг мэдэхгүй зогсоод байхыг нь харчихаад бурантагаа урд талын тэмээнээсээ суга татаж аваад голын гарамыг олж очоод гарч байсан юм гэдэг. Тэгээд тэр тэмээг бусад нь дагаад цувраад гарч байсан юм гэнэ билээ. Гэтэл тэр тэмээ нь жил бүр явсаар байгаад Туул голын гарамыг мэддэг болчихсон тэмээ байж л дээ. Тэмээ бол тийм хэрсүү амьтан. Тэр тэмээг Гэндэн сумны хүрэн гэдэг байсан юм гэнэ билээ.

Энэ хэзээ болсон явдал вэ?

1910-1920 оны үед л болсон явдал болов уу. Үүнийг би өөрийн өвөг эцгүүдээс дуулсан. Миний аав бол Хөх хот, Бээжин зэрэг газар руу жин тээж явсан хүн юм билээ. 1980 хэдэн оны үед 80 нас гараад бурхандаа явсан. Тэр хүн тэгж ярьж байсан. Тэмээгээр тэгж жин тээдэг байсан үе хамгийн сүүлд надаар дууссан. Хамгийн сүүлийн тэмээн жин надаар дууссан. Тэр үед надтай хамт явсан 2, 3 өвгөн одоо бий.

Хэдэн онд та явсан бэ?

1967 онд.

Хаанаас хаа хүрсэн бэ?

Баянлиг – Хархорин, Баянлиг- Улаанбаатар гэж явж байсан.

Ямар учиртай жин байсан бэ?

Гурил будаа зэрэг янз бүрийн л ачаа тээж ирж байсан.

Тэгэхэд нийт хэдүүлээ явсан бэ?

За хө тэгэхэд 9-үүлээ явсан юм байна. Бригад тус бүрээс 3 хүн ороод есүүлээ болсон. Нийтдээ 100 гаруй тэмээтэй явж байсан юм.

Тэмээгээ яаж сонгож байсан бэ?

Ачаа даах, алс хол явах чадал чансаатай тэмээнүүдээ айлууд нь өөрсдөө сонгоод өгч байсан юм. Бид нар ч өөрсдөө сонгож байсан юм. Нэг тэмээ ойролцоогоор 250 орчим кг ачаа даадаг юм. Харин алсын жинд бол 170, 180 орчим кг ачаа л ачиж явдаг.

Ачаалж явахад тэмээдийн зохион байгуулалт ямар байдаг вэ?

Хамгийн номхон, ачаа сайхан даадаг тэмээгээ “гарын тэмээ” гэж гарт авч явдаг. Жаахан авир араншинтай тэмээгээ хойно нь хавчуулдаг. За тэгээд ачаа бараа хазайхад сандрахгүй, ийш тийшээ гүйгээд явчихдаггүй тэмээг бас гартаа авч явах нь бий. Үгүй бол сүйдлэх аюултай.

Тэгээд тэрхүү ачааны хамгийн сүүлийн тэмээнд хонх явдаг. Шөнө дөл явж байгаад хонхны дуу гарахгүй бол ямар нэгэн саад гарч ачаа тасарсан байх магадлалтай байдаг. Хүн заримдаа үүрэглэж барьж, анхаарал алдах тохиолдол бас байдаг шүү дээ. Ард, өмнө талд нь бас “ачаа шорлож явдаг хүн” гэж хоёр хүн явна. Ард яваа хүнийг бас “хоргол хөөж яваа хүн” гэж ярьдаг л байсан. Харин арай өмнөхөн яваад энд тэнд ганга эрэг байна гэх зэрэг газар үзэж явдаг хүнийг ачаа шорлож явдаг хүн гэдэг байсан.

Ачааны үед номын тэмээ, бурханы тэмээгээ хаана авч явах вэ?

Хэрэв хүүхэдтэй бол нүүж явахад хүүхэд ачсан тэмээгээ нэг гартаа барина. Араас нь бурхан ачсан тэмээгээ уядаг. Харин хүүхэдгүй бол бурхан ачсан тэмээгээ эхэлж гартаа барьж явна. Тэмээнээс өөр зэрлэг амьтад хотонд орж ирэх, малтай эрлийзжэх зүйл байдаг уу?

Манайд тийм юм дуулдаагүй. Нэг айлд л янгир орсон гэсэн яриа гарч байсан. Тэгээд ноолуур муутай юм байна гээд байлгасан юм гэнэ билээ.

Танай нутагт “мөнгөн буйл”-тай хүн байдаг уу?

Бий. Тэмээ түм хүрээд “мөнгөн буйл”-аар шагнуулж байсан юм гэсэн. Ламын гэгээний улаан тэмээтэй. Манай суманд тэмээний хоёр ч хөдөлмөрийн баатар байдаг. Сугар-Очир, Тойвгоо гээд. Тэмээнийхээ тоогоор манай сум улсад 3-р байранд ордог. Урьд нь уг нь Өмнөговийн нэг сумын дараа 2-р байранд ордог байсан юм. Энэ жил 3-р байранд орсон байна билээ.

“Алтан ботго”-ны эзэн бий юу?

Байгаа. Хөдөлмөрийн баатар Сугар-Очирынд бий.

Төрөөс тэмээнд холбогдох дэмжлэг урамшуулал, бодлого бий юу?

Тодорхой юм яригдахгүй байна. Яг тэгвэл ингэнэ гэсэн юм тодорхой шийдтэй юм дуулахгүй байх шиг.

Хэрэв орсон буур хүн рүү дайрвал яаж хамгаалах вэ?

Нүдрүү нь цохихоос өөрөөр эргэдэггүй амьтан даа. Яг нүдрүү нь л цохивол нэг далдичдаг. Өөрөөр бол эргэдэггүй. Шороогоор өмнөөс нь цацаж болно. Гэхдээ нунтаг зөөлөн элс шороогоор тэгнэ үү гэхээс дайрга бол цацлаад нэмэргүй. Мод, төмөр байсан ч нэмэргүй байдаг.

Тэмээтэй холбоотой ямар эд хэрэглэлүүд байдаг вэ?

Сайхан хивс тохом, ногт эсвэл морины хударга шиг юмнууд ч байдаг. Өрвөлөгөөс нь ч юм уясан л харагддаг.

Тэмээнээс хичнээн хэмжээний ноос гардаг вэ?

Өнөө нормлож байх цаг үед 20 кг гэж ярьдаг байсан. Атнаас 7-8 кг орчим гардаг, дундаж нь тэр орчим. Тэмээ ноос хаяна гэж бас бий. Энэ жил нэг өөр байхад дараа жил бас л өөр байх жишээтэй байдаг. 200 тэмээтэй айлыг дунджаар бкг ноосоор тооцож авдаг л байсан.

Одоо тэмээний ноосны үнэ ханш ямар байдаг вэ?

Наймаачдын авах үнэ ханш янз бүр байдаг. Зарим жил 2-3 мянган төгрөг болчихсон байхад заримдаа 10 гаруй мянга болчихсон ч явж л байдаг.

Энэ жилийн үнэ ханш ямар байна?

Одоо үнэ нь гараагүй байна. 4-р сараас эсхүл 5, 6 дугаар сараас л жинхэнэ үнэ нь гарч эхэлнэ.

Тэмээ эр ноос, эм ноос гэж хоёр янзын ноостой амьтан. Тэр эр ноосыг нь бид нар томж тэмээ оосорлодог, гэр, ширдэг оёдог утсаа хийдэг. Эм ноосыг нь бол тушаачихдаг.

Эм ноосыг нь ашигладаггүй юм уу?

Одоо ашигладаггүй. Урьд нь хөвөнтэй дээл энэ тэр хийгээд ашигладаг хүн зөндөө л байсан.

Тэмээ бүрт эм ноос, эр ноос гэж байдаг. Зогдорын ноос бол жишээ нь эр ноосыг хэлдэг. Эм ноос гэдэг нь их биенд нь байдаг ноосыг хэлдэг.

Тэмээний сүү цагаан идээ ямар байдаг вэ?

Би насаараа тэрийг хэрэглэж л хүн болсон.

Онцлог нь юу байдаг вэ?

Ямаа шиг хурдан саагаад алга болчихдоггүй. Бүтэн жилдээ саалгадаг амьтан. Сааль урттай гэдэг нь тэр. Тэмээ бол өнжиж төллөдөг амьтан. 10 ингэтэй айл байлаа гэхэд нөгөө талдаа ингэ байхгүй бол нэг жил ааруул, сүүтэй цай уухгүй гэсэн үг. Тиймээс хоёр талдаа жилд л 10, 10 ингэ ботголоод байхад л тухайн жилдээ хэрэглээ нь болоод явчихна гэсэн үг. Ингэний сүү, өрөм, бяслаг, аарц, ааруул бүгд бий. Ямаа, үхрийг бодвол тэр нь хомсхон шиг мөртлөө амт нь их сайн. Манай нутагт цагаан сар болохоор тийшээгээ л их хошуурдаг.

Одоо бол танайд тэмээний мах иддэг байх, тийм үү?

Тийм ээ. Байнга хэрэглэнэ.

Урьд нь тэмээний мах иддэг байсан юм болов уу?

Тэмээг манай энэ нутагт тэнгэрийн амьтан гэж үзээд нухаж иддэггүй байсан юм гэнэ билээ. Тэгээд энэ Өмнөговийн урд талын сумыг Балдан засгийн хошуу гэдэг байсан. Тэнд л тэмээ иддэг байсан гэж ярьдаг байсан. Тэгээд 1950 хэдэн оны үеэс хойш тэмээ нухаж иддэг болсон. Бүр тэмээ нухаж идсэн айлд ордоггүй, зугатдаг байсан юм гэнэ билээ. Одоо ч цаг нь өөр болоод тэмээ нухсан айл руу хошуурдаг болсон юм даг уу. Тэр Балдан засгийн хошууныхныг л дээр үеэс тэмээг хүнсэнд хэрэглэдэг байсан юм гэнэ гэж ярьдаг байсан. Одоо бол тэмээг хамгийн чанартай махтай, хамгийн аагтай өвс ногоо идэж уудаг гээд ноднингоос авахуулаад тэмээ рүү их хошуурдаг болсон байна.

Одоо тэмээний үнэ ханш ямар байна вэ?

1 саяас л дээш явна. Нас гүйцсэн тэмээ 2 сая гээд л явна. Тэрнээс доош торомыг хэдэн зуу, тэдэн зуу гээд өгч л байдаг юм. Тэмээнийхээ бие цогцосноос хамаардаг.

Тэмээний хэрэглээ нэмэгдэж байна уу? Буурахаар байна уу?

Хэрэглээ бол хэвээрээ. Унаж эдлэх нь л буураад байна. Мотоцикл, машин гарсан цагаас л хойш ийм юм болоод байна.

Тэмээг оршуулгын зан үйлд хэрэглэдэг талаар та юу мэдэх вэ?

Ачлаганд нь хэрэглэдэг байсан. Саяхан хүртэл байсан л зүйл. Хоёр ачаа түлээ ачаад дээр нь тавиад л явдаг байсан гэдэг.

Тэмээг гэрийн бууринд оруулдаггүй гэдэг?

Тэмээгээр гэрийн буурь гаталж болдоггүй гэж одоо ч ярьсаар л байдаг. Дээр үеэс л айлын бууц дайрдаггүй, олз хаадаг, сайн муу юм орж ирдэг юм гэнэ билээ гэх зэргээр ярьдаг байсан гэдэг.

Тэмээ сэтэрлэдэг үү?

Сэтэрлэдэг. Одоо харин сэтэрлэхээ больжээ. Намайг бага байхад таван хошуу малыг бүгдийг нь л сэтэрлэдэг байсан. Тэмээ нухаж иддэггүй байсан үедээ сэтэрлэдэг байсан л юм гэнэ билээ. Тэмээ иддэг болсноосоо хойш л ёстой хамаа замбараагаа алдсан юм шиг байна. Одоо танай сүрэгт сэтэртэй тэмээ бий юу?

Байхгүй. Би бол тэмээ нухаж иддэг хүн учраас.

Тэмээн дунд эрхэмлэдэг зүс гэж байх уу?

Дээр үед хөх халзан тэмээг зүс муутай л гэж ярьдаг байсан. Одоо ч байжээ.

Тэмээтэй холбогдох тахилгатай уул, овоо байдаг юм болов уу?

Манайхаас өмнө Баянхонгор, Өмнөговийн зааг дээр “Цагаан буур хайрхан” гэж байдаг.

“Цагаан буур хайрхан” ямар учиртай вэ?

Яг шавж байгаа буур шиг цагаан халзан толгой байдаг юм. Тэрийг ботголдоггүй, сааль авдаггүй ингийг дэргэд нь уяж хоноод хойтон жил нь ботголуулж байсан гэж ярьдаг байсан юм. Ботголдоггүй ингийг эрмэг ингэ гэдэг. Тэр хайрхан нь зүүн тийшээ хараад шавж байгаа буурын хэлбэртэй юм гэсэн.

Тэр хайрхан аль сумын нутагт байдаг вэ?

Өмнөговь аймгийн Сэврэй суманд ордог юм билээ. Уг нь манай сумдын зааг дээр л байдаг юм.

Тэр тахилгатай хайрхан уу?

Дээр үед тахидаг байсан юм гэнэ билээ. Одоо бол мэдэхгүй.

Тэмээтэй холбоотой ямар нэгэн үг мэдэх үү? Тэмээ хариулсан хүн буурынхаа занг андахгүй гэх зэргээр монголчууд ярьдаг даа?

“Ноолоход номхон тэмээ амар” ч гэж байх шиг ярьж л байдаг юм.

Та ургийн овгийнхоо тухай дэлгэрүүлж ярихгүй юу?

“Өвгөн Жигжид” гэж овогтой.

Нэлээн түрүүхэн энэ овог тань өөр байсан уу?

Мэдэхгүй. Энэ нэлээн дээр үеийн л хүн юм билээ.

Та халх хүн үү? Танай нутагт ямар ургийн овогтой хүмүүс байдаг вэ?

Тийм. Өөр овог бараг байхгүй дээ. Гэхдээ өөлд ястангууд байдаг гэж яригддаг л юм. Өнөө Галданбошготын дайн гэж ярьдаг шүү дээ. Тэрнээс л гарч ирсэн улсууд гэж яригддаг .

Та тэгж хэнээс дуулсан бэ?

Өвөг дээдсээсээ л дуулсан.

Түүнтэй холбоотой газар усны нэр танайд байдаг уу?

“Өөлдийн ус” гэж нэртэй газар бий. Энэ “Их баян” гэдгийн өвөр рүү байдаг.

За хүү минь надад бас хэлэх үг байна. Тоож асуулт асуусанд чинь баярлалаа.

Дүүрэн жаргалтай

Төвшин биетэй

Саруул сайхан

Эрүүл энх байхын ерөөлийг дэвшүүлье ээ.

*“Алтан ботго”-ны эзэн Сонгуулийн Жуул. Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын харьяат. 44н, эр, “шармаан” овогтой.*

Та яг одоо амьдарч байгаа газрынхаа нэрийг хэлнэ үү?

Би Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын “Найз” буюу 3 дугаар багийн иргэн.

Байгаа газрын нэр?

Зэлтэрийн гялаан.

Таны ургийн овог юу вэ?

Шармаан.

Та ямар ямар мал маллаж байна вэ?

Хонь, ямаа, тэмээ л байна.

Бэлчээрээсээ шалтгаалж эдгээр малыг маллаж байна уу?

Бэлчээрээс болж байна. Бас хүн хүчнээсээ ч болж байна.

Танайх одоо хичнээн тэмээтэй вэ?

Манайх энэ жил 500 гаруй л тэмээ тоолуулсан.

Танд тэмээ өсгөж маллах ямар шалтгаан байсан бэ?

Ер нь бол би өөрөө суурин газар өссөн хүн. Тэгээд 1990 он гараад өмч хувьчлалаар жаахан мал аваад хөдөө гарсан. Сүүлд 2000 он гарснаас хойш амьдрал ахуй ч тэр, байгаа орчин нь ч тэр тэмээ өсгөвөл арай боломжтой юм болов уу гэж бодсон. Тэгээд ч миний дээд удмынхан ер нь тэмээ маллаж байсан улсууд байсан. Өсгөж, хүмүүжүүлсэн аав маань тэмээчин хүн байсан. Өвөө маань тэмээчин байсан. Тэгээ л тэмээ рүү орсон. Манай авга ах Туулайхүү гэж “аварга малчин” хүн байсан. Тэр хүнтэй айл саахалт байсан нь ч нөлөөлсөн. Тэр хүний заавар, зөвлөгөөг дагаж явдаг байсан.

Таны тэмээнүүд дунд онцгойлж хайрладаг тэмээ бий юу?

Байлгүй яахав. Хөдөө гадаа явгарах үед баригдчихдаг, номхон, унаад явахад явгалчихдаггүй тийм тэмээнүүд байна.

Та тэмээндээ нэр өгдөг үү?

Нэр өгдөг. Тухайн тэмээнээсээ шалтгаалаад янз бүрийн л нэр өгдөг. Хүний голдуу нэртэй тэмээ ч байна. Зүсээрээ нэрлэгдсэн тэмээ ч байна.

Та сонгоод нэрлэж болох уу?

“Дагавар улаан”, “Шовгор хар” ингэ, “Зэрлэг хар” гэж байлаа. Гүндалай гэдэг нэртэй тэмээ ч байлаа.

Яагаад Гүндалай гэж нэрлэсэн юм бэ?

Зэлэн дээр олон ботго уяатай байгаад эх нь явчихаар, ботгонуудыг зэлнээс нь тайлж туухаар олон ботгонууд нэг л зүгрүү явж байхад зөрүүлээд ганцхан ботго ганцаараа өөр зүгт яваад байдаг байсан. Тэгэхээр нь тэгж нэр өгсөн.

Та хавтгай тэмээний талаар хэр дуулсан бэ?

Ерөөсөө мэдээлэл бага. Одооноос л харин тэмээ мал уядаг зарим хүүхдүүд энд тэндээс хавтгай тэмээний хурдан эрлийз авчирч байна гэж ярих болсон. Манай энд хавтгай тэмээ байхгүй учраас мэдэхгүй.

Та тэмээн уралдаанд хэр оролцдог вэ?

Би тэмээн уралдаанд оролцоод байдаггүй. Бага залуу байх үедээ амьдралдаа ганц хоёр удаа л тэмээн уралдаанд орж байсан. Өөр зүйл байхгүй.

Цогт-Овоо суманд тэмээн уралдаан зохиогддог уу?

Тэр бол байнга. Жил болгон л тэмээний баяр хийдэг. Ноднин хоёрдугаар сард тэмээний баяраа хийсэн.

Танайд бэсрэг тэмээ байдаг уу?

Байгаа. Ер нь бол ороод ирчихсэн.

Тэр одоо баруун аймгаас авчирсан гэсэн үг үү?

Тийм. Зарим нь 70, 80 эсвэл бүр 50 хувийн цустай тэмээнүүд байдаг.

Хэзээнээс тэгж сонирхож авчрах болов?

Сүүлийн 3, 4 жилээс л их эрчимжэж байна. Манай аймагт Гиннесийн тэмээ уралдсан даа, тэгэхэд л их ховор байсан. Баянхонгорын Шинэжинст, Баянлиг өөр сумуудаас тийм тэмээ ирж байснаас биш манайд бол их байгаагүй.

Бэсрэг тэмээг уралдаанд оруулахыг хориглож байсан уу?

Их хориглодог байсан. Гэтэл саяхан аймагт нэг тэмээчдийн зөвлөгөөн болсон. Би өөрөө тэнд очсонгүй. Тэр хурал дээр бол бараг хүлээн зөвшөөрч байгаа, адуу шиг ялгаж уралдуулах хэмжээнд ярилцсан юм шиг байсан.

Та өөрийнхөө сүрэгт бэсрэг тэмээ нэмэгдүүлье гэж бодож байсан уу?

Тийм юм боддоггүй. Тэр тэмээ уяж барьдаг хүмүүсийн хэрэгцээнд л хэрэгтэй байх. Миний хэрэгцээ бол арай өөр болохоор тэгж боддоггүй.

Тэмээтэй холбоотой ямар нэгэн зан заншил мэддэг үү?

Өөрийнхөө хэмжээнд л.

Танайд тэмээ, ингэ, буур гэх зэрэг нэр орсон газар байдаг уу?

Ер нь ховор. “Тэмээн гашуун” гэж нэртэй нэг газар бий.

Хаана?

Мандал-Овоо, Цогт-Овоо хоёр сумын зааг дээр байдаг тийм газар бий. Ямар учраас тэгж нэрлэснийг мэдэхгүй. Ургамлаасаа болсон байж магадгүй гэж боддог.

Та Гүнжлхам гэж сонсож байсан уу?

Тэмээний бурхан байдаг.

Танайд тийм бурхантай холбоотой ном судар байдаг уу?

Манайд яг тийм бурхан байдаг эсэхийг мэдэхгүй. Харин “малын банзрагч” гэж судар байдаг.

Тэмээтэй холбоотой овоо тахилга, уул хайрхан байхгүй юу?

Санаанд орохгүй байна.

Тэмээтэй холбоотой аман домог, хууч яриа мэдэх үү?

Миний өвөө аав Түдэв гэж хүн байсан. Тэр хүн бага залуудаа амьдрал нь бас их тааруухан хүн байжээ. Тэгээд Дулам гэж нэг хүнтэй ханилаад хүүхэд ч тогтдоггүй байсан юм гэдэг. Тэгээд сүүлд нэг лам дээр очиж үзүүлжээ. Гэтэл нөгөө лам нь нохой их олныг тэжээ тэгвэл хүүхэд тогтоно, олон тэмээтэй болох юм байна гэж хэлсэн гэдэг. Нохойг бараг 30 хүртэл нь тэжээ гэж хэлжээ. Тэгээд өвөө маань нохой олон тэжээгээд хүүхэд тогтоод олон тэмээтэй, олон нохойтой айл болсон гэдэг. Янз бүрийн хамуутай, муу ботго тором энэ тэр цуглуулсаар байгаад нэгдэл нийгэм болсон. Манайд “Жаргалант” нэгдэл гэж байсан. Тэгэхэд 370-аад тэмээ нийгэмчилсэн гэж ярьдаг юм. Тэгж тэмээ нь их олон болсон байсан. Гэтэл нэг бууран тайлаг нь манай Цогт-Овоо хайрхан руу явчихаад болж өгдөггүй байж. Гэтэл өвөө тэрийг очиж хүчээр барьж, хөтөлж авчрах гэсэн нөгөө тэмээ явахгүй чаргуулдаад л байсан гэдэг. Тэгээд арай гэж нэг юм хөтлөж авчраад, хоноод өглөө бостол гадаа зэлтэй тэмээнээс нь хэд хэдэн тэмээ үхчихсэн байсан гэсэн. Тэгээд ламаас очиж асуутал Цогт-Овоо хайрхан тэр бууран тайлагийг чинь авчихсан байжээ, тэр бууран тайлагийг нь буцааж тавь гэж хэлсэн юм гэдэг. Тэгээд тэр бууран тайлагийг тавиад явуултал Цогт-Овоо руу явчихсан гэж ярьдаг байсан.

Тэмээг оршуулгын зан үйлд хэрэглэдэг байсан талаар та юу мэдэх вэ?



Тийм юм байсан гэж эгч ярьдаг.

Тэмээн жингийн талаар та ямар нэг зүйл мэдэх үү?

Мэдэхгүй. Манай тэр нагац ах Туулайхүү гэж хүн л жинд явдаг байсан. Явж явж л буцаж ирэхдээ нэг жаахан гурил будаа зэрэг шалихгүй жаахан юм л олж ирдэг байсан даа гэж ярьдаг байсан. Тэр талаар би сайн мэдэхгүй.

Тэмээнд ачаа ачих зохион байгуулалтын талаар та юу мэдэх вэ?

Сайн мэдэхгүй. Бид нарын үед тэмээн тэрэг гэдэг юм байсан. Тэмээ хомнож нүүх гэдэг зүйл бол яг л алга болж байсан үе.

Танайд одоо тэмээгээр нүүдэг айл бий юу?

Байхгүй болсон.

Хамгийн сүүлд хэзээ тэмээгээр нүүдэл хийсэн бэ?

1990 оны сүүлч 2000 оны эхээр л тэмээ хомнох зэрэг зүйлүүд больсон байх шүү.

Танайхны хот айлуудад зэрлэг амьтад орж ирэх, эрлийзжэх тохиолдол гардаг уу?

Тийм юм гайгүй.

Танай нутагт “мөнгөн буйл” авч байсан хүн бий юу?

Манай Цогт-Овоо сумын “Жаргалант” нэгдэл л 1980 хэдэн онд авч Зил-130 машинаар шагнуулж байсан гэж яригддаг байсан. Бусдаар бол хувь хүн, малчин өрх тийм юм авч байгаагүй болов уу.

Танай нутагт “алтан ботго” авч байсан хүн бий юу?

Манай нутаг 60 гаруй жилийн түүхтэй сум. 80 хэдэн оны сүүлээр шиг санагдаж байна, манай аав Түдэвийн Шар гэж хүн байсан, миний яг төрсөн эцэг л дээ, тэр хүн БНМАУ-ын аварга тэмээчин, “алтан ботго”-ны эзэн хүн байлаа. Одоо бол би аавынхаа дүүгээр овоглож яваа хүн юм. Тэгэхэд аав тэр “алтан ботго”-ыг анх удаа авч байсан юм. Тэгээд түүнээс хойш бас л “алтан ботго” авсан хүн байхгүй байж байгаад 2020 оны үед надад ноогдсон юм. Манай сумын түүхэнд “алтан төл”-ийн эзэн хоёр л тодорсон. Нэг нь аав, нэг нь би байлаа. Энэ “алтан ботго”-ыг ямар шалгуураар өгдөг вэ?

Сүүлийн гурван жилийн төлийн бойжуулалт, тэмээ өссөн байдал, сааль сүү хардаг байх. Аавын үед бол нэгдэлд тушаах сааль сүүний норм гэж байсан байх. Тэр үеэр нь Монголын радиогийн сурвалжлагч Амбасэлмаа гуай ирж аавтай хамт ботгыг нь тоололцож байсан юм гэдэг. Тэгээд аав ярьж байж билээ, энэ Амбасэлмаа их мундаг хүн юм аа, хаврын тарчиг цагт ирчихсэн надтай хамт ботго тоолоод л явж байдаг гэж. Та 100 ботго гэсэн, гэтэл 103 ботго байгаа нь ямар учиртай юм бэ гэж Амбасэлмаа надаас асууж байх юм, сүрхий тоолдог хүн юм. Тэр 3 ботго нь яахав дээ насанд хүрээгүй гунжин торомын ботго юм аа, тэрийг тоонд оруулаад яахав дээ гэж хэлдэг байсан юм. Харин одоо бид хоёрын хувьд бол төл бойжуулалт тэгээд тэмээний ашиг шимийг хүргэх, сумуудын сүү цагаан идээний үзэсгэлэн худалдаанд оролцсон байдал зэрэг зүйлийг харж байж өгсөн юм билээ.

Цогт-Овоо сум тэмээний тоогоороо хэр вэ?

Манай сум аймгийнхаа хэмжээнд 4 эсвэл 5 дугаар байранд л бичигддэг байх.

Танай суманд танайхаас илүү тэмээтэй айл өрх бий юу?

Манай суманд байдаггүй бололтой юм билээ.

Төр засгаас тэмээтэй холбоотой өөр өгдөг дэмжлэг, шагнал урамшуулал байдаг уу?

Гэр бүлийн хүн маань ноднин жил боловсруулсан сүү цагаан идээгээрээ төрөл бүрийн үзэсгэлэн худалдаанд оролцож, хэдэн жилийн хөдөлмөрөө үнэлүүлж, Өмнөговь аймгийн 90 жилийн түүхэнд анх удаа Улсын аварга саальчин болсон.

Тэмээгээрээ юу?

Тийм, тэмээгээрээ.

Тэмээний сүү цагаан идээ нь бусад малаасаа ямар онцлогтой байдаг юм бол?

Онцлог нь сүүлийн үед тэмээний сүү цагаан идээг маш их өргөн дэлгэр ашигладаг болчихсон байна. Янз бүрийн өвчнөөс хамгаалах ашиг тустай гэдэг болж. Уургийн агууламж нь бас маш их өндөр байх юм.

Орсон буур аюултай амьтан уу?

Тухайн буурын зан араншингаас л болдог. Гэхдээ ямар ч номхон буурыг энэ номхон гэж бодож болдоггүй юм билээ. Янз бүрийн муухай ааштай буур байдаг л даа.

Тэмээний эд хэрэглэлийн тухай ярина уу?

Тохош, ногт, бурантагнаас эхлээд олон л зүйл ярих байх даа.

Тэмээний бурантагны модыг яаж хийдэг вэ?

Буйлыг бол дэлгүүр хоршоонд зарж л байдаг юм. Миний хувьд бол өөрөө яваад авчихдаг.

Буйлыг ямар модоор хийдэг вэ?

Буйлс гэж мод байдаг. Тэрүүгээр хийдэг. Гэхдээ тэр модыг авдаг газар, авдаггүй газар гэж бас байна. Ерөнхийдөө бол *идэр гурван есийн хүйтэнд лус савдаг унтаж байх үеэр очиж авдаг ном журамтай.*

Тэмээнээс хичнээн хэмжээний ноос гардаг вэ?

Ерөнхийдөө бол ноосны урамшуулал гэж олгодог. Тэнд нэг тэмээний ноосыг 5кг-аар боддог. Яг амьдрал дээр бол 5 кг-аас илүү л ноос гардаг. Ноос ихтэй бүдүүн буурнаас бол 15-20 кг ноос гарах нь ч бий. Улсаас бол 5 кг гэж тооцоолдог. Зөвхөн тэмээ гэхгүй хонины ноос, түүхий эдийн урамшуулал гэж бас хамт ордог.

Тэмээг хэдий үеэр ноосолдог вэ?

Тэмээг тухайн цагаас шалтгаална. Сүүлийн жилүүдэд 3, 4 дүгээр сарын үеэр хавсаргатай байх болсон учраас 5 дугаар сар гаргаж байгаад ноослох болдог.

Танайх тэмээгээ ноослоход нэлээд хугацаа орно биз дээ?

Ах дүү, найз нөхөд ирээд хамтдаа хяргаад эхлэхээр 500 гаруй тэмээг шаргуухан ноослолоо гэхэд 6, 7 хоногт хяргачихдаг юм.

Тэмээний ноосны үнэ ханш ямар байгаа вэ?

Жил жилээсээ шалтгаална. 2010 хэдэн оны үед нэг жил айхтар их өссөн юм. 1 кг ноос 20 мянган төгрөг гарсан юм. 2005 оноос өмнө бол харин гавьтай байгаагүй. 1 кг нь 2-3 мянган төгрөг л байсан. Харин өнгөрсөн жил тэмээний ноос 1 кг нь 10 мянгатай байсан.

Танайх өдөр тутам тэмээний мах хэрэглэдэг үү?

Тэгнэ. Зуны цагт бол бог мал, тэмээний борц хоёрыг хэрэглэдэг.

Ямар үед тэмээний махыг голчлон хэрэглэдэг вэ?

Өвөл цагт л тэмээний махаа хэрэглэдэг.

Урьд нь дээхэн үед тэмээний мах иддэг байсан уу?

Манай эгч бол ярьдаг байсан. Өөрөө тэмээний мах, зээрийн мах гээд ангийн махаар л хүн болсон гэдэг байсан. Тэгэхдээ дээр үед тэмээний мах иддэггүй айл байсан гэж ярьдаг байсан. *Тэгээд хүн ирээд тогоогоо угаа, тэмээний мах чанасан тогоондоо цай чанаж өгөх гэлээ гэж ярьдаг байсан.* Эгч маань бол өөрөө тэмээний мах л идэж өссөн хүн байсан.

Тэмээ ямар үнэ ханштай байна вэ?

Мах 1 кг нь 4.500-5.000 төгрөгний ханштай байна. Бүхлээрээ гэвэл нас наснаасаа шалтгаалаад янз бүр болно. Ингэн тэмээ 1 сая 200 мянга, бүдүүн тэмээ (400-с дээш дарах) бол 2 сая гаруй болдог. 2, 3 настай тэмээ бол 700-800 мянгатай байдаг.

Тэмээний хэрэглээ буурч байна уу? нэмэгдэж байна уу?

Гайгүй ээ. Сүүлийн үед тэмээний үнэлэмж өндөр болж байна. Ноос ноолуур үнэд хүрч байна. Уралдаан наадам хийгддэг боллоо. Тэмээний тоо толгой ч өсөж байна.

Хоормог ямар үнэтэй байна вэ?

Хоормог энэ жил цаг муу болоод 1 литр нь 11-12 мянгатай байна гэсэн. Цагийн сайханд 5-6 мянган төгрөг л гэж зарагдаж байсан.

Яагаад тэгж үнэ нь өсөв?

Байгаль цаг уураас л болж байна. Энэ жил гантай, манай урд талын сумд хэцүү байна. Тэгээд Дундговь руу ороод явчихаараа тэмээ цөөрчихдөг учраас хэцүү. Зарим айл тэмээгээ онд оруулахын тулд юун тэмээ саах болчихоод байгаа. Тийм байдлаар хоормог үнэд орсон байх. Тэмээнд эрхэмлэдэг өнгө зүс гэж байдаг уу?

Маллаж байгаа хувь хүнээсээ л шалтгаалах байх. Шар зүсмийн тэмээний ноос нь хавар их эрт унадаг, ноос тогтдоггүй. Харин бараан хүрэн зүсмийн тэмээний ноос тогтоц сайтай, арвин байдаг. Цагаан зүсмийн тэмээ, цагаан адуу энэ тэрд тийм сайнгүй.

Танай Цогт-Овоо сумын тэмээнүүд ямар үүлдрийн тэмээд вэ?

Манай энэ хавийн тэмээд Ханын хэцийн хүрэн тэмээддээ орно.

Энэ үүлдрийн онцлог нь ямар байдаг вэ?

Сүү арвинтай, ноос үс дажгүй, махны талруугаа тэмээнүүд байдаг.

Ханын хэцийн хүрэн ямар сумуудаар байдаг вэ?

Ханхонгороос хойш Цогт-Овоо сумын зааг дээр байдаг газрын нэр.

Цаашдаа та тэмээгээ малласаар байх уу?

Цаг бэрх байвал тэмээ өсгөхөд хэцүү. Манай энд задгай ус, булаг шанд гэж юм байхгүй. Ганцхан мотортой худагтай...

Тэмээгээ зарж борлуулья гэвэл зах зээл нь хэр юм шиг байна?

Зах зээл байлгүй яахав. Цогтцэций гэж том газар байна, аймаг байна. Бүр болохгүй бол хотоос ч ченжүүд давхилдаад ирдэг тийм л газар.

***Гэндэнгийн Дашчирэв. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын уугуул, 73н, эр, бэсүд овогтой.***

Хавтгай танай нутагт байдаг уу?

Байдаг.

Эхлээд та өөрийнхөө тухай товч танилцуулна уу?

Би Баянхонгор аймгийн Шинэжинст сумын уугуул Гэндэнгийн Дашчирэв гэдэг хүн байна. Төрийн байгууллагад 42 жил ажилласан. Үүний хажуугаар орон нутгийнхаа байгалийн талаар судалж, юм тэмдэглэж явдаг хүн. Сум орон нутгийнхаа музейг хоёр ч удаа байгуулж байлаа. Тэд нар маань устсан. Одоо харин хувьдаа нэг музей байгуулсан.

Дээр үед археологийн голдуу олдворууд буюу янз бүрийн ном судар, тулга, тогоо, зэр зэвсэг олддог л байсан. 1967 онд би 17 настай байсан юм. Тэгэхдээ л юм хийсэн байсан. Цэрэгт яваад ирэхэд юу ч үгүй болсон байсан. Дахиад 1974 онд цэрэгт явж ирэхэд намын даалгавар өгөөд дахиж хийлгэсэн. Энэ үед бол голдуу байгалийн холбогдолтой юмнуудаар хийсэн. Тэр маань 1990 оны хувьсгалаар бас алга болсон. Тэрнээс хойш одоо бол би нутгийн чулуу, амьтан, байгалийн ургамал зэрэг зүйлүүдийг цуглуулж байна. Тэгээд угсаатан, түүх, палеонтологийн олдвор зэрэг юу байдаг юм, дээр нь өөрөө жаахан гар урлалын юм нэмээд музей хийсэн.

Намаас хэрхэн, ямар даалгавар өгч байсан тухайгаа ярина уу?

1967 онд Намын Төв Хорооноос Сайд нарын Зөвлөлийн тогтоол гараад бүх суманд “Орон нутаг судлах музей” байгуул гэж тушаал гарсан. Тэгээд тэр дагуух курсыг 3 хоног аймагт зохион байгуулж байсан учраас музейгаа байгуулах болсон. Тэгэхэд үзмэр гэж юу болох,

яаж шилэн хоргонд байрлуулах зэрэг талаар яриа хийж байлаа. Тэр үед Юндэнбатаа гэж нэг мундаг, дээр үеийн настай хүн байсан. Тэр урьд нь лам хүн байсан юм билээ. Түүхийн талаар агуу мэдлэгтэй, гарын уртай тийм хүн байсан. Намайг 17-тай байхад л тэр 50, 60 орчим настай хүн байж. Цэрэгт яваад тэндээ дарга болоод мөн буцаж ирээд нэгдэлд дарга хийж байгаад тэгээд аймгийн музейн эрхлэгч болсон хүн байсан. Тэр хүнээс зарим зүйлийг сурсан.

Хавтгай тэмээ танай сумын хаагуур нутагтай вэ?

1956 онд манай Шинэжинст сум байгуулагдсан юм. Тэгэхэд “Цагаан хаалга” гэж сумаас 20-н хэд орчим км-ийн зайд байрлах газарт нэг тал урууддаг, нөгөө Сэгс Цагаан богд найраглалд гардаг бүс нутгаар тэр хавтгай тэмээ бол нэл байсан юм. Манай тэмээн сүрэгтэй зарим нь хамт ирж ус уугаад гарч байдаг байсан.

Та өөрөө харж байсан уу?

Зөндөө харж байсан. Маш элбэг байсан. Тэмээтэй хамт ус уудаг. Идэш тэжээл нь ч нэг газарт байсан. Зохиолч Пүрэвдорж гуай найраглалдаа хавтгай нь тэмээтэйгээ, адуу нь хулан, тахьтайгаа, аргаль, янгир нь хонь ямаатай нийлсэн нутаг байлаа гээд бичсэн байдаг. Яг л тийм байсан.

Одоо тэрүүгээр хавтгай бий юу?

Одоо байхгүй болсон. Одоо Сэгс Цагаан богд, Атас, Чигсээр урагшлаад, Ингэн Сэвстэй гээд байдаг болсон. Тийшээ урагшаа л жаахан явсан шиг байна. Урьд тэнд байдаггүй байсан.

Хавтгай тэмээг өөрөөр нэрлэж байна уу?

Бэсрэг тэмээ гэдэг.

Та бэсрэг тэмээний талаар хэр мэдэх вэ?

Зөндөө л байдаг. Яагаад бэсрэг тэмээ байдаг вэ гэхээр хавтгай чинь ороонд орж эхлэх үеэрээ томчуул нь зарим жижгийгээ хөөчихдөг байна. Гэтэл өнөөх нь явж байгаад монгол тэмээтэй таарч буурыг нь барьж хаячихаад эсвэл хөөж явуулчихаад ингийг нь хураачихдаг байна. Тэгж эрлийзэждэг. Түүнээс биш хурдан тэмээтэй болох гэж малчид аваачиж эрлийзжүүлээд байгаа юм байхгүй. Санаатай эрлийзжүүлээд байгаа юм бол тун бага. Ер нь бол их хахир хатуу тэгээд ноос багатай, яахав жаахан ахиу сүүтэй тийм л амьтан шүү дээ.

Сүү нь их өтгөн үү?

Энэ зэрлэг амьтад гэдэг чинь их сүүтэй байдаг юм байна. Тэгж байж үр төл нь сайн, чадалтай амьтан болдог байна.

Тэгж хахир амьтныг оролдож маллаж байхын оронд өөрийнхөө гарын доорхи тэмээгээ маллаж байсан нь дээр болов уу. Ер нь бол зөнгөөрөө л тэгж эрлийзэжсэн. Эрлийз гэхээр муу юм бас байдаг л байх. Ямар нэгэн юмны яс чанар мууддаг шиг. Хавтгай нь зэрлэг амьтан болохоор хурдан явахын тулд өндөр, зэгзгэр хөлтэй. Тэгээд багахан шиг хөнгөн биетэй, хурдан тэмээ байдаг.

Нэг хэсэг тэмээ уралддаггүй байлаа. Гэтэл сүүлдээ уралдах болоод л бэсрэг тэмээ тавьж уралдуулаад, түрүүлэх болсон. Одоо бол бэсрэг тэмээг тусад нь уралдуулна уу гэхээс биш хамт уралдуулахаа байсан.

Таны санаж байгаагаар тэмээн уралдаан анх хэзээ зохиогдсон бэ?

Суманд зохиогддог. Анх яг хэдийд зохиож эхэлснийг сайн мэдэхгүй байна. Ардчилал гараад л зохиож эхэлсэн болов уу.

Тэмээг өсгөж нэмэгдүүлэх бодлогын талаар?

Нэг хэсэг тэмээ жаахан цөөрөөд байсан. Хүнс хоолонд мах, шөл ихтэй гээд хүн бүр л авдаг байсан учир тэмээ их хоргодож байсан. Одоо бол тэмээний янз бүрийн уралдаанууд ихсэж

байна. Гоёл чимэг, өмсгөл зүүлттэй. Тэмээг бүр ботго торомноос нь шахуу нас насаар нь уралдуулдаг, адуу шиг болж.

Та тэмээний мах иддэг үү?

Тэмээний мах иддэг. 1956 онд сум байгуулагдах үед тэмээний мах иддэггүй байсан. Бүр тэмээний мах идсэн айлд ордоггүй байсан юм. *Тэмээний мах идсэн айл юм* гэнэ гээд ярилцдаг, ордоггүй байсан юм билээ.

Яагаад тэгдэг байсан юм бол?

Тэмээний мах идэж үзээгүй байснаас тэр байх. Хоёрдугаарт, тэмээний мах идэх шаардлага ч байгаагүй биз. 1960,70 онд нэгдэл байгуулагдаад мал ч цөөрсөн байх тэгээд идэх болсон байх. Тэмээний мах бол их сэрүүн чанартай. Тэр талаасаа ч болсон юм уу.

Танай суманд олон тэмээтэй айлууд бий юу?

300-аад тэмээтэй айл бий. Манайд аймгийн хамгийн олон тэмээтэй, гавьяат малчин айл Шинэнгийнх бий. Одоо 1000 гаруй тэмээтэй. Баянлиг сум бол аймгийн хамгийн олон тэмээтэй сум байх. Тэнд хоёр ч хөдөлмөрийн баатар бий. Сугар-Очир гээд нэг нь. Ер нь бол манай энэ хавь тэмээний зонхилох нутаг л даа. Богд сум бас байна.

Тэмээг уналга, эдэлгээнд хэр ашигладаг вэ?

Одоо багасч байна. Урьд нь элбэг байсан. Манай тэнд бол зун нь морио унаж, өвөл нь тэмээ унадаг. Өвөл бол морь унана гэж байхгүй. Тэгээд аян жинд явна.

Өвөл яагаад тэмээ их унадаг билээ?

Тэмээ илүү дулаахан, ноос, үс ихтэй, явдал сайтай. Яахав адуу жаахан цөөн учраас ч бас тэгдэг байсан байх. Манай тэндээс тэмээгээр Утай Гүмбэм, Цагаан эрэг, Хатгал, Хүрээ гээд л жин их тээж байлаа. Манай аав жин тээдэг хүн байсан. Хоёр, гурван 70 кг-ийн гурил, будаа ачаад л явдаг байсан байх.

Бэсрэг тэмээг жинд хэрэглэж байсан болов уу?

Байгаагүй байх аа.

Тэмээ багасч байгаагийн нэг шалтгаан бол тэмээний хэрэглээ багассантай холбоотой. Урд нь машин тэрэг байгаагүй учраас тэмээгээр л нүүдэг байсан. Хааяа үхэр ачдаг байсан байх. Сарлаг цөөхөн байсан ч хааяа ачдаг байсан юм гэдэг.

Танайд сарлаг байсан гэж үү? Говь газар сарлаг байсан гэхээр?

Манай тэнд чинь тэрүүхэндээ бас их уултай. Тэр хавиараа л байсан байх. Баян-Энгэрийн зоо энэ тэрд бололцоотой. Манайх хэдэн сарлагтай байсан. Сарлагийг аччихаар хөтөлнө гэж байдаггүй. Ачаад тавьчихаар өөрөө явдаг байсан.

Танайд зориудаар ч байдаг юм уу зэрлэг амьтан барьж аваад гэрийн амьтантай эрлийзжүүлэх зүйл гарч байсан уу? Аргаль, угалз ч юм уу?

Манайд тийм юм ховор байсан байх. Бүр дээхэн үед манай хөгшчүүл ярьдаг л байсан. Хавтгайг сургаж унах гэж байсан. Хуланг сургаж унах гэж байсан гэх мэтчилэн юмнууд дуулддаг. Хавтгай, хулан бол аль аль нь их яхир амьтад. Яг уначихаар ухраад явдаггүй. Хавтгай бол байгаа газартаа л явна. Өөр газар руу бас явдаггүй.

Хавтгай тэмээ тэгэхээр хүнд баригддаг байх нь ээ?

Баригдалгүй яахав. Тэгэхдээ уналга эдэлгээнд оруулчихсан юм гэж байсан үгүйг мэдэхгүй. Байхгүй байх. Зүгээр туршиж үзсэн юмнууд бол байдаг.

Манайд ховордсон зургаан амьтад байсан. Тахь, хавтгай, мазаалай, хулан, хар сүүлт, соргог бөхөн гэдэг ч юм уу. Тахь нь утсан, соргог бөхөн утсан. Мазаалай устгах гэж байна.

Зэрлэг амьтад сэлгэлт, нүүдэл бас хийж байх шиг?

Тэр бол амьтдын буруу биш л дээ. Хүмүүс очоод суурьшаад, чимээ шуугиан гараад байхаар дайжиж байна. Тэгээ л хавтгай Цагаан богдын ар руу очиж тогтсон байх. Тэгээд наанаас нь уул уурхайнхан очоод шахчихсан, замгүй л болсон байх.

Та хавтгайн мах идэж үзсэн үү?

Үзээгүй. Дээр үед бол улсууд агнадаг л байсан. Нэгдэл нийгмийн үед мал цөөтэй хэцүү л байсан. Мал мах тоо хэмжээтэй ч байлаа, махны бичиг авдаг. Тийм нэг үед ан хийж л амьдарч байсан байгаа. Иддэг ургамал нь ижил учир махны амт нь адилхан л байх. Хавтгай, тэмээ хоёр адилхан л юм идэж байгаа шүү дээ. Тэмээ бол их л шорвог юм иддэг. Манайхруу хужир ихтэй.

***Чимбэгийн Сугар-Очир. Баянхонгор аймгийн Баянлиг сумын харьяат, 67н, эр, өөлд.***

Тө өөрийнхөө талаар товч танилцуулна уу?

Би Баянхонгор аймгийн Баянлиг сумын харьяат, Монгол Улсын хөдөлмөрийн баатар Чимбэгийн Сугар-Очир гэдэг хүн байна.

Та нас сүүдэр хэд хүрч байна?

70 дөхөж явна. 1956 онд төрсөн.

Баянлиг сумын хэддүгээр баг вэ?

Тавдугаар баг.

Та ямар ургийн овогтой вэ?

Өөлд.

Та одоо ямар төрлийн мал маллаж байна вэ?

Голдуу тэмээ маллаж байна. Тэмээчин хүн. Одоо хүүхдүүд тэмээн дээр байна.

Одоо танайх хэд орчим тэмээтэй вэ?

200 гаруй тэмээтэй. Хүүхдүүддээ тэмээгээ хувааж өгсөн.

Яагаад тэмээ өсгөж, үржүүлэх болсон бэ?

Насаараа л тэмээ өсгөлөө.

Тэмээ өсгөх болсон гол шалтгаан юу байсан бэ?

Амьдралын шаардлага байсан. Мөн таван хошуу малаас хамгийн тэсвэртэй мал нь тэмээ байдаг. Тэгээд бас монголд хамгийн их цөөрч байгаа мал бол хоёр бөхтэй тэмээ байдаг.

Та хэдэн жил мал маллаж байна вэ?

Насаараа л мал маллаж байна.

Таны аав бас тэмээ хариулдаг байсан уу?

Тэмээчин хүн байсан. Би удам залгасан тэмээчин хүн. Гурав дахь үеийн тэмээчин.

Таны тэмээнүүд дунд онцгойлж хайрладаг тэмээ бий юу? Нэр өгдөг үү?

Байдаг. Тэмээнүүд маань цугаараа нэртэй.

Эхнэр: Одоо ингэ сааж байгаад хав харанхуй юу ч үзэгдэхгүй болчих үед ботгоны зэлэн дээр очоод эхийн нэрээр нь дуудахад ботго нь буйлаад босоод ирдэг. Тэгэхээр тэмээ өөрийнхөө нэрийг цээжилчихдэг ухаантай амьтан. Жишээ нь “Өндөр хүрэн” гэж ингэ байвал хөөс, хөөс Өндөр хүрэн гээд дуудвал ботго нь буйлаад босоод ирдэг.

Танай нутагт тэмээндээ өгдөг нэрийн хувьд онцлог шинж байдаг уу?

Тэмээнийхээ донжийг харж байгаад хэлбэр, зүс, зан араншин зэргээр нь харж байгаад нэрлэдэг. “Гүзээ бор”, “халтар ингэ”, “орилоо шар”, “өндөр хүрэн” гэх нэртэй тэмээд бий.

Хавтгай тэмээний талаар та хэр мэдэх вэ?

Хавтгай тэмээ бий. Манайхны тэмээтэй эрлийзжэх зүйл бий. Цусыг нь сайжруулж байсан. Гэхдээ муу, дутагдалтай тал нь их ярдаг юм билээ. Зан ааш нь их зэрлэгдүү маягийн юм билээ. Амьдрах чадвар монгол тэмээнээс хавьгүй илүү болов уу.

Эхнэр: хол газар унаж явахад хавтгай сайн. Монгол тэмээ бол хол газар явахад хэвтээд өглөө гэхэд нөгөөдөх нь бол яваа л байдаг. Сүү их сайтай. Хавтгайн ингэний сүү шал (цагаандуу хатуу газар)-н дээр байхад нь авч хэрэглэж байсан удаа бий гэдэг. Тэгэхээр өтгөн их байна гэсэн үг. Ботго нь хөхөж байхад л хажуугаар нь дуссан байна гэж бодохоор. Зарим хавтгайн эрлийз ингэнээс 5 литр сүү гарах нь бий.

Танай тэмээн сүрэгт хавтгайн буур орж байсан уу?

Эхнэр: Орж л байсан. Манай том хүү ингэ хураах гээд явсан чинь дотор нь нэг хөөрхөн шар амьтан байна гэсэн. Тэгсэн хавтгай байж. Ингээ хураагаад явтал ард нь буйлаа л хоцорсон гэдэг. Нэг ингэ тасалчихсан байсан, тэрийгээ дагаа л яваад байсан гэсэн.

Манай нөхрийг худгаас тэмээ услаад байж байхад хажуугаар нь нэг хавтгай ирээд ус ууж байна гэсэн. Манайх усаа мотор асааж, ховоогоор усаа татдаг. Тэгээд толгой дээр нь гараа тавихад хөөрхөн байгаад байсан гэсэн. Зэрлэг тэмээ нэг жил болоход хүнд дасчихдаг юм билээ. Манай тэнд хавтгай сургасан нэг хүн байдаг байсан. Хээр явж байгаад тийм тэмээтэй таараад сахар өгөхөөр идчихдэг байсан гэсэн яриа байдаг. Тэр хүн одоо алга даа зайлуул.

Хавтгай тэмээ хурдан уу?

Эрлийз нь бол хурдан. Цусыг нь л сайжруулдаг юм л даа. Тавдугаар үеэсээ их хурдан болдог. Харахад хамгийн чанарждаг үе тавдугаар үе.

Эхний үе дээрээ эрлийз тэмээ хурдан биш гэсэн үг үү?

Их ярдаг байдаг. Нэг ширүүхэн гуядчихад л халдчих гээд байдаг.

Та тэмээн уралдаанд оролцож байсан уу?

Оролцож байсан.

Ямар амжилт үзүүлж байв?

Би их хурдан тэмээдтэй байсан хүн.

Тэр тэмээнүүд дотор бэсрэг (эрлийз) тэмээ байсан уу?

Дан монгол тэмээ байсан. Тэгэхэд эрлийз байдаггүй байлаа.

Эхнэр: Сүүлд харин эрлийзээс түрүүлдэг нэг сайхан тэмээ байсан. Олон түрүүлсэн.

Хэдэн оноос хойш тэмээн уралдаанд бэсрэг тэмээ оролцдог болов?

Эхнэр: 1990 оноос хойш болов уу.

Тэмээн уралдаан ер нь анх хэзээнээс зохиогдож эхэлсэн бэ? 1990 оноос хойш уу?

Үгүй, бүр дээр үеэс л цагаан сарын үеэр айл хэсэж уралддаг байсан. Тэр үеэр л аль хурдан тэмээгээ барьж, сойж байгаад л уралдчихдаг байсан.

Малчны баяраар уу?

Яг тийм. Эхлээд айлаар уралддаг байсан, дараа нь төр захиргаанаас уралдуулдаг болсон.

Тэр уралдаанд оролцож байгаа бэсрэгүүд ямар учиртай юм бэ?

Хавтгайн буур л монгол ингэнд орсон гэсэн үг шүү дээ. Эрлийз, хурлийз болоо л цааш нь үргэлжилнэ гэсэн үг. Хурлийз болоод ирэхээрээ монгол тэмээнээс огт ялгагдахааргүй болчихдог.

Бэсрэг тэмээг өөрөөр нэрлэдэг үү?

Эрлийз тэмээ л гэх байх даа.

Бэсрэг тэмээний сул тал өөр юу байдаг вэ?

Ярдаг л байдаг. Ноос бас шингэхэн, их муу.

Танай нутагт одоо тэмээний мах хэрэглэдэг үү?

Хэрэглэдэг.

Урьд нь хэрэглэдэг байсан болов уу?

Эхнэр: Бүр түрүүхэн үедээ бол гайгүй л байсан байх. Тэмээ оролцсон айлаас тойрч зугатдаг байсан юм гэдэг. Одоо гэтэл тэмээ бол гол идэш нь тэмээ болсон. Арван богний дайтай байдаг болохоор дээр нь бас өөх тос сайтай байдаг болохоор тэмээ хэрэглэхгүй бол хэцүү болсон шүү дээ манай говийнхон.

Тэмээний мах, хавтгайн мах хоёр ялгаатай байдаг болов уу?

Мэдэхгүй байна. Арай л махлагдуу байдаг болов уу.

Та цаашид өөрийнхөө сүрэгтээ бэсрэг тэмээг нэмэгдүүлэх, өсгөх тухай боддог уу?

Хурдан болохоор нь эрлийзжүүлж авч байсан юм бий.

Зориудаар шууд эрлийзжүүлж байсан уу?

Дамжуулж л эрлийзжүүлж байсан.

Зориудаар хавтгайн буурьтай эрлийзжүүлэх боломж хэр байдаг вэ?

Ер нь ховор доо. Монгол буурыг бол барьж хаячихаад ингийг нь хураачихдаг юм гэсэн, овоо шүү дээ.

Эхнэр: Эрлийзжүүлэхээр бөх жижигтэй болдог.

Тэмээтэй холбоотой зан заншлын талаар та хоёр хэр мэдэх вэ?

Тэмээ бол их гойд ухаантай амьтан шүү дээ. Ямар ч шороон шуурга нүдэж байсан гэсэн ард нь сөргөж явсаар хотондоо ирдэг амьтан. Лав л төөрнө гэсэн ойлголт байдаггүй амьтан.

Тэмээ бол уруудна гэж байдаггүй.

Гүнжлхамын талаар дуулж байв уу?

Мэдэхгүй. Тэмээгээ л шүтдэг улс.

Танайд тэмээтэй холбоотой тахидаг овоо, уул бий юу?

Мэдэхгүй.

Холбоотой ном, судар мэдэх үү?

Эхнэр: Хатан суудал уулыг тэмээтэй холбоотой гэж сонссон. Тэрийг тахьдаг байсан хүн нь лав тэмээгээр очиж тахидаг байсан юм гэж дуулсан. Тэмээ малын өвчин зэрэг талаас нь тахидаг байсан юм гэсэн. *Жаран жаран жилийн өмнөөс тахиж байсан юм* гэнэ билээ гэж ярьдаг.

Тэмээ малтай холбоотой янз бүрийн зүйр үг, аман домог, хууч хэр мэдэх вэ?

Мэдэхгүй.

Тэмээг оршуулгад хэрэглэдэг тухай та юу мэдэх вэ?

Эхнэр: Дээр үед тэмээн дээр хана тавьж байгаад аваад явдаг байсан гэдэг. *Тэмээг буурин дээр хэвтүүлдэггүй* юм гэдэг. Буурин дээр гишгүүлчихэв гэж ярьдаг байсан.

Оршуулгын үед нэг талд нь заг ачна говь учраас, нөгөө талд нь эсгийгээр бүтээгээд, ороогоод авч явж байсан юм гэдэг, тэнг нь тэнцүүлээд.

Танай тэмээг сэтэрлэдэг үү?

Сэтэрлэнэ. Манайх нэг тайлаг сэтэрлэж байсан.

Ямар үед сэтэрлэдэг вэ?

Хүн тавьсаны дараа сэтэрлэдэг байсан юм гэдэг.

Тэмээ сэтэрлэхэд өнгө, зүс заадаг уу? Танайд эрхэмлэдэг тэмээний зүс юу байдаг вэ?

Эхнэр: Манайд Ламын гэгээний улаан тэмээ гэж домогтой.

Ламын гэгээний улаан тэмээний талаар ярьж өгөөч?

Зоо нуруу сайтай, ачаа даахдаа сайн тэмээ гэдэг.

Эхнэр: Тэр тэмээ нь ачаанд их сайн тэмээ юм гэдэг. Хэцийн хүрэн тэмээний ачааг ачаад дээр нь өөрийнхөө ачааг давхар ачаад явах хэмжээний хүч тэнхээтэй гэдэг. Дархлаа сайтай.



Аян жинд явахад их хэрэглэгддэг тэмээ юм. Тэмээ жинд явахад их үүрэглэдэг. Харин тэр тэмээд бол ерөөсөө үүрэглэдэггүй гэдэг. Тэсвэртэй.

Манай аав тэр тэмээнд Улаанбаатар хотоос түүхий эдийн ачаа ачаад Хөх хотруу оруулаад, тэндээсээ бараа ачаад Улаанбаатар хот ордог. Тэгж явахдаа гэрээрээ нэг дайрвал дайраад, хонуул хонож өнжөөд явж байдаг тийм хүн байсан юм гэсэн. Миний аав 16 наснаасаа жин тээсэн хүн.

Таны аав хэдэн оны үед амьдарч байсан хүн бэ?

Эхнэр: Манай аав 1915 оны хүн.

Таны алдар хэн бэ?

Эхнэр: Намайг Рэндоогийн Нансал гэдэг.

Таны ургийн овог юу вэ?

Халанхай.

Энэ ямар учиртай овог вэ?

Манай аавын аавын л удам юм шиг байгаа юм.

Танай нутагт “мөнгөн буйл” авсан хүн байдаг болов уу?

Манайх “Улаач нэгдэл” гэж байх үедээ нэгдлээрээ “мөнгөн буйл” авч байсан. Бас “алтан гадас” одонт гэдэг.

Танайхаас алтан ботгоны эзэн гэж тодорсон уу?

“Алтан ботго”-ны эзнээр хамгийн анх би тодроод надаас хойш дөрөв тодорсон.

“Алтан ботго”-ыг ямар хүнд өгдөг вэ?

Олон жил олон ботго бойжуулсан хүнд өгдөг.

“Мөнгөн буйл”-ыг ямар хүнд өгдөг вэ?

Олон жил тогтвортой тэмээ өсгөсөн хүнд өгдөг. Манай сум бол тэмээгээрээ гуравт ордог.

Тэмээний үнэ ханш одоо ямар байгаа вэ?

Бүдүүн тэмээ бол хоёр сая (2.000.000)-тай байгаа. Тором бол таваас зургаан зуун мянга (500.000-600.000) орчимтой байна.

Цаашид тэмээний хэрэглээ ер нь нэмэгдэх болов уу?

Нэмэгдэж магадгүй.

Орсон буур аюултай амьтан уу?

Аюултай. Галзуурсан л амьтан гэсэн үг. Гэхдээ зан аашаасаа болдог. Зарим тэмээ гайгүй.

Тэмээнээс дунджаар хэдэн кг ноос гардаг вэ?

Дунджаар 5 кг ноос гардаг.

Хавтгайны ноос их бага гарах байхдаа?

Бага гардаг. Гэхдээ шигүү юм уу, ямар учиртай юм хүнд байдаг. 3 кг орчим байдаг болов уу.

Тэмээнээс өөр тийм хээрийн зэрлэг амьтантай (аргаль, угалз, хулан, тахь) үржилд ордог амьтад байдаг уу?

Тэмээний бүтээгдэхүүнийг их эрүүл мэндэд сайн гэдэг болж. Хятадад нэг ингэний ферм байгуулсан. Тэнд ингэний хоормог дээр ёстой оочёрлож байна гэж дуулсан. Ингэний хоормогийг дархлаанд сайн гэдэг. Буурны заарыг бас сайн гэдэг.

Буурны заарыг яаж авдаг юм бэ?

Буурны заарыг одоо бол арай өөр авна. Дээр үед бол хайчлаад авдаг байсан.

Буурны заарыг юунд хэрэглэдэг вэ?

Заарыг шарханд хэрэглэдэг. Дээр үед цагаан буурын заарыг эмэгтэй хүн хэрэглэдэг байсан.

Хавдарт л хэрэглэж байх шиг байна. Хавдарыг бол сайн бариад байдаг.

Тэмээний талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа дэмжлэг байдаг уу?  
Малын хөлийн мөнгөнөөс хасаад байсан. Өмнөговьд бол нэг ботго 5 мянган төгрөг болдог гэсэн. 100 ботго бойжуулсан хүн хэд ч болдог юм.  
Өмнөговийн Мандал-Овоо сумд түмэн тэмээний баяр хийсэн юм гэсэн. Манай Баянхонгор тэмээний баяраа бас Шинэжинстэд хийх юм шиг байна.  
Тэмээний ноосоор юу, юу хийдэг вэ?  
Тэмээний ноосоор ботгоны зэл, оосор, чагт, гэрийн оосор, бүч гээд хийхгүй юм байхгүй.  
Та өөрөө энэ бүгдийг хийдэг үү?  
Бүгдийг нь хийнэ. Нэг хошлон томчиход чөлөөтэй 7 жил болдог. Одоо ширмэл ширэхээ больсон. Тэмээн утсаар оёсон юм их бөх бат болдог. Гэрийн дээвэр туургыг тэмээн утсаар л оёдог. Тэгэх юм бол адаглаад тасрахгүй, сэтрэхгүй.

Би ХАА-н чиглэлээр 20 жил тасарч байгаад болсон анхны хөдөлмөрийн баатар юм. Надаас хойно дахиад манай нутгийн нэг хүн хөдөлмөрийн баатар болсон. Тэр бид хоёр хамаатан улсууд.

***Готовын Тойвгоо. Баянхонгор аймгийн Баянлиг сумын харьяат, 70н, эр, “алдар” овогтой. Тарав хэмээх газраар нутаглаж байгаа.***

Таны алдар нэр хэн бэ?  
Готовын Тойвгоо.  
Хэдэн настай вэ?  
70 настай, 1953 онд төрсөн.  
Таны ургийн овог юу вэ?  
“Алдар” овогтой.  
Энэ сүүлд авсан овог уу?  
Ургийн овог тогтоох үед л авсан овог.  
Таны яг одоо амьдарч байгаа газрын нэр юу вэ?  
Би Баянхонгор аймгийн Баянлиг сумын хөдөө 2 дугаар багийн нутагт амьдарч байна.  
Танай өвөлжөөний нэр юу вэ?  
“Тарав” гэдэг газар.  
Та яг ямар мал малладаг вэ?  
Надад үхрээс бусад нь байгаа.  
Үхэр маллахгүй байгаа шалтгаан нь бэлчээрээс болж байна уу?  
Нутаг нь таардаггүй юм.  
Та одоо хичнээн тэмээтэй вэ?  
580 гаруй тэмээтэй.  
Тэмээ өсгөх болсон шалтгаан тань юу байсан бэ?  
Нутаг ус, бэлчээрээс л болсон. Тэмээ ер нь говьдоо л зохицсон амьтан.  
Та хэдэн жил мал маллаж байна вэ?  
Насаараа л мал маллаж байна.  
Таны өвөг дээдсүүд бас л мал маллаж байсан улсууд уу?  
Тийм ээ.  
Танд онцгойлж хайрладаг тэмээ байдаг байх?  
Байдаг.

Тэмээндээ нэр өгдөг үү?  
Өгнө өө. Алийг нь тэр гэх вэ.  
Хавтгай тэмээний талаар та хэр мэдэх вэ?  
Мэдэхгүй. Баян-Өндөрийн говьруу л байдаг байх.  
Та хавтгай гэх амьтан үзсэн үү?  
Телевизээр харж байсан.  
Та тэмээн уралдаанд хэр оролцож байсан бэ?  
Оролцож л байсан.  
Танай мал сүрэгт бэсрэг тэмээ байдаг уу?  
Байхгүй.  
Бэсрэг тэмээний онцлог ямар байдаг гэж та боддог вэ?  
Унаж эдлэх, уралдахад арай чадал тэнхээтэй байдаг юм уу даа. Их сүүтэй байдаг юм гэсэн.  
Бэсрэг тэмээ ямар байдлаар үүсдэг вэ?  
Хавтгай тэмээний буур өөрөө ирж монгол буурыг хөөгөөд ингэнд нь орчихдог юм билээ.  
Хавтгай чадалтай байгаа л даа. Эрлийжжүүлэх шаардлагагүй юм гэсэн. Их ааш муутай,  
адайр, зожиг тийм амьтан гэдэг.  
Ач холбогдолтой тал байдаг болов уу?  
Хурд хүч л байдаг байх.  
Та тэмээтэй холбоотой зан заншил хэр мэдэх вэ?  
Байдаг л байх.  
Та гүнжлхам гэж дуулсан уу?  
Мэдэхгүй.  
Тэмээтэй холбоотой ном судар, тарни мэдэх үү?  
Манайд тийм юм байдаггүй.  
Та тэмээтэй холбоотой аман хууч, домог сонсож байсан уу?  
Байхгүй.  
Тэмээг оршуулгын зан үйлд хэрэглэдэг байсан эсэх талаар та юу мэдэх вэ?  
Машин техникгүй байхад хэрэглэдэг байсан. Одоо бол тийм юм мэдэхгүй.  
Та тэмээн жингийн талаар юу мэдэх вэ?  
Мэдэхгүй. Би жинд явж байгаагүй.  
Ачлаганы үеийн тэмээний зохион байгуулалт ямар байдаг вэ?  
Ачдаг номхон тэмээ гэж бас тусдаа байна. Олон дахин хэрэглэж байж дадлагажина.  
Зэрлэг тэмээнээс өөр бусад зэрлэг амьтад хотонд орж ирэх тохиолдол бий юу?  
Хааяа нэг зэрлэг амьтад тэжээсэн тохиолдол байдаг. Харин өөрсдөө орж ирдэг үгүйг нь  
мэдэхгүй.  
“Алтан ботго”, “алтан төл” гэж нэг зүйлийг хэлээд байна уу?  
Тийм.  
Төрөөс тэмээтэй холбоотой өөр олгодог дэмжлэг, шагнал урамшуулал байдаг уу?  
“Улсын аварга”, “Хөдөлмөрийн баатар”, “Гавьяат малчин” гэх зэргээр урамшуулдаг зүйл  
байна.  
Орсон буур аюултай амьтан гэдэг?  
Тухайн тэмээний ааш зангаасаа л болно. Явган хүнд ч дургүүддэг буур бий.  
Танайд орсон бууранд өртөж, гэмтэж байсан тохиолдол байдаг уу?  
Байдаг юм билээ.  
Хүний амь насанд хүрэх үү?

Хүрдэг юм гэсэн. Хэд хоногоор сахиад хэвтдэг буур ч байсан юм гэсэн. Бууранд хөөгдөөд нүхэнд орж хэвтээд хэд хонож байсан хүн байсан юм гэдэг.

Энэ танай нутагт болсон зүйл үү?

Яг энэ тэр гэдгийг нь мэдэхгүй. Тийм л домог шиг юм яригддаг. Орсон бууранд идүүлсэн тохиолдол байсан.

Орсон буурыг унаж болдог уу?

Зан сайтай буурыг унаж л байдаг юм. Гэхдээ буур бол хамаагүй унахаар амьтан биш ээ. Орсон буурыг номхон гэдэггүй.

Тэмээ, ингэ, буур гэх зэрэг нэр орсон газрын нэр мэдэх үү?

“Цагаан буур хайрхан” л гэж Өмнөговь, Баянхонгорын зааг дээр нэг газар бий. Цагаан буур хайрханыг тэмээний эцэг гэж нэрлэдэг л юм гэсэн.

Тэр тахилгатай хайрхан уу?

Үгүй болов уу.

Тэмээнд холбогдох ямар эд хэрэглэлүүд байдаг вэ?

Буйл, бурантаг, ногт, хом, ороолт, шат гээд л бий. Тэгээд тохош, тогч гэх зэрэг.

Тогч гэж юуг нь хэлж байна вэ?

Тохом.

Тэмээнээс ер нь хэр хэмжээний ноос гардаг вэ?

Ингэ арай байга. Дунджаар 5 кг гаруй байдаг. Тэгээд дээд тал нь 10 гаруй кг болоод л явчихдаг.

Тэмээний ноосоор ямар нэгэн эд зүйл хийдэг үү?

Зангилаа, ногт гээд арай нарийхан утас хийгээд л түүгээрээ янз бүрийн юм хийдэг.

Тэмээний сүү цагаан идээ өргөн дэлгэр хэрэглэж байна уу?

Тэгж байна. Тэмээний сүүн идээг их хэрэгтэй гэж хүмүүс сонирхдог болж. Эмчилгээ, эмийн журмаар шахуу хэрэглэж байх шиг. Ингэний сүү ундаа ууж байгаад төрсөн хүний хүүхэд лав шарлахгүй байна гэнэ. Хүүхдийн шар гэж нэг юм байдаг. Ядаргаанд сайн л гэнэ.

Сүүлийн үед ингэж яригдаж байна уу? Урьд нь ч ийм байсан уу?

Сүүлийн үед шар өвчин гэж гарснаас хойш ингээд байна. Түүрүүхэн бол яахав ядаргаанд сайн гээд уудаг л байсан.

Танайхан тэмээний мах иддэг үү?

Иддэг.

Урьд нь тэмээний мах иддэг байсан болов уу?

1950 хэдэн оны үеэс л тэмээ идэж эхэлсэн шиг байдаг юм. Түүнээс өмнө иддэггүй байсан юм гэдэг. Үхэр, бог мал, цагаан идээгээр голцуухан байсан гэдэг. Миний мэдэхийн 50 хэдэн оноос л тэмээ алж эхэлсэн юм билээ. Тэмээ алдаг хүн олдохгүй, ганц хоёр хүн гуйгаа л явдаг байсан гэдэг.

Одоо бол тэмээ гаргадаг хүн наад захаасаа биз дээ?

Тэгнэ. Төвлөрсөн төлөвлөгөөтийн үед бас алж гадагшаа дотогшоо явуулдаг байсан байх.

Тэмээний үнэ ханш ямар байна вэ?

Сайн тэмээ 2 саятай, ингэн тэмээ 1 сая 500-тай, бага тэмээнүүд нь өшөө доош ботго гэхэд л 500 мянга байх жишээтэй л байна. Тэмээ бас тарга тэвээргээсээ болно.

Тэмээний хэрэглээ ямар байна?

Тэмээг бас тал тал тийш авч байна шүү. Тэмээ цөөтэй газрууд ч сонирхдог юм шиг байна.

Тэмээний ашиг тус бас багагүй болохоор тэр байх.

Тэмээ малд эрхэмлэдэг өнгө зүс гэж байдаг уу?

Цагаан тэмээг жаахан чанар муутай, салга гэдэг.

Танайх ламын гэгээний улаан тэмээ юу?

Тийм.

Бусад тэмээнүүдээсээ онцлог нь юу байдаг вэ?

Манайх одоо шилдэг үүлдэр болгох гээд л яваад байгаа. Бусад тэмээнээсээ арай илүү ноосорхог, сүүтэй гэдэг. Дээр үед бол хүч чадал сайтай байсан юм гэсэн.

Яагаад ламын гэгээний улаан тэмээ гэж ярьдаг байсан бэ?

Ламын гэгээний жасад л байсан тэмээ юм гэдэг.

Танайд ямар зүсмийн тэмээг ягаан зүсмийн тэмээ гээд байна вэ?

Арай улаан биш бас шар биш тэр хоёрын завсрын өнгөтэй тэмээг ягаан зүсмийн тэмээ гэдэг.

Танайд цагаан зүсмийн адууг ямар өнгөтэй гэж хэлдэг вэ? Зарим газар бор гэж хэлдэг?

Цагаан л гэнэ. Тэмээ бол цагаан өнгө гардаггүй. Хар саарал ч юм уу өнгөтэй гардаг. Тэгээд дараа нь цэнхэр энэ тэр болж бүдгэрсээр байгаа л цагаан болдог.

Та цаашид тэмээгээ өсгөж хариулья гэж бодож байна уу?

Бодолгүй яахав. Одоо миний хувьд бол маллаад байх чадал тэнхээгүй боллоо. Залгамжилсан хүүхдүүд л авах байх.

Танайд тэмээ малладаг улсуудаас хамгийн өндөр настай нь ямар хүмүүс байдаг вэ? Хаагуур нутаглаж байна?

Миний ойролцоо Аюушийн Нэргүй гэж 80 гаруй настай нэг өвгөн бий. Тэр насаараа л тэмээ малласан хүн.